

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 18
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	19 – 133
1. <i>Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.</i>	20 – 21
2. <i>Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/</i>	21 – 23
3. <i>Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	24 – 51
4. <i>Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	51 – 55
5. <i>Хуулийн төслүүдийг эцэслэн батална.</i>	55 – 58
6. <i>Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	58 – 133

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны
ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Т.Доржханд, Ч.Номин, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин;

Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Баярмаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу, П.Мөнхтулга, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, Б.Түвшин;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: О.Алтангэрэл – 37 минут, Н.Алтанхуяг – 12 минут, Ч.Анар – 05 минут, Б.Батбаатар – 3 цаг 59 минут, Д.Батбаяр – 07 минут, Д.Батлут – 02 минут, Н.Батсүмбэрэл – 01 минут, Б.Батцэцэг – 03 минут, Ж.Бат-Эрдэнэ – 08 минут, Ж.Баясгалан – 02 минут, Х.Булгантуяа – 18 минут, А.Ганбаатар – 01 минут, Г.Ганбаатар – 03 минут, С.Ганбаатар – 08 минут, Д.Ганбат – 42 минут, Г.Дамдинням – 01 минут, Х.Жангабыл – 1 цаг 22 минут, Т.Мөнхсайхан – 05 минут, З.Мэндсайхан – 05 минут, М.Нарантуяа-Нара – 04 минут, С.Одонтуяа – 04 минут, Б.Пунсалмаа – 27 минут, Д.Пүрэвдаваа – 01 минут, Ц.Туваан – 02 минут, Б.Тулга – 04 минут, Г.Тэмүүлэн – 05 минут, Ж.Чинбүрэн – 28 минут, Ж.Энхбаяр – 2 цаг 41 минут, Л.Энхнасан – 01 минут, Л.Энхтуяа – 12 минут, Р.Эрдэнэбүрэн – 04 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын тэргүүн, Монгол Улсын гадаад харилцааг өргөжүүлэн олон улс дахь байр суурийг бэхжүүлсэн Монголын ард түмний эрхэм хүмүүн Пунсалмаагийн Очирбат 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 83 насандаа өвчний учир таалал төгсөж, Монгол төр, Монголын ард түмэнд хүнд гарз тохиолоо.

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Пунсалмаагийн Очирбатын гэгээн дурсгалыг хүндэтгэж, хуралдааны танхимд оролцогсдыг босож, эмгэнэл илэрхийлнэ үү хэмээн хүсэв.

Улсын Их Хурлын гишүүд болон хуралдаанд оролцогсод 1 минут босож, эмгэнэл илэрхийлж, хүндэтгэл үзүүлэв.

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Д.Амарбаясгалан: Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 27

Бүгд: 82

67.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, “Монгол газрын тос боловсруулах

үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 28
Бүгд: 86
67.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 26
Бүгд: 88
70.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 21
Бүгд: 88
76.1 хувь буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, П.Сайнзориг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 78.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх Б.Энхсайхан, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Мэдээлэл, харилцаа холбооны инженер М.Отгонбат, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Э.Баттогтох, Хуулийн газрын ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Эрдэнэболд, С.Эрдэнэбат, Д.Ганмаа, Л.Энхнасан, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж нар хариулж, тайлбар хийв.

ХАРХОРУМ ХОТЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж, дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн боловсруулсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус батална.

7.3.Засгийн газар хотод хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн жагсаалтыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батална.

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр, барилгажилтын төслийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хотын Зөвлөл тус тус батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Ж.Бат-Эрдэнэ, С.Замира, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 53
Бүгд: 95
44.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.2 дахь хэсэг болгох:

“17.2.Энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 53
Бүгд: 95
44.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 49
Бүгд: 95
48.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Д.Амарбаясгалан: 3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний өмнө “иргэн,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 45
Бүгд: 95
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5.13 дахь заалтын “өмчийн болон” гэснийг мөн заалтын “удирдлагыг томилох, чөлөөлөх,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 41
Бүгд: 95
56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Л.Мөнхбаясгалан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 58.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5 дахь хэсгийн “эзэмших” гэснийг тус тус хасах.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 44

Бүгд: 95

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**“ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 2, 3 дахь заалтыг хасаж, 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуультай нийцүүлэхээр Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 39

Бүгд: 95

59.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Байнгын хорооноос боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх Б.Энхсайхан, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын

ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Мэдээлэл, харилцаа холбооны инженер М.Отгонбат, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Э.Баттогтох, Хуулийн газрын ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 38

Бүгд: 96

60.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй хамт батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хуулийн төслүүдийг эцэслэн батална

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Э.Баттогтох, Хуулийн газрын ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Хархорум хотын төлөвлөлт бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 31
Бүгд: 96
67.7 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, З.Мэндсайхан, Д.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.8 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/-ийг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 29
Бүгд: 96
69.8 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 31
Бүгд: 96
67.7 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

4. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 28
Бүгд: 96
70.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

5. “Хархорум” хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 27
Бүгд: 96
71.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

6. “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 31
Бүгд: 96
67.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

7. “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 34
Бүгд: 96
64.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

8. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 33
Бүгд: 96
65.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 28
Бүгд: 96
70.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

10. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 25
Бүгд: 96
74.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хууль, тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 11 цаг 50 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Ганбат, Б.Хулан, М.Цэлмүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Саруул, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч Б.Төрбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга Ц.Тэгшжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Монгол

Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор Г.Давааням, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Ерөнхий аудитор О.Баярмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, П.Амаржаргал, Ж.Бямбадулам, Н.Мөнхзэсэм, Ж.Сайнхишиг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Д.Энхтүвшин, Б.Мөнхсоёл, Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, О.Батнайрамдал, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, Б.Жаргалан, С.Эрдэнэбат, Ө.Шижир, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, Б.Энхбаяр, Ж.Золжаргал, Ж.Баясгалан, Г.Ганбаатар, Д.Батбаяр, Д.Энхтуяа, Х.Булгантуяа, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цолмон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Ерөнхий аудитор О.Баярмагнай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 36

Бүгд: 97

62.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Энхбаяр, Н.Батсүмбэрэл, Д.Энхтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 38

Бүгд: 97

60.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 40

Бүгд: 97

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 34

Бүгд: 97

64.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 33

Бүгд: 97

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 32

Бүгд: 97

67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97

67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 30
Бүгд: 97

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 31
Бүгд: 97
68.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97
66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 31

Бүгд: 97

68.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 29

Бүгд: 97

70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 30

Бүгд: 97

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 28

Бүгд: 97

71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 29

Бүгд: 97

70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 56 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 100 гишүүн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 17 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая.

66 гишүүн буюу 52.4 хувьтай ирц бүрдсэн тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье. /алх цохив/

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын тэргүүн, Монгол Улсын гадаад харилцааг өргөжүүлэн олон улс дахь байр суурийг бэхжүүлсэн Монголын ард түмний эрхэм хүмүүн Пунсалмаагийн Очирбат 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 83 насандаа өвчний учир таалал төгсөж, Монгол төр, Монголын ард түмэнд хүнд гарз тохиолоо.

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Пунсалмаагийн Очирбатын гэгээн дурсгалыг хүндэтгэж босож, эмгэнэл илэрхийлэхийг хүсэж байна. /Улсын Их Хурлын гишүүд 1 минут босож зогсож хүндэтгэл үзүүлэв/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 8 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Дөрөвдүгээрт, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Зургадугаарт, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Долдугаарт, “Нийслэл Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг
яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ**

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар

яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

55 гишүүн буюу 67.1 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Монгол Улсын Засгийн газар болон
Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын
Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах,
үргэлжилнэ/**

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ч.Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Алтанцэцэг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал, У.Чинзориг “Монгол газрын тос

боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Бүртгэлийн санал хураалт. Ирц бүртгэлийн санал хураалт. Г.Дамдинням гишүүний саналаар ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт.

Энэ ирцэд ороогүй гишүүд М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Б.Баярбаатар, Б.Тулга, С.Зулпхар.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

58 гишүүн дэмжлээ. Энэ чинь 64-өөр дэмжигдэх ёстой.

Засгийн газрын гишүүн Ц.Баатархүү дэмжээгүй өгсөн байх юм. Энэ чинь юу болж байна. Ц.Баатархүү сайд.

Ц.Баатархүү: Миний төхөөрөмж өнөөдөр ажилласангүй. Тэгээд дахин санал хураалгаж өгөөч ээ гэдэг санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Ц.Баатархүү сайдын горимын санал ямар санал болчхов? Микрофон өгье дөө. Нэг асуудлаар нэг л гишүүн горимын санал гаргах боломжтой байгаа юм. Дэгээрээ. Ц.Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Энэ нэлээн хэдэн хүний төхөөрөмж ажиллаагүй. Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөөч гэдэг горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Ц.Баатархүү гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай санал хураалтдаа оролцохыг хүсье. Санал хураалт. /алх цохив/

62 гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгох горимын санал дэмжигдлээ. Одоо үндсэн санал хураалт явагдана.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Манай гишүүд санал хураалттай холбоотой эргэлзээтэй ганц хоёр зүйл байх шиг байгаа юм. Энэ бол Засгийн газар хоорондын хэлэлцээр явагдаж байгаа.

Газрын тосны бүтээн байгуулалттай холбоотой гишүүдийн асууж байгаа асуулт бол манай дотоод асуудал. Үүнтэй холбоотой өчигдөр Аж үйлдвэржилтийн байнгын хороо хуралдаж үйл ажиллагааг эрчимжүүлэх тогтоол бас батлагдсан.

Тэгэхээр тэр бол манай дотоодод Улсын Их Хурал, Засгийн газрынхаа түвшинд зохион байгуулагдах ажил гэдгийг анхаарах нь зүйтэй. Энэ бол Засгийн газар хоорондын зээлийн хэлэлцээрийн асуудал явж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Ингээд соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын 67 гишүүн дэмжлээ.

Нэмж Загджавын Мэндсайхан гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн нар дэмжсэнээр протокол тэмдэглүүлж байна.

Ингээд нийт 69 гишүүн дэмжсэн байна.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Газрын тосны үйлдвэр энэ бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс асуусан асуулт, хэлсэн санал дээр маш өндөр хариуцлагатай хандах ёстой. Шаардлагатай зүйлс дээр Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэг, Байнгын хорооны гишүүдийг газар дээр нь бодит нөхцөл байдалтай очиж танилцах боломжоор хангаж өгөх хэрэгтэй.

Үүнийг Засгийн газар зохион байгуул. Тэгээд энэ асуудлын ойлголтыг нэг талд гаргахад анхаарч ажиллахыг хүсэж байна. Чиглэл болгож өгч байна. /алх цохив/

Эцсийн найруулга орж ирнэ. Эцсийн найруулга орж ирэх билүү? Тийм. Эцэслэн баталчихсан шүү дээ. Тийм ээ.

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулна.

Индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй 2, мөн зүйлийн 42.2.3-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн 4, нийт 6 санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг үндэслэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан “Орхоны хөндийд

“Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: С.Зулпхар гишүүнд талархал дэвшүүлье.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Н.Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Сумъяасүрэнгийн Энхжаргал Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн, Нэргүй Нацагдорж “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Баасанхүүгийн Энхсайхан “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх, Баярсайханы Амарсанаа “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мягмаржавын Отгонбат “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Мэдээлэл, харилцаа холбооны инженер, Мөнхуягийн Мөнх-Эрдэнэ “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууя.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Шинэ Хархорум хотын хуультай холбоотойгоор хоёр заалт өнгөрсөн чуулган дээр саналаар унасан юм.

Тэр нь ч яах вэ тэгээд нөгөө газар эзэмшүүлэх, ашиглуулах гэдэг асуудал байсан. Уг нь үүний цаана газрын хуулиараа асуудлууд нь шийдэгдээд явчих боломжтой зүйл дээр аль болох хөрөнгө оруулалт татах тийм эрх зүйн орчныг бид уг нь энэ хуулиараа нээгээд өгчихсөн бол зүгээр байсан юм уу даа гэдэг агуулга.

Тэгээд ажлын хэсгийн дарга Г.Тэмүүлэн даргатай би бас энэ талаар байр сууриа солилцоод ойлголцсон байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Турк Улсад айлчлаад Хархорум хотын Хөрөнгө оруулалтын санамж бичиг дээр гарын үсэг зурчихсан. Бид энэ эрх зүйн орчныг уг нь нээж өгөх нь зүй ёсны асуудал.

Дараагийн нэг асуудал. Энэ Хархорум хотын концепцыг Улсын Их Хурлаар батална гээд өчигдрийн Байнгын хороон дээр ороод ирсэн юм. Яах вэ төлөвлөлтийг нь Улсын Их Хурал баталж болно. Концепцыг нь Засгийн газраар батлуулаад явбал. Одоо энэ чуулган чинь өнөөдөр юм уу, маргааш завсарлаад 3 сарын 15 хүртэл цуглахгүй. Тэгээд энэ хооронд концепц бол орж ирэхгүй юм байна, батлагдахгүй юм байна гэж ойлголоо.

Тэгээд энэ дээр ажлын хэсгийн дарга Г.Тэмүүлэн дарга нь нэг тодруулаад. Засгийн газраар энэ концепцыг батлагдаж болохгүй юу гэдэг асуудалд нь та нэг хариулж өгөөч ээ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Б.Баярбаатар гишүүний асуултад хариулъя.

Бид түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулахтай холбогдуулаад энэ Хархорум хотын төлөвлөлт болон бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль маань ингээд Улсын Их Хурлаар өнөөдөр эцсийн хэлэлцүүлгээ хийх гэж байна.

Үүнтэй холбогдуулаад өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болоод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хурал баталж байхаар орж ирсэн.

Ер нь манай одоогийн байгаа эрх зүйн орчныхоо хүрээнд улсын нийслэлтэй холбоотой асуудлыг, тэр дундаа тухайн тэр хотынх нь үзэл баримтлал болон ерөнхий төлөвлөгөөг нь Улсын Их Хурал баталдаг ерөнхий жишиг байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн энэ долоо хоногийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 2040 буюу Улаанбаатар хотын үзэл баримтлал болон ерөнхий төлөвлөгөөг батлахаар орж ирж байгаа.

Тэгэхээр ер нь нэг талдаа бид түүхэн нийслэлийг сэргээн байгуулах, цаашид илүү бодлогын зөв шийдлүүдийг гаргах үүднээс Улсын Их Хурлаар том бодлогын асуудлыг хэлэлцэж баталж байх нь зүйтэй гэсэн энэ үндсэн дээр Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээс Улсын Их Хурал батлахаар орж ирж байгаа. Зарчмын хувьд зөв зүйтэй гэж харж байгаа.

Бид эрх ашгийн эрэмбийн хүрээнд эрэмбэ дараалалтайгаар энэ бодлогуудыг оруулж ирээд Улсын Их Хурал дээр шийдлүүдийг гаргаад явах нь зүйтэй гэж харж байгаа.

Тэгээд ер нь Улсын Их Хурал дээр бид цаашид энэ хотын маань төлөвлөлт ямар байх юм, газар зохион байгуулалтууд нь ямар байх юм, ерөнхий төлөвлөгөө болон техник, эдийн засгийн үндэслэл нь хэрхэн хийгдэж байгаа юм гэдэг нь бодлогын шийдлүүдийг Улсын Их Хурал дээр танилцуулаад нэгд. Нөгөө талдаа ард түмэнд мэдээллүүдийг өгөөд ингээд цаашид бодлогын шийдлүүд нь гараад явна гэж харж байгаа.

Хэзээ энэ ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлалууд нь Улсын Их Хурлаар орж ирэх вэ гэдэг энэ цаг хугацааны мэдээллийг Хархорум хотын захиргааны газраас өгөх байх гэж бодож байна. Энэ ондоо багтаад, магадгүй хаврын чуулганаар Улсын Их Хурлаар орж ирж төлөвлөгөөгөө танилцуулаад батлуулаад явах байх гэсэн ерөнхий ойлголттой байна.

Д.Амарбаясгалан: Р.Сэддорж гишүүн. Алга байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Хархорум төсөл зүгээр нэг гарч байдаг төсөл, хөтөлбөр биш юм.

Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр буюу “Алсын хараа-2050” дээр нийслэлийн баримжаатай хөгжүүлэх гэсэн ийм зохицуулалт байгаа. Нийслэлийн баримжаатай хөгжүүлнэ гэдэг ирээдүйд Монгол Улсын нийслэл болох боломжтой гэсэн санаа агуулж байгаа.

Тэгээд одоо шууд Монгол Улсын нийслэлийн төлөвлөлттэй явна гэж үзэх юм бол бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай учраас ингэж болохгүй байгаа юм.

Тэгэхээр одоо Их Хурлын гишүүдийн санал зөрж байгаа асуудал нь тэнд байгаа газрыг эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн тухай асуудал дээр нэлээн маргаантай байгаа юм.

Тэгэхээр нэгэнт улсын нийслэл болж болзошгүй ирээдүйдээ магадгүй гэсэн ийм ангилалд байгаа учраас энэ улсын нийслэлийн стандарт, стратегийн хөгжлийн зураг төсөл, энэ бүх зүйлүүд гарах ёстой. Одоо байгаа нөхцөл байдал нь энэ хууль батлагдаж байж тодорхой хэмжээ, судалгаа шинжилгээ нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, хуулийн үзэл баримтлал хийгдэх ёстой болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ дээр бид ажлын хэсгийн зүгээс “Төлөвлөлт” гэдэг үгийг зориуд оруулж байгаа. “Төлөвлөлт” гэдэг нь болох юм завсрын шинж чанартай буюу нийслэл болох хүртэлх хугацаанд энэ хуулийн үйлчлэлийн хязгаарыг тогтоосон ийм зохицуулалтыг харж байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд маань үүнийг эхний ээлжид та бүхэн дэмжиж өгмөөр байна. Нөгөө талаасаа ажлын хэсгийн зүгээс ч гэсэн өмнөх анхны хэлэлцэх эсэх асуудлаар яригдаж байхад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын ярьсанчлан тийм симуляцын түвшний төлөвлөлтүүдийг хийх зайлшгүй шаардлагатай байгаа. Н.Нацагдорж дарга аа.

Одоо бид нарт чинь 37 концепц гэж байгаад байгаа шүү дээ. Тийм ээ. 37 концепц гэдэг уралдаанд оролцсон талууд 37 янзаар симуляц хийж үзээд ойрын ирэх жилүүдэд хэтийн төлөвт хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн төвлөрөл, технологи, инновацын боломж ямар байх вэ гэдгээс шалтгаалсан зүйл байгаа. Энэ дээрээ энэ хууль батлагдах байх гэж найдаж байгаа. Энэ хуулийг батлагдсаны ар дээр яаралтай сонгоод симуляцаа хийгээд хамгийн зохимжит “нийслэлийн чиг баримжаатай” гэж оруулах ёстой ийм л зүйл байгаа.

Тэгээд Засгийн газраас. Би ажлын хэсгээс асуухгүй. Засгийн газраас асууя гэсэн. Засгийн газраас яг хариулах хүн алга байна. Тэгэхдээ зарчмын зүйл нь ер нь 100 хувь гэж үзэх юм бол 50 дээр нэмэх 1, магадгүй 60 хувийн магадлалаараа Монгол Улсын ирээдүйн нийслэл болох юм байна. Нийслэлийн хэв шинж гэдэг чинь өөрийн гэсэн стандарттай, өөрөө засаг захиргааны нэгж, дээрээс нь Монгол Улсын төр, удирдах байгууллага, олон улсын байгууллага төвлөрсөн ийм зүйл байна гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр ер нь хуулийн төслийнхөө цаашдын үйлчлэлээ “нийслэлийн чиг баримжаатай” гэдэг дээр нь авч үзэх ёстой болов уу.

Зарим гишүүдийн, манай Б.Баярбаатар гишүүн, Г.Хосбаяр гишүүн нарын асуугаад байгаа тэр “эзэмших” гээд гэдэг зүйл дээр хэрвээ нэгэнт “нийслэлийн чиг баримжаатай” болох юм тэнд бас стратегийн байршил бүхий бүтээн байгуулалтууд болох учраас энэ зүйлийг нь жишээлбэл болж өгвөл энэ хуулийг дагах бичгүүд дээр нь тодорхой үечлэлтэй он зааж өгвөл зүгээр байгаа юм. Жишээлбэл, 2025 онд энэ хууль батлагдлаа гэхэд 2025 ондоо багтаад үзэл баримтлалаа эцэслэн боловсруулах. Дээрээс нь тэр 189 мянган га газрын төлөвлөлт нь өөрөө ирээдүйд “нийслэлийн чиг баримжаатай” байх юм бол аль нь жишээлбэл яг засаг захиргааны гол төв байх юм. Одоогийн байгаа ажлын хэсэг дээр ярьж байгаа яст мэлхийний хэлбэртэй байх юм уу ч гэдэг юм уу. Тийм ээ. Энэ бүх зүйлүүдээ маш яаралтай нэг жилийн дотор хийх ёстой байх. Тэгээд шаардлагатай гэж үзэх юм бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр шаардлагатай гэж үзэх юм бол бид 2032 он ч гэдэг юм уу, 2038 он ч гэдэг юм уу тодорхой 2050 он хүртэлх 3-аас 4 цаглавар тогтоод цаглавар дотроо төлөвлөлтийн үе шатуудыг тавьж өгмөөр юм шиг байгаа юм.

Магадгүй цаглаварын хоёр дахь үе шатаас ч гэдэг юм уу, гурав дахь үе шатаас тэр “газар эзэмших” боломжийг нь бас хангаж өгөх ёстой. Тэгэхгүй шууд хорьчхоор тэнд хүмүүс хөрөнгө оруулалт хийх, бүтээн байгуулалт хийх боломжууд нь хумигдчихна гэсэн үг.

Тэгэхээр огт энэ хуулиар энд “газрыг эзэмшүүлэхгүй” юм байна гэдэг эцэслэн шийднэ гэхээсээ илүүтэйгээр төлөвлөлтийн хууль маань одоо жишээлбэл 4 жил үргэлжлэх юм уу, 5 жил үргэлжлэх юм уу. Төлөвлөлтийн хууль үргэлжлээд дуусахад дараагийн шилжилтийн хуулийн дараагаар үргэлжлэх хууль маань “газар эзэмшүүлэх” боломжийг нь хангасан ч гэдэг юм уу, энэ байдлаар явбал их зөв байна л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Тэгэхгүй энэ хуулиа урт хугацаа ны гэж шууд эзэмших эрхийг нь хасчхаж болохгүй. Шууд бас нээчихэд учир дутагдалтай байна л гэж харж байгаа юм.

Тийм учраас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сүхбаатар Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Хархорум хотыг байгуулах ерөнхий төлөвлөлтийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар батална гэхээр цаашдаа улсын зэрэглэлтэй энэ хотуудыг Улсын Их Хурал батлаад, тухай бүр өөрчлөлт оруулах тохиолдолд нь дахиад Улсын Их Хурал болгоноор орж ирнэ гэдэг ийм байдлаар явна гэхээр энэ хотын үйл ажиллагаанд нэлээн төвөг учруулах зүйл рүү нь орчих вий дээ гэдэг дээр бас болгоомжилж байна.

Түрүүн бас гишүүд хэллээ. Ер нь энэ Хархорум хотыг байгуулахад тэнд хөрөнгө оруулалт хамгийн түрүүнд хэрэгтэй. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд, гадна, дотнын хөрөнгө оруулагч нар үндсэн гол татах зүйл маань газар. Гэтэл “газрыг эзэмшүүлэхгүй” гэдэг шийдвэр маань эргээд энэ хотод хөрөнгө оруулалт хийх сонирхол, тийшээ орох сонирхлыг унагаачих биш үү.

Тэгэхээр эзгүй талд хот барихад хамгийн чухал тэр зүйлүүд нь тодорхой байх ёстой.

Тийм учраас энэ тал дээр. Магадгүй энэ хот байгуулахын хамгийн гол амин чухал зүйл нь тийшээ хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтынх нь гол зүйл нь ерөөсөө л бид нарт байгаа зүйл газар байгаа. Тэгээд энэ асуудлыг бидний хувьд эргэж авч үзэх хэрэгтэй болох байх.

Тэгээд би Хархорум хотын ажлын хэсгээс асуумаар байна. “Газар эзэмшүүлэхгүй” гээд шийдчихээр цаашаа яах юм бэ? Одоо энд чинь аж ахуйн нэгж, байгууллагууд газар эзэмшүүлэхгүй юм чинь тэнд хөрөнгө оруулахгүй.

Тэгэхээр үүнийг босгох, улсад шинэ хот бариад байх мөнгө байхгүй. Гадна, дотнын хүмүүс, тухайлбал Астана хот 7 жилийн дотор л баригдсан юм билээ л дээ. Тодорхой газрыг нь эзэмшүүлнэ, хөрөнгө оруулалтыг нь тодорхой татвараас хөнгөлнө, дэмжинэ гэдэг байдлаар улс болгоноос, төрийн сайд нар болгон, айлчлал болгоноосоо нэг байшин, барилга тодорхой төлөвлөлтийнх нь хэсэг дээр нь баталгаа, татварын хөнгөлөлт, дэмжлэг өгнө гэж байж ийм хурдан боссон.

Тэгэхээр манайх газар олгохгүй, эзэмшүүлэхгүй юм байна. Ер нь ашиглуулна. Тэгж байгаад болно гэдэг байдлаар явна гэх юм бол хотын асуудал цаасан дээр үлдчих вий гэдэг дээр миний хувьд санаа зовж байна.

Хоёрдугаар асуудал нь, Хархорум хот. Тэнд хүн амьдарна. Тэр хот амьдрах өөрөө үндсэн концепц нь юу байх юм бэ? Хамгийн чухал хот аялал жуулчлал, үйлдвэрлэл байх юм уу, эсвэл түүнийг дагасан томоохон бүсийн ямар үйлдвэрүүд байх юм гэдэг төлөвлөлт дээр тодорхой ямар үзэл баримтлалыг баримталж байгаа юм бэ гэдгийг асуумаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр саяын тэр газар эзэмшүүлэхтэй холбоотой асуудал дээр нэг талдаа зарим гишүүд эрхийг нь хязгаарласан зүйл дээр тодорхой асуудлыг гаргаж ирж тавьж байх шиг байна.

Бид одоогийн байгаа Хот байгуулалтын тухай хуулиараа улсын нийслэлийн үзэл баримтлал болоод ерөнхий төлөвлөгөөг нь угаасаа баталдаг жишиг байгаа юм. Тэгээд Хархорум хот угаасаа бид бүхний хувьд асар том өндөр амбицтай, улсын маань түүхэн нийслэл байсан. Цаашид ч магадгүй бид бүхэн энэ хотоо байгуулсны дараагаар эрэмбэ дараалалтайгаар нийслэлийн баримжаатай хотын статустай хот болох боломж бололцоо бүрэн дүүрэн байгаа гэж харж байгаа.

Энэ ч үүднээсээ бид асуудалд аягүй хариуцлагатай хандах ёстой. Ажлын хэсэг дээр бид бүхэн сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд ярилцаж байгаад гол болгоомжилж байгаа зүйл маань газар төлөвлөлт болоод газар зохион байгуулалттай холбоотой асуудлыгуудыг зөв хийх ёстой гэдэг асуудлыг тавиад тавиад байгаа.

Тэгээд энэ үндсэн дээрээ энэ хотынх нь газар төлөвлөлт нь болоод газар зохион байгуулалт нь заавал ч үгүй Улсын Их Хурлаар орж ирж хариуцлагатайгаар энэ Улсын Их Хурлаар танилцагдаж, хуульчлагдаж цаашид хэлбэрэлтгүйгээр мөрдөгддөг байх энэ зохицуулалтыг хийх нь зүйтэй гэж харж байгаа. Нөгөө талдаа гишүүдийн хувьд ч гэсэн бид ойлгох ёстой юм.

Улаанбаатар хотын алдааг бид энд давтах ёсгүй гэдэг гэсэн үг яриад байгаа юм. Буруу төлөвлөлттэй, газар зохион байгуулалт байхгүй. Өнөөдрийн Улаанбаатар хотод нүүрлэсэн магадгүй энэ газрын наймаа ч гэдэг юм уу хариуцлагагүй хандсан асуудлуудыг бид нэг талдаа энэ эрсдэлээс сэргийлж Улсын Их Хурал хариуцлагатайгаар эхний ээлжид эрэмбэ дарааллын хүрээнд ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлалыг нь Улсын Их Хурал ороод танилцаад, түүн дээрээс танилцуулагдах, магадгүй тэр газар зохион байгуулалттай холбоотой төлөвлөлттэй холбоотой мэдээллүүдийг сонссоны үндсэн дээр Засгийн газар энэ газрын тухай асуудлуудаар тодорхой өөрчлөлтүүдийг оруулж ирж болно.

Улсын Их Хурал энэ дээр ямар нэг хойш нь хандах, хойрго хандах зүйл байхгүй. Хэзээ оруулж ирнэ. Энэ дээр бид шуурхай хандаж энэ түүхэн нийслэлийг сэргээхтэй холбоотой хуулийн асуудлууд дээр хариуцлагатай хандана гэдгийг нэгдүгээрт хэлэх байна.

Хоёрдугаарт, энэ хотын маань эдийн засгийн үндэс суурь маань өөрөө юу ярих юм бэ гэдэг асуудлыг С.Эрдэнэбат гишүүн асуулаа.

Тэгэхээр бид энэ хот төлөвлөлт, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим гэдэг зүйлүүдийг хуульд хуульчилж оруулж өгсөн.

Нэгдүгээрт, эдийн засаг гэхээсээ илүүтэй нэгдүгээрт энэ хот байгуулахаасаа өмнө бид түүхэн өв соёл болоод үнэт зүйл, өвөө сэргээх, хадгалан хамгаалах асуудал нэгдүгээрт байгаа. Үүн дээрээсээ суурилад бид

олон төрөл тогтвортой аялал жуулчлалыг дэмжих гэдэг асуудал номер хоёрт бичигдэж энэ хотыг байгуулах суурь зарчим дээр тусгагдаж орж ирж байгаа.

Гуравдугаарт, эдийн засагтай холбоотой гол асуудал маань ерөөсөө л энэ бүс нутгийнхаа нэгдүгээрт тэнцвэртэй хөгжлийг нь хангах ёстой. Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалтай уялдсан байх ёстой. Эдийн засгийнхаа хувьд бүсийн хөгжлийг дэмжиж бие даан хөгжих боломжтой байх ёстой гэсэн энэ суурь зарчмуудыг хийж өгч байгаа. Үзэл баримтлал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Төлөвлөлттэй холбоотой, тэгээд байгаль орчинд үзүүлэх нөлөө, орон нутгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой гурван товчхон асуулт асууя. Ажлын хэсгээс.

Хот төлөвлөлтийн ухаалаг шийдлүүдийг яг ямар технологид тулгуурлан хэрэгжүүлэх гэж байгаа вэ? Энэ ухаалаг хот байгуулах технологиуд чинь зардал өндөртэй байх учраас энэ сонголт нь бас мэргэн байх хэрэгтэй байх.

Хоёрдугаарт, хуулийн төсөлд байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний судалгаа хийсэн байна. Тэгэхдээ усны нөөц болон хөрсний бохирдолд үзүүлэх нөлөөллийн судалгаа. Тэрийг орхигдуулсан байх шиг байна. Би олж харсангүй. Энэ Орхоны хөндийн чинь бас энэ ЮНЕСКО-гийн өвд бүртгэгдсэн газарт эко системийг алдагдуулахгүй байх гэсэн онцгой шаардлагатай байдаг.

Ингэхээр Хархорум хотын бүтээн байгуулалтад хэрэгжиж байгаа энэ Орхоны хөндийн сав газарт ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн тийм судалгаа байна уу? Үүнийг бууруулах ямар төлөвлөгөө байна аа? Эко систем нь хамгаалах бодлогын төсөлд нарийвчилсан тийм төлөвлөгөө тусгасан уу гэдгийг асууя.

Гурав дахь нь, төсөл хэрэгжихтэй холбоотойгоор Архангай, Өвөрхангай нутгаас иргэдийг нүүлгэн шилжүүлэх асуудал гарах уу? Ийм шаардлага үүсэж байгаа юу? Тийм бол эдгээрт үүсэх хүндрэл байна уу? Эдийн засгийн нөхөн олговрын асуудал ч юм уу, энэ дээр ямар бодлого баримталж төлөвлөж байгаа вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Д.Ганмаа гишүүний асуултад хариулья.

Хуулийн төсөл дээр ерөнхийдөө бид саяын тэр хот төлөвлөлттэй холбоотойгоор, цаашид шинэ техник, технологи болоод шинэ инновацад суурилсан ямар ер нь дэд бүтцүүдийг хөгжүүлэх юм бэ гэдэг асуултыг асууж байна.

Тэгэхээр бид түрүүн бас ярьсан. Энэ хот төлөвлөлтийн суурь зарчим буюу хот төлөвлөлтөд цаашид анхаарах, баримтлах үндсэн зарчмынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тодорхой хуульчилж оруулж өгсөн. Энэ дээр дотроо, би танд уншиж өгөх юм бол үндсэн хот төлөвлөлтөд баримтлах зарчмын 4.1.6 дээр “дэвшилтэт технологи болон инновацад суурилсан ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх” гэдэг асуудлыг гаргаж ирж тавьсан.

Мөн нөгөө талдаа дэд бүтэц дотроо эрчим хүчний хэмнэлттэй болоод байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих, тэр дотроо сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих гэдэг асуудлыг гаргаж ирж тавьсан байгаа.

Би танд энэ хууль дээр зохицуулалтаар тавьсан хуульчилж бичиж байгаа зохицуулалтыг хийж байгаа.

Түүнээс яг амьдрал дээр төлөвлөлт тал дээр яг ямар ямар ухаалаг шийдлүүд, технологиудыг ашиглах юм бэ гэдэг энэ дараагийн асуудал. Энэ хүрээндээ хотын ерөнхий төлөвлөгөө болоод хотын ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг эцэслэн баталж хийхдээ энэ асуудлууд тодорхой болно гэж харж байгаа.

Одоогийн байдлаар хотын ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлал эцэслэн батлагдаагүй. Улсын Их Хурлаар орж ирж хуульчлагдаж танилцуулагдахаар энэ зохицуулалтууд хийгдсэн байгаа гэдгийг хэлэх байна.

Хотын суурь судалгаатай холбоотойгоор. Одоогийн байдлаар Улсын Их Хуралд танилцуулснаар, бид бүхний авснаар суурь судалгааны хүрээнд энэ байр зүйн судалгаа болон зураглалын ажлууд хийгдсэн. Инженер, геологийн судалгаанууд бас хийгдсэн. Тэр дотроо инженер, геологийн судалгаан дээр 3 байршил дээр 991 цооног хатгасан гэж байгаа. Ундны усны хайгуулын ажлууд бас хийгдсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, тэр дотроо хөрс гадаргыг доройтуулахгүй байх чиглэлээр суурь судалгааны ажлууд хийгдсэн байгаа.

Нөгөө талдаа археологи, палеонтологи болоод угсаатны зүйн судалгаанууд хийгдсэн. Археологийн хүрээлэн бас энэ дээр үргэлжлүүлээд судалгааны ажлуудыг хийгдэж байгаа. Тэр дотроо бид бүхний бас энэ хууль дээр тусгаж оруулж ирж байгаа зүйл маань ямар нэг байдлаар энэ бүтээн байгуулалтын ажлууд явагдахад, бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө тухайн тэр хийгдэх газрууд дээр ямар нэг археологи болоод палеонтологийн сөрөг нөлөөлөл учрахгүй, тухайн эрсдэлтэй газрууд дээр тодорхой бүтээн байгуулалтыг хийхгүй гэсэн баталгаануудыг гаргаж ирэх зайлшгүй шаардлага байгаа гэж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ судалгааны ажлууд хийгдээд явна гэж харж байгаа.

Тэгэхдээ энэ дээр бас нэг зүйлийг хийхэд яг тухайн тэр тусгай хамгаалалтад авсан 2 газар байгаа. Одоогийн энэ хууль дагаж бид тухайн хот байгуулахтай холбоотой тусгай хамгаалалттай газрыг авна. Өмнө нь ЮНЕСКО-гийн хүрээнд тухайн соёлын өвд баталгаажсан 183 мянган га газрыг бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Би ерөнхийдөө Хархорины аялал жуулчлалын бүс болгоё гэж бүр 2005 онд анх аялал жуулчлалыг хариуцаж байхдаа яаманд ярьж байсан.

Тэгээд түрүүн С.Эрдэнэболд гишүүний асууж байсан шиг аялал жуулчлалыг хөгжүүлэх ямар нэгэн тийм төлөвлөгөө байгаа юу? Хэчнээн жуулчин авна гэж төлөвлөж байгаа юм бэ? Ямар аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зочид буудал, үйлчилгээ төлөвлөсөн юм бэ гэж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгөх үү? Тэгье. Ажлын хэсгийн дарга.

Г.Тэмүүлэн: Би хуулийн төсөл дээр тусгагдсан аялал жуулчлалтай холбоотой тодорхой заалтуудыг ажлын хэсгээс зохицуулалт хийж оруулсан, тусгасан заалтуудыг танд уншиж танилцуулья.

Яг тодорхой хэчнээн хэмжээний жуулчин ирэх, ямар төлөвлөлт зохион байгуулалтууд хийгдэх талаар Засгийн газрын ажлын хэсгээс танд нэмж мэдээлэл өгөх байх.

Бид энэ хуулийн төсөл дээр анхаарах ёстой гол асуудал маань үндсэндээ бид энэ хотын маань эдийн засгийн үндэс суурь нь, цаашид өөрийнхөө бие даан хөгжих үндсэн боломж бололцоо нь үндсэндээ бид бүхэн түүх болон соёлын биет болон биет бус өв дээр суурилсан аялал жуулчлалын асуудлууд байгаа.

Бид тухайн соёлын биет болон биет бус өв, байгалийн онцлог, мөн дээрээс нь нүүдлийн соёл иргэншилд түшиглэсэн олон төрөлт тогтвортой аялал жуулчлалыг энэ бүс нутагт, тэр дундаа энэ шинэ байгууллагад Хархорум хот дээр дэмжиж бий болгох боломж бололцоо байгаа гэж үзэж байгаа. Энэ хүрээндээ бид хуулийн заалтууд дээр 4.1.1 болон 4.1.2 дээр тусгайлан аялал жуулчлалыг дэмжих зохицуулалт заалтууд бас орж өгсөн.

Мөн дээрээс нь 8.1.18 дээр өв соёл болон нутгийн иргэдийн ахуй амьдралд түшиглэсэн төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх, мөн түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээлд тулгуурлан үндэсний бахархлийг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах зэрэг зохицуулалт заалтууд тусгайлан тусгагдсан байгаа гэдгийг хэлэх байна.

Хотын үзэл баримтлал болоод хотын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Засгийн газрын ажлын хэсгийн зүгээс танд нэмж мэдээлэл өгөх байх. Ерөнхий хэр хэмжээний аялал жуулчлалыг жуулчин хүлээж авах болон хэр хэмжээний бүтээн байгуулалтыг энэ хүрээндээ хийх талаар тодорхой мэдээллийг өгөх байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Ажлын хэсгээс Н.Нацагдорж дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Н.Нацагдорж: Өглөөний мэнд. Гишүүний асуултад хариулъя.

Таны асуусан асуулт бол дараагийн төлөвлөлтийн үе шатад тусгагдах ёстой зүйлүүд. Мэдээж Хархорум хотын төлөвлөлтөд тэргүүлэх чиглэлүүдэд мэдээж аялал жуулчлал. Мэдээж хүнсний үйлдвэрлэлүүд, хөнгөн үйлдвэрлэл, үйлдвэрлэлүүд, өндөр технологийн үйлдвэрлэлүүд гэсэн энэ чиглэлүүд одоогоор бас энэ судалгаанд ороод явж байгаа. Энэ бол үзэл баримтлалаараа тодорхой болно.

Тэгээд үзэл баримтлал гэдэг бол таны асуусан зүйлүүдийг тодорхойлохоос гадна маш олон янзын хувилбарууд хийгдэж, тэрнийхээ батлагдсаны дараа Хөгжлийн Ерөнхий дэлгүүр лүүгээ ордог юм.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Ажлын хэсгээс асуулт байна.

Нэгдүгээрт, хот байгуулах асуудлыг ер нь дэмжиж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Улаанбаатар хотын өнөөгийн үүсээд байгаа нөхцөл байдал бол үндсэндээ дэд бүтэц хомсдмол байгаагийн л илрэл гэж харж байгаа шүү дээ.

Өнөөдрийн агаарын бохирдол, түгжрэл, энэ бүх юм чинь шинэ хот байгуулаагүй, иргэд маань эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэр эрх нь ноцтойгоор зөрчигдөж байгаа учраас энэ асуудлыг яаралтай богино хугацаанд үр дүн өгөхөөр бид хуульчлах ёстой гэж харж байгаа.

Манай улсын 67 хувь нь хот суурин газар амьдарч байгаа. Тэгээд сүүлийн 20 жил зөвхөн Өмнөговь аймаг руу л хотоос шилжсэн байдаг. Бусад бүх аймгаас Улаанбаатар луу шилжсэн байдаг юм.

Тэгэхээр энэ шинээр байгуулагдах Хархорум хот руу хүн амын шилжилт хөдөлгөөн очих, хүн амыг татах, хөрөнгө оруулалтыг татахын тулд ямар ямар үндсэн үзүүлэлтүүд байгаа юм бэ? Жишээгээр тэр газрыг “ашиглуулах”, “эзэмшүүлэх” гэдэг асуудлын зөрүү нь хэр байгаа юм? Яг Хархорум хот дээр зөвхөн ашиглуулах эрх зүйн орчин бүрдүүлчхээд Улаанбаатар хотод нь энэ Богд Хан уулынхаа бүх ашигтай сайхан гэсэн газрыг эрх бүхий этгээдүүд нь

эзэмшээд байвал цаашдаа энэ хотын үйл ажиллагаа явахгүй болов уу гэж бодож байгаа юм. Үүнийг яг тодорхой ажлын хэсэг хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт, үзэл баримтлалыг Их Хурлаар батална гээд тэгээд байгаа юм.

Тэгэхээр Их Хурлаар батална гэхээр бүсчилсэн хөгжлийн бодлого гээд үндсэндээ Их Хурал дээр зөвхөн өөрийн тойрог, бүсчилсэн асуудал яригдах учраас миний харж байгаагаар Засгийн газар нийт улсаа төлөөлөөд энэ үзэл баримтлалаа батлах нь зүйтэй байх. Ерөнхий төлөвлөгөөгөө бол Их Хурлаар оруулж ирж болно гэж харж байна.

Тэгэхээр үүний зөрүүг нь Та бүхэн маань өгөөжтэй тал нь, сөрөг талыг нь ажлын хэсэг нэг дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү. Үзэл баримтлал нь Их Хурлаар байх нь зүйтэй юм уу, Засгийн газраар байх нь зүйтэй юм уу гэдгийн ялгаатай талыг маш тод хэлж өгнө үү гэж хүсмээр байгаа юм.

Тэгээд эцсийн үр дүнд нь энэ хотыг богино хугацаанд үр дүнтэйгээр үйл ажиллагааг нь урагшлуулахын тулд энэ хуульд дэм болсон, түлхэц үзүүлсэн гол хүчин зүйлүүдийг нь маш тодорхой нэг илэрхийлж өгөөч ээ. Тэгэхгүй энэ хамаг ажлын хэсгээс орж ирсэн үндсэн эрхүүд нь хасагдсан байна гэж харж байгаа юм. Баярлалаа. Асуултад хариултаа авчхаар тодруулъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, саяын суурь дэд бүтэцтэй холбоотой асуудлуудыг та хөндөж гаргаж ирж тавьж байна. Бид бүхний хувьд ажлын хэсэг дээр гол анхаарч байгаа зүйл маань энэ онцгой чухал газар, тэр дундаа Монгол Улсын түүхэн нийслэлд байсан Хархорум хот дээр бид энэ “Шинэ Хархорум” хотыг байгуулахтай холбоотойгоор ямар нэг Улаанбаатар хотод бий болсон тэр алдаануудыг давтах учиргүй юм.

Тэгэхээр ямар нэг байдлаар энэ асуудалд бид төлөвлөлтийг хийхдээ, зохион байгуулалтыг хийхдээ хариуцлагатай хандах ёстой гэдэг зарчмыг баримталсан. Энэ хүрээндээ эхний ээлжид. Одоо эрэмбэ дарааллаар бид асуудлуудыг шийдээд явах бүрэн боломж бололцоо байгаа. Энэ хотын маань үндсэн ерөнхий төлөвлөгөөнийх нь үзэл баримтлал нь эцэслэгдэн батлагдаагүй байна. Хийгдэж дуусаагүй байна. Энэ хотын ерөнхий төлөвлөгөө маань өөрөө дуусаагүй байна.

Тэгэхээр энэ хүрээндээ бид одоо хууль дээр ямар нэг байдлаар эзэмшүүлэх асуудлыг зохицуулж оруулж өгөх эрт гэж харж байгаа.

Тэгээд дээрээс нь ажлын хэсгийн зүгээс гол баримталсан зүйл маань Газрын тухай хууль болоод, Хот байгуулалтын тухай хууль, Хот, тосгоны тухай хууль, мөн хамгийн сүүлд өнгөрсөн оны хавар батлагдсан Шинэ Зуунмод хотын хуулиудын хүрээнд, нийцүүлэх хүрээнд бид энэ газар зохицуулах харилцаануудыг, газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай харилцаануудыг нийцүүлж оруулж ирсэн гэдгийг хэлэх байна. Шулуухан хэлэхэд бид Улаанбаатар хотын алдааг энэ “Шинэ Хархорум” хот дээр давтах учиргүй.

Дээрээс нь төлөвлөлтийг нь зөв хийх ёстой. Хариуцлагатайгаар хийх ёстой. Газар зохион байгуулалтыг бид алдаа мадаггүйгээр хийх ёстой. Энэ асуудлууд нь нэг талдаа хуульчлагдсан байх ёстой гэж бодоод байгаа. Хэлбэрэлтгүйгээр цаашид мөрдөгддөг байх ёстой гэж харж байгаа.

Ямар нэг байдлаар магадгүй тухайн тэр техник, эдийн засгийн үндэслэлийг хийхдээ тухайн тэр хотын барилгажилтын төсөл болоод газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахдаа эдгээр Улсын Их Хурлаас батлагдах энэ үзэл баримтлал болоод ерөнхий төлөвлөгөөний хүрээнд заавал ч үгүй хийгддэг байх ёстой гэдэг асуудлыг бид хуульчилж нарийвчилж оруулж өгсөн.

Энэ бол нэг талдаа бид энэ төлөвлөлтийг хуульчилж өгч байгаа, хэлбэрлэлгүйгээр мөрдөгддөг байх нь зохицуулалтыг хийж өгч байгаа онцлогтой. Ингээд Улсын Их Хурлаар ерөнхий төлөвлөгөө маань орж ирж батлагдаад хуульчлагдсаны үндсэн дээр бид цаашид зохицуулалтын харилцаануудыг, газартай холбоотой асуудлуудыг зохицуулалтуудыг хийгээд явах бүрэн боломж бололцоо байгаа. Цаг хугацаа хангалттай байгаа гэдэг зүйлийг хэлэх байна.

Саяын дэд бүтцийн хүрээнд Та ерөнхийдөө хараарай. Энэ хуулийн хүрээнд заагдсан 8.1 дүгээр зүйл дээр. Бид энэ хот төлөвлөлт болоод бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хот байгуулалтын тухай хуульд заасан болон олон улсын стандартад заасан шаардлагуудаас гадна нэмж төлөвлөлт болоод хот зохион байгуулалттай холбоотой, хот байгуулалттай холбоотой зарчмуудыг шинээр нэмж оруулж өгч байгаа.

Тэгэхээр нэг талдаа эрх зүйн орчин талаасаа бид өмнөх хот байгуулалтын хуульд байгаагүй шинэ шинэ зарчмуудыг оруулж өгч байна. Энэ бол хүнд ээлтэй ногоон хот байх ёстой. Тухайн тэр юу гэдэг юм нягтаршлийг нь бид хуульчилж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Уучлаарай. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн тодруулж асууна.

Д.Пүрэвдаваа: Би ингээд л байгаа юм л даа. Одоо жишээгээр Шинэ Зуунмод хот, Аэро Сити гээд энэ Улаанбаатар хот тойрсон энэ хотууд нь аж

ахуйн нэгж, компаниуддаа олон жилээр эзэмшихээр газар олгоод яваад байгаа тохиолдолд энэ шинэ Хархорум хот чинь хөрөнгө оруулах хүн олдох уу? Энэ тооцоо судалгаа байна уу?

Энэ “Шинэ Хархорум” хотдоо давуу байдлыг үүсгэх таатай орчныг бий болгох зорилгоор л энэ дэмжсэн хууль гараад байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Яг бусдаасаа бага эрх олгогдсон ийм байх юм бол тийшээ хөрөнгө оруулах, тийшээ чиглэсэн хөдөлгөөн үүсэхгүй юм байна. Яг үүнийгээ нотолсон тоо баримтууд байна уу л гэж асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх үү. Г.Тэмүүлэн дарга. Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Д.Пүрэвдаваа гишүүний ярьж байгаа асуудал зөв өө.

Энэ хөрөнгө оруулалтын талаасаа, хөрөнгө оруулалтын орчин талаасаа бид яг ямар давуу талыг бий болгож байгаа юм бэ гээд.

Энэ анх Засгийн газраас өргөн баригдсан хууль дээр хөрөнгө оруулалтын орчинтой холбоотойгоор тодорхой ямар нэг харилцаанууд нэлээн дутуу байсан. Тэгээд бид ажлын хэсгээс Засгийн газарт чиглэл өгч байгаа зүйл маань ойрын хугацаанд энэ хөрөнгө оруулалтын орчинтой холбоотойгоор илүү давуу тал үүсэхтэй холбоотой асуудлуудыг нарийвчилж сайн судлаад эргээд оруулж ирье. Хотынхоо ерөнхий төлөвлөгөө болоод үзэл баримтлалаа оруулж ирэхдээ үүнийгээ Улсын Их Хурлаар оруулж шийдүүлье гэсэн чиглэлийг өгч байгаа.

Би танд хэлэх гээд байгаа зүйл нь одоогоор хотын үзэл баримтлал болоод хотын ерөнхий төлөвлөгөө маань эцэслэгдээгүй байна. Батлагдаагүй байна. Түүнээс өмнө бид ямар нэг байдлаар газар эзэмшүүлэх харилцааг зохицуулж энэ эрхийг олох нь буруу гэж харж байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурал дээрээсээ ерөнхий төлөвлөгөөгөө эхлээд оруулж ир. Тэрний дараа газар зохицуулах, газар эзэмшүүлэхтэй холбоотой харилцаанууд болоод бусад тэр хөрөнгө оруулалт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? 1990 оноос хойш бид өөрсдөө хотоо төлөвлөж, хот байгуулах хуулиа батлах гэж байна.

Чуулганы хуралдаанаар хурал даргалагчаас хуулийн төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу хуулийн төсөл маань шинэ тутам үүсэж болох харилцааг тусган, туршлага сургамж, олж авсан мэдлэгт суурилсан ийм сайн хуулийн төсөл болж байна гэж харж байгаа.

Тэгэхээр шинэ хотын хувьд хөрөнгө оруулалт маш чухал. Хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах талаар хэдэн зүйл асууя.

5-аас 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл тогтворжуулах гэрчилгээг 4 жилийн хугацаатай олгож, харин 2 жилийн дотор хийж дуусгахаар хөрөнгө оруулалтын дээд хэмжээг 300 тэрбумаар 16 жилийн тогтворжуулалтын гэрээ олгоно гэхчхэн байгаа. Энэ талаар жоохон нэмэлт мэдээлэл авъя гэсэн ийм бодолтой байна.

Хоёрдугаарт нь, хотын эдэлбэр газарт амьдарч байгаа Архангай, Өвөрхангай, Булган аймгийн сум, багийн оршин суугч иргэдэд хотын иргэн болох сонголт нь нээлттэй байгаа. Тэгээд амьжиргааны эх үүсвэр мал аж ахуй, газар тариалан эрхлэх энэ боломжийг нь цаашдаа хэрхэн хангаж ажиллах вэ? Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт бол хотын хүн амыг 10 мянга хүртэл хотын захирагчийг Засгийн газраас томилж ажиллана гэхчхэн байгаа.

Тэгэхээр 10 мянга хүртэлх хүн ам нь хэдий хугацаанд бүрэлдэж бий болно гэж ингэж харж байгаа вэ гэсэн энэ гурван асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Бидний хувьд энэ Хархорум хотын төлөвлөлт болоод бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийнхаа хүрээнд ерөөсөө гол баримталж байгаа суурь асуудал маань энэ хот байгуулалтын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар төлөвлөх гэдэг асуудлыг оруулж ирж байгаа.

Энэ хүрээндээ одоо байгаа Хархорин сум болоод мөн энэ тусгай хамгаалалтад хамрагдаж байгаа Архангай аймгийн Өгий нуур болон Хашаат суманд, мөн Булган аймгийн Гурванбулаг сумд гэдэг юм уу эдгээр сумдууд маань энэ ерөөсөө нэгдсэн төлөвлөлтөд нэгтгэгдэж явна. Тэгээд нэгдсэн байдлаар хамтдаа хөгжих боломж бололцоог бид оруулж өгч байгаа.

Энэ хүрээндээ ямар ч бай одоо байгаа сумдын төлөвлөлтүүд нэгтгэгдээд явна гэсэн үг. Цаашдаа эдгээр сумдын иргэд маань энэ шинэ хотын иргэд болох эрх нь нээлттэй гэдэг асуудлууд яригдана. Тэгэхдээ мэдээж цааш цаашдаа хэдий хугацааны дараагаас нь 10 мянгад хүрч, хэдий хугацааны дараагаас хотын өнгө төрхтэй хот болох гэдэг бол тухайн хот байгуулалт болоод хот төлөвлөлтийнхөө хүрээнд хийгдээд явах байх.

Энэ дээр Засгийн газрын ажлын хэсэг маань нэмээд цаг хугацаа болоод саяын хүн амын тоотой холбоотой асуудлуудыг хэлэх байх. Бидний хувьд энэ хууль дээр тусгаж өгсөн хамгийн доод хэмжээ 10 мянга гэдэг зүйл бол Хот байгуулалтын тухай хуульд заасан байдаг. Хот өөрөө хотын анхан шатын нэгж

болсон хороолол 10 мянга байж нэг хотын бид өнгө төрхтэй болно гэсэн хүрээнд суурилж оруулж өгсөн.

Тэгэхээр анхны хороолол байгуулагдсанаар цаашдаа энэ Хархорум хотыг бие даасан хот гэж үзэж, тухайн орон нутгийн иргэд нь өөрсдийнхөө төлөөллийг сонгох, тухайн захирагчаа сонгоод явах энэ эрхүүдийг нь нээж өгч байгаа.

Ингээд цаашдаа энэ Хархорум хот маань бие даасан эдийн засаг болон дэд бүтэц бие даасан төвүүдтэй бие даан хөгжих боломж бололцоонуудыг бид бүхэн бүрдүүлээд өгөөд явна гэдэг зүйлийг хэлэх байна.

Саяын тэр нэмэлт асуултууд дээр манай Засгийн газрын ажлын хэсгийн зүгээс нэмээд хариулах нь зүйтэй байх гэсэн саналтай байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд.

Нэмж хариулах юм уу? Ажлын хэсгээс. Н.Нацагдорж дарга нэмж хариулна. Хариулт өгье.

Н.Нацагдорж: Хариулъя. 10 мянга гэдэг ойлголт бол зүгээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд хот гэдэг нь 15 мянган хүнээс дээш оршин суугчтай бол хот гэж заасан байдаг.

Тэр дотор яагаад 10 мянга гэсэн бэ гэвэл хорооллийг 10 мянган хүнээр хороолол гэж үзнэ гэж заасан байдаг. Тэгээд 10 мянгаас доошгүй гэж байсан. Тэгээд энэ хорооллынх нь тоогоор авчихсан юм билээ. Тэгээд 10 мянга хүрснийх нь дараа захирагч сонгуулиар томилогдоно гэсэн.

Одоогийн энэ хууль дээр шууд Засгийн газар томилохоор. Тэр хүртэл Засгийн газар томилохоор заасан байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 6 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг намын бүлэг, нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэлх гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж дэмжсэн санал.

1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал болон түүнд нийцүүлэн боловсруулсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус батална.

7.3. Засгийн газар хотод хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийн жагсаалтыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн батална.

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр, барилгажилтын төслийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хотын Зөвлөл тус тус батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Болно.

Нацагдоржийн Батсүмбэр гишүүн үг хэлье.

Н.Батсүмбэрэл: Энэ гүйцээн боловсруулах дээр орж ирж байгаа энэ 7.2 дээр байгаа асуудал байгаа.

Улсын Их Хурал хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг батална гээд байгаа. Их Хурал хотын төлөвлөгөө батлаад байвал энэ их зовлонтой болно. Бүх хотын ерөнхий төлөвлөгөө баталдаг болж хувирна. Цаашдаа энэ процесс нь өөрөө хүндэрнэ.

Тийм учраас үүнийг дэмжихгүй байх нь зохимжтой байна. Засгийн газар өөрөө асуудлаа гүйцэтгэлийн хүрээнд шийдээд явах нь зүйтэй гэж бодож байна.

Ийм учраас энэ саналыг дэмжихгүй байхыг Их Хурлын гишүүддээ уриалж байна.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Өнөөдөр бид 2040 гээд Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө орж ирж байгаа байх аа.

Энэ ерөнхий төлөвлөгөөг яагаад анх 2011 онд санагдаж байна. 2011 онд ингээд Улсын Их Хурлаар баталдаг болсон юм бэ гэж. Өнөөдөр хүн болгоны

толгойд Улаанбаатар хотыг будилуулсан будилаан тарьсан, энэ Улаанбаатар хотын төлөвлөлтийг эвдсэн гэдэг юмыг бид маш сайн мэдэж байгаа шүү дээ. Энэ Улаанбаатар хотын төлөвлөлтийг эвддэг, хэн нэгэн Засаг дарга орж ирэнгүүтээ эвдээд явчихдаг, хэн нэгэн архитектур орж ирээд эвдээд явчихдаг. Үүнийг болиулахын тулд хууль болгож Улсын Их Хурлаар баталж байж бас нэг арга хэмжээ авч байгаа нь энэ шүү дээ. Бид өнөөдөр ингээд л 2040 гээд л Улаанбаатар хотынхоо төлөлтийг Улсын Их Хурлаар батлаад л явж байгаа. Ярилцаад л явж байгаа.

Яг үүнтэй адилхан дараа нь энэ хот Монгол Улсын нийслэл хот болно. Эхнээс нь бид хэлэлцээд явчихъя гэж байгаа юм. Тийм болохоор яг Улаанбаатар хоттой адилхан Улаанбаатар хотын алдааг давтахгүйн тулд дахиад Улсын Их Хурлаараа батлаад явдаг ийм зарчим руугаа орьё гэсэн байдлаар л оруулж ирж байгаа юм. Энд ерөөсөө буруу юм байхгүй гэж бодож байгаа шүү. Хэрвээ шаардлагатай бол дараа нь тэгээд засаад л, энэ хууль чинь ер нь түр хууль болчхож байгаа шүү дээ. 10 жилийн хугацаатай үйлчлэх үү, үгүй юу. Тэгээд тэрний дараа засаад явах нь зүйтэй байх л гэж бодож байгаа.

Тэгэхээр хот өнөөдөр байгаа Хот байгуулалтын тухай хууль дотор орж байгаа Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө батална гэдэгтэйгээ жишгийг адилтгаад энэ Хархорум хотын ерөнхий төлөвлөгөө үзэл баримтлалыг батлаад явъя гэсэн ийм л санал орж ирж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. Ц.Даваасүрэн гишүүн ийм юм. Дэмжсэн болон эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр хоёр хүртэл гишүүн үг хэлнэ ээ гэж байгаа юм.

Тэгэхээр дэмжсэн болон эсрэг байр суурьтай, тэгэхдээ намын бүлгийг төлөөлөөд 2 хүн л гэж байгаа юм.

Тэгэхээр сая Н.Батсүмбэрэл гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн хоёр Монгол Ардын намын бүлгийг төлөөлөөд хоёр хүн гэхэж байгаа байхгүй юу. Өөр бусад нам, эвслийн бүлгээс. С.Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Уг нь энэ төслийг ажлын хэсэг чинь нэлээд ярилцаад л, Байнгын хороо ч ярилцаад баталж ирсэн юм шүү дээ.

Улаанбаатарын, яг одоогийн нийслэлийн алдааг давтахгүйн төлөө аль болох хичээж ажиллаж байгаа.

Тийм учраас энэ төслийг дэмжиж өгөхийг хүсье ээ Та бүхэнд. Одоо бид ингээд л юм болгоныг эсэргүүцээд суугаад байх юм бол суугаад л байна шүү дээ.

Тийм учраас эрхэм гишүүдэд энэ Байнгын хорооноос ирсэнийг дэмжиж өгөхийг хүсье ээ. Төслүүдийг. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Их Хурлын эрхэм гишүүд маань энэ Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай гэж байгаа.

Тэр “төлөвлөлт” гэдэг үгийг сүүлд энэ зарчмын зөрүүтэй саналаар нэмээд явж байгаа юм. “Төлөвлөлт” гэдэг үг бол “шилжилтийн” гэсэн санааг агуулж байгаа гэдгийг ажлын хэсэг дээр олон дахин ярьсан байгаа юм.

Өөрөөр хэлбэл нэг далайлтаар энэ хууль гараад он удаан жил явна гэхээсээ илүүтэйгээр 2050 алсын хараанд орсон нийслэлийн баримжаатай гэдэг. Хэрвээ нийслэл хот болгоно гэхээр Үндсэн хуулийг өөрчлөх шаардлагатай болчихоод байгаа учраас тэр хүртэлх буюу одоо ингээд “төлөвлөлтийг хийнэ” гэдэг агуулгаар ийм “шилжилтийн” гэдэг санаа орж байгаа юм

Хоёрдугаарт, та бүхэн 1.1-ийг нэг сайн уншаад өгөөч ээ гэж хүсмээр байгаа юм. Энэ хуулийн зорилт нь “түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж” гэсэн үг байгаа юм.

Энэ ямар утгатай вэ гэхээр ер нь ирээдүйд нийслэлийн баримжаатай гэдгийгээ л хэлж байгаа. Дээрээс нь монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах гэсэн.

Тэгэхээр “Монгол үндэстний түүх” гэдэг нь тэнд олон хот, балгадууд байгуулагдаж, улс үндэстэн, гүрэн улсууд эмхлэгдэн байгуулж цэгцэрч байсан гэдэг утгаараа энэ бас геополитикийн шинжийг агуулж байгаа юм. Энэ нь цаад утгаараа сая Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэнчлэн бас энэ нийслэл гэдэг санаа агуулагдаад явж байгаа.

Үүний араас тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийг тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчин орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэсэн байгаа юм.

Тэгэхээр хэдүүлээ бас нэг юмыг ялгаатай харах ёстой. Концепц буюу үзэл баримтлал гэдэг бол, аливаа хуулийн үзэл баримтлал гэдэг бол тухайн хууль яагаад батлагдах гэж байгаа юм бэ, яагаад нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой юм бэ, ямар чиглэл хүрээнд үйлчлэх юм бэ. Гол философийг нь тодорхойлдог.

Тэгэхээр манай энэ хуулийн өөрийнх нь үзэл баримтлал болбол хуулийн үзэл баримтлал шүү. Хотын төслийн гэж яриагүй. Хуулийн үзэл баримтлалыг энэ 1.1 дээр оруулсан юм байгаа юм шүү.

Харин тэр төслийн үзэл баримтлал бол энэ хууль батлагдсаны араас мөнгө санхүү зарцуулагдаад техник, эдийн засгийн үндэслэл нарийвчлагдаад, одоогийн байгаа тэр 37 янзын концепц буюу 37 янзын уралдаанд ирсэн материал дундаас зарим нэгийг нь аваад, авах гээхийн ухаанаар хэмжээд, ирээдүйд нийслэлийн баримжаатай гэдэг шалгуураа тогтоогоод тусдаа гарах байгаа юм.

Тэр утгаараа яах вэ гэхээрээ хууль гарч байж араас нь концепц буюу үзэл баримтлал батлагдана.

Одо улсын чанартай хуулиуд дээр Засгийн газар үүнийг тогтоох байгаа. Зөвхөн нийслэлийн үзэл баримтлалыг Их Хурлаар тогтоох байгаа гэсэн ялгаануудыг нь Та бүхэн олж хараарай гэж хүсье.

Ингээд энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байгаа. Улсын Их Хурлын гишүүд Та бүхэн яг энэ үгийн нюанс буюу яг тэр үг зүй талаас нь энэ ямар ямар агуулга ард нь орсон юм бэ гэдгийг сайн анзаарч дэмжиж саналаа өгөөсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байна.

Гэхдээ энэ хууль бол ердийн хууль биш. Энэ хууль бол XXI зууны хоёр дахь хагасын Монгол Улсын өнгө төрх, өрсөлдөх чадвар, дээрээс нь хөгжил дэвшил, бүсчилсэн хөгжил, дээрээс нь технологи, инновацийн цоо шинэ шийдэл, ая тухтай Үндсэн хуулийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан, нөгөө талаасаа Монгол үндэстний түүхэн гал голомт бөгөөд бахархалыг тээсэн, тэтгэсэн ийм хөгжил дэвшлийн хууль байх болно гэж үзэж байгаа юм.

Тийм учраас бүхнийг багтаах, чихэх боломжгүй учраас “төлөвлөлт” гэдэг байдлаар “шилжилтийн” байдлаар оруулж байгаа гэдгийг Та бүхэн мэргэн ухаандаа тунгааж дэмжиж өгөөсэй гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэлж дууслаа.

Ингээд зарчмын зөрүүтэй саналаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

42 гишүүн. 44.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.2 дахь хэсэг болгох:

“17.2.Энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Цэрэнпилийн Ц.Даваасүрэн гишүүн үг хэлье. Дараа нь Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье.

Тэгэхээр одоо энэ төлөвлөлтийн асуудлууд, энэ төр, хувийн хэвшлийнхний оролцоо энэ тэр гээд бүгдийг нь хийхийн тулд бид одоо энэ чинь ажил нь эхэлчихсэн явж байгаа юм.

Би одоо энэ ажлыг эхлүүлсэн хүний хувьд хэлэхэд хөрсний судалгаа, геодезын судалгаа нь хийгдээд явж байгаа. Үүний дараа нь газрынх нь төлөвлөлтүүд явагдаж эхэлнэ. Хаана ямар барилга байгууламж байх юм гээд.

Тэгэхээр бидний өмнө явж байсан концепцоор бол энэ чинь ер нь нийслэлийн чиг баримжаатай болох чиглэл рүү байсан байхгүй юу. Одоо Ерөнхийлөгчийн ордон тэнд баригдана, энд Засгийн газрын байгууллагууд байна гээд.

Одоо аялал жуулчлалын чиг баримжаатай гээд хуульчлаад өгчих юм бол төрийн байгууламжуудыг төлөвлөх асуудал чинь хуультайгаа зөрчилдөөд эхэлнэ.

Тэгэхээр энэ асуудлуудаа Та бүгд зохицуулсан байдлаар хийхгүй бол аялал жуулчлалын гэж явснаа үсрээд нийслэлийн чиг баримжаатай болох юм гэж үзэх юм бол тийм худлаа юм байхгүй шүү.

Тийм учраас эхнээс нь энэ хотынхоо хөгжлийн ерөнхий концепцыг зөв гаргаж тэр төлөвлөлтүүдээ хийж явахгүй бол болохгүй ээ. Яриад байгаа нь зөв мөртлөө хийгээд байгаа үйлдэл чинь бас буруу харагдаад байна.

Тийм учраас эхнээсээ энэ хөгжлийнх нь концепцыг зөв гаргаад, дараа нь төлөвлөлтүүд явах ёстой. Ингэж явж ирсэн юм.

Хоёр асуудал үүссэн юм. Аялал жуулчлалын чиг баримжаатай байх юм уу, ер нь энэ хөгжлийн төв байх юм уу гэдэг асуудал. Тэгээд бид хөгжлийн төв байх юм. Энд төр, захиргааны удирдлагууд хүртэл шилжих юм гэж явж байснаа одоо аялал жуулчлалын чиг баримжаатай гээд явчхаж байгаа юм.

Тэгэхээр та нар хуулийн үг гэдгийг зүгээр ингээд дараа нь болчихдог юм гэж ойлгож болохгүй. Тийм болчих юм бол тэр чиглэлээр төлөвлөлтүүд явагдах

болно. Тэгээд энэ асуудлуудыг эхнээсээ сайн анхаараарай гэдгийг хэлье. Яагаад гэвэл дараагийн хурал дээр ахиад л өөрчлөөд, дараа орж ирэхээр ахиад өөрчлөөд яваад байж болохгүй шүү дээ.

Яагаад гэвэл бид энд хөрөнгө оруулалт татна, гаднынхныг оролцуулна. Гэтэл гаднынхан чинь гайхна шүү дээ. Сая хөгжлийн концепц боловсруулах олон улсын тендер өнгөрсөн 7 сард болсон. Тэгэхдээ бид ерөнхийдөө энэ чинь Монгол орны хөгжлийн төв болж хөгжих юм гэж ярьсан.

Одоо гэтэл аялал жуулчлал болох юм гэнэ гээд Их Хурал нь шийдчихжээ гэвэл тэр улсууд чинь гайхаж эхлэх байхгүй юу. Одоо тэд нар чинь 7 компани шалгаруулаад бид ажлынх нь чиг хандлагуудыг нь тодорхойлоод өгчихсөн байгаа шүү дээ. Ийм хот болж хөгжих юм шүү. Та нар ажлын даалгаврын дагуу наад концепц боловсруулаарай, бэлдээрэй гээд явж байгаа.

Гэтэл төр нь ороо бусгаа шийдвэрүүд гаргаад байх юм бол ялангуяа тэр олон улсын бидний энэ хотын хөгжлийн концепц боловсруулах гэж байгаа компаниудын хувьд тун сонин байдал үүсэж болзошгүй шүү гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

С.Бямбацогт: Энэ 17.2 дахь хэсгийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар зохицуулна гэж өөрчлөх гэж байгаа юм байна.

Тэгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль маань их хатуу хүнд сурталтай, ажил явуулахгүй ийм хууль болчихсон. Урьд нь би Зам, тээврийн сайд байхдаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн өмнөх хуулиар Туулын хурдны замыг концессоор BOT_[build-operate-transfer] нөхцөлөөр үндсэндээ төсвөөс мөнгө гарахгүйгээр шийдэх энэ ажлыг явуулж байсан. Олон компанид оролцоод явж байсан.

Монгол Улсын баруун, зүүн, одоо, өмнөд, хойд бүсүүдэд олон улсын нисэх онгоцны буудал байгуулах. Ганцхан Улаанбаатараас гадагшаа олон улс руу нисдэггүй болгох асуудлыг шийдээд тодорхой асуудал явж байсан.

Мөн Яармагийн наадамчдын зам дээгүүр дүүжин гүүр барих асуудал яриад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар төсвөөс ямар ч дарамт шахалтгүй гаднаас зээл авахгүйгээр хувийн хэвшлийнхээ өөрсдийн хөрөнгөөр барих ийм асуудал явж байсан.

Гэтэл энэ юмыг гацаасан асуудал бол энэ Төр, хувийн хэвшлийн шинэ хууль. Одоо мөрдөгдөж байгаа. Яг үүнтэй адилхан бид Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулъя, дээрээс нь эртний нийслэл Хархорум хотоос сэргээе гээд шинэчлэгдэж байгуулъя гээд том бодлого, том зорилго тавиад явж байдаг. Гэтэл үүнийг чинь төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар зохицуулна. Үүнд

тийм үү хувийн хэвшлээр гүйцэтгэхтэй холбоотой харилцааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр. Энэ чинь том гацаа тээг болох юм биш үү.

Уг нь энэ хууль дээр сайн заалт орж ирсэн байгаа юм. 5 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулсан хувийн хэвшил татварын болон татварын бус хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх гээд. Гэтэл энэ чинь ингээд л Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар ингээд л гацаа дэгээ болоод явчих байх даа. Энэ зайлшгүй ингэх шаардлагатай байсан уу? Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, сааруулах Улаанбаатар гэсэн ганцхан таталцалтын төвтэй биш, баруун бүстэй, зүүн бүстэй, төвийн бүстэй, хойд бүстэй, говийн бүстэй тийм олон улсын чанартай хотуудтай болох энэ бодлогын эхлэл бол Хархорум хот. Энэ бодлого маань хуулиараа гацчих юм биш байгаа? Үүнийг бодсон уу? Үүнийгээ яагаад оруулж ирсэн юм бол?

Одоо зөвхөн суманд ярихад олон аймаг тойрсон олон сумтай болчихсон. Завхан аймгийн Алдархаан сум гэхэд 3 мянган хүн амтай бүртгэлтэй мөртлөө яг амьдарч байгаа нь мянган хүн ам амьдардаг. Ихэнх нь аймгийн төвдөө амьдардаг. Сургууль нь 93 хүүхэдтэй. Завханы Яруу сум гэхэд 1500, 1800 орчим хүнтэй гэсэн мөртлөө сумын төвд нь 100 хүрэхгүй өрх амьдардаг. Сургууль нь 90 хүүхэдтэй. Тэгсэн мөртлөө төрийн захиргааны бүх байгууллага байдаг. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг байдаг. Маш их үргүй зардал гардаг. Ховдод ч ялгаа байхгүй. Аймгийн төвөөс 40 километр байж байгаа сум нь 3 мянган хүн амтай, 400 хүүхэдтэй сургуультай байж болоод байдаг. 60 километр байж байгаа сум нь 2 мянга хүрэхгүй хүн амтай. Сургуульд нь 100 гаруйхан хүүхэд сурдаг. Энэ яагаад гэхээр ерөөсөө тэнд таталцлын төв алга. Тэнд дэд бүтэц алга. Ард иргэд нь аятай тухтай амьдрах орчин нөхцөл алга. Тийм болохоор хаана дэд бүтэц хөгжсөн байна, хаана таталцлын төв бий болж байна тэр лүү тэмүүлээд байна.

Тийм болохоор л бид Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвийг задалъя гэж байгаа. Хархорум. Цаашлаад бусад аймгууд бүс нутаг бүртээ. Цаашлаад энэ маань цааш жижигрээд аймгууд руу орохоороо сумуудыг ч гэсэн ийм байдлаар шийдэх ёстой. Зах зээлийнх нь жамаар дэд бүтцийг нь шийдэж өгөөд таталцлын төвийг бий болгоод өгөх юм бол энэ жижиг сумууд чинь аяндаа алга болно. Тийм.

Энэ бодлого маань үндсэндээ Хархорум хот дээр томоор эхлээд явж байдаг. Гэтэл буцаагаад ажлын хэсэг дээр, Байнгын хороон дээр энэ хүнд сурталтай хуулиар явна гэх юм бол энэ Хархорум хотыг цаашаа хөгжүүлэх, хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулах, олон улсын нисэх буудал баримаар байна, авто зам баримаар байна, төмөр зам баримаар байна, эрчим хүчний цахилгаан станц баримаар байна. Энэ бүхэн чинь бүгдийг нь төсөв дааж чадахгүй, гаднын зээл тусламж чадахгүй. Хувийн хэвшлийнхний сонирхлыг оруулж байж энэ бүтээн байгуулалт хийгдэнэ.

Гэтэл Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль чинь аягүй хүнд сурталтай модон хууль болчихсон байгаа. Үүгээр явах чинь зөв үү? Энэ саналыг би дэмжихгүй байна.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Биш ээ. Яах билээ. 2 болчихсон. Нэг намын бүлгийг төлөөлж 2 гишүүн. Өөр намын бүлэг, бүлэгт харьяалаагүй гишүүдээс үг хэлж болно гэж байгаа юм.

Санал хураалт руу орно. 2 дахь санал дээрээ явж байна. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

44.2 хувиар санал уналаа.

Б.Тулга гишүүн наад санал хураалтдаа жоохон анхаарал тавьж байгаад ор. За юу. Өөр юманд анхаарч байгаад л тэгээд л дараад нь гар өргөөд л горимын санал гаргана гээд л явах юм.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн горимын санал.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ нөгөө доороо нэг улаан бичиг гардаг нь улаан бичиг нь гараад явчихлаа. Юу ажилласангүй. Төхөөрөмж ажилласангүй тул санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Энэ санал хураалт чинь ер нь зүгээр түрүүчийнхээ санал хураалттай адилхан л дүн гарч байна шүү дээ. Ер нь дэмжихгүй байгаа саналууд чинь унаад байгаа юм биш үү.

Энэ Байнгын хороо, ажлын хэсэг дээрээ ер нь сайн ярьсан юм байгаа биз дээ. Юмнудаа.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох нэг санал хураалт явуулж үзье. Санал хураалт. /алх цохив/

Горимын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хурааж дэмжсэн санал.

3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний өмнө “иргэн,” гэж нэмэх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.
/алх цохив/

52.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5.13 дахь заалтын “өмчийн болон” гэснийг мөн заалтын “удирдлагыг томилох, чөлөөлөх,” гэснийг хасах.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.
/алх цохив/

56.8 хувиар санал дэмжигдлээ.

Даваагийн Цогтбаатар гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. 4 дэх санал хураалт дээр.

5.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5 дахь хэсгийн “эзэмших” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. О.Батнайрамдал гишүүн үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Яах вэ, энэ бас түүхэн ач холбогдолтой хууль маань ингээд эцэслэн батлагдах гэж байна. Тэгээд миний хувьд 4 ач холбогдолтой зүйл байгааг энэхүү өнөөдөр намрын чуулганы сүүлийн өдөр ийнхүү батлагдах гэж байна.

Тэгэхээр энэ дээр хэлчихье гэж бодож байгаа юм. Энэ Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсанаараа нэгдүгээрт үнэхээр л тэртээх 800 жилийн өмнөх Монголын эзэнт гүрний мартагдсан түүхийг дахин амилуулах бүтээн байгуулалт болно гэж бодож байгаа юм.

Тэгэхээр үнэхээр л олон 100 жилийн өмнө дэлхийн бодлогыг тодорхойлж, олон улсын худалдааны цөм болон цогцолж байсан эртний нийслэл Хархорум хотын түүхийг сэргээж, шинэ бүтээн байгуулалт хийж байгаа нь Монголын хүчирхэг эзэнт гүрний мартагдсан түүх, нүүдэлчдийн соёлыг дахин амилуулж хойч үедээ үлдээж байгаа бидний өв болох учиртай гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, эдийн засаг талаасаа аваад үзсэн ч гэсэн эдийн засгийн төрөлжилтөд бас нэг тулгуур эрсдэл болох ёстой салбар бол яалт ч үгүй тогтвортой аялал жуулчлал байгаа юм.

Тэгэхээр аливаа улс эдийн засаг өрсөлдөх давуу тал дээрээ тулгуурлаж хөгждөг.

Тэгэхээр Монгол Улсын хувьд энэ уурхайгаас гадна аялал жуулчлалын салбар нь эдийн засагт өрсөлдөх давуу талтай тэргүүлэх салбар мөн. Урт хугацааны хөгжлийн бодлого дээрээ ч бас тусгасан байгаа юм.

Тэгэхээр дэлхийд танигдсан брэнд түүх байна. ЮНЕСКО-д бүртгэлтэй Орхоны хөндий сан нутаг бол тогтвортой аялал жуулчлалын эдийн засгийн гол тулгуур болон хөгжүүлэх өрсөлдөх давуу талын түүхэн өгөгдөл яалт ч үгүй мөн.

Тэгээд дахиад уул уурхайн салбартай харьцуулахад ажлын байрыг илүү олноор бий болгож бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах ийм хот болох учиртай.

Гуравдугаарт, мөн дэвшилтэт технологид суурилсан, байгаль орчинд ээлтэй, мөн дэд бүтцийн цогцоор шийдсэн ухаалаг ногоон хот бий болгох цаг нь үнэхээр л болсон гэж үзэж байгаа.

Тэгэхээр иргэдийн ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг хангаж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, мөн сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжсэн ногоон байгууламж бүхий ухаалаг дэд бүтэц бүхий энэ Хархорум хот бол дараа дараагийн бүтээн байгуулалтад загвар болоосой гэж бодож байгаа юм.

Тэгээд хамгийн сүүлд нь өнөөдөр гишүүддээ хандаж хэлэхэд Монгол Улсын ирээдүйн хөгжил эв нэгдлийн баталгаа болох бүтээн байгуулалт гэж харж байгаа юм. Яагаад гэхээр өнөөдөр 5 улс төрийн хүчний төлөөлөл бүхий 126 шинэ парламент байна. Энэ шинэ парламентын 4 улс төрийн нам, тэр дундаа Монгол Ардын Нам, Ардчилсан нам, ХҮН нам, мөн Үндэсний эвсэл 2024 оны сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгасан нийтлэг нэг зорилт нь өөрөө Хархорум хотын бүтээн байгуулалт байсныг санал санал хураалтын өмнө онцлох нь зүйтэй гэж бодож байгаа юм.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 230 дугаар зарлигаар чиглэл болгосон, Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан энэхүү хуулиа эцэслэн батлахыг эрхэм гишүүд Та бүхээсээ энэхүү завшааныг ашиглаад хичээнгүйлэн хүсье гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Манай О.Батнайрамдал гишүүн суудал дээрээсээ хэвлэлийн бага хурал хийчих шиг боллоо.

Хэлэлцэж байгаа саналтай холбоотой дэмжсэн, эсрэг байр сууриа илэрхийлэх дэгтэй. Тэгэхээр энэ дэгээ сайн барьж ажиллана шүү.

5 дахь санал хураалт дээр явж байгаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

53.7 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хурааж дэмжсэн санал.

1.Төслийн 2, 3 дахь заалтыг хасаж, 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуультай нийцүүлэхээр Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.
/алх цохив/

59.4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.
/алх цохив/

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Дөрөв.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт,
хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан
Улсын Их Хурлын тогтоолын төслүүд
/Байнгын хорооноос боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг/**

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна.

Индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд өөрчлөлт олгох, оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулсан 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг баримтлан тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028

оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: С.Зулпхар гишүүндээ талархал дэвшүүлье.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 8 гишүүн байна. Асуулт асууя.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Өмнөх юун дээр ажлын хэсгээс асуусан асуулттай давхцаж байгаа учраас асуултаа татлаа.

Д.Амарбаясгалан: Агваанлуvsсангийн Ундраа гишүүн асуулт асууна. Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Асуулт давхацсан байна. Өмнөх асуудалтай хамт хэлэлцэж байгаа учраас өмнөх асуудал дээр гишүүд маань асуултаа өргөн хүрээгээр асуусан.

Эхлээд гишүүд асуулт авч, асуулт асууж, хариулт авч явах процесс ингээд дуусаж байна. /алх цохив/

Одоо Байнгын хорооноос Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр батлах горимын санал.

Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Одоо энэ Байнгын хорооноос, Их Хурлаас ингээд тогтоолын төсөл оруулж ирээд байна шүү дээ. Тийм ээ.

Энэ дээр би нэг зүйлийг анхааруулж хэлье гэж бодоод байгаа юм. Яг хэн санаачилчихсан юм, үүнийг. Байнгын хороо гээд байгаа байхгүй юу. Байнгын хороо санаачилна гэж байхгүй шүү дээ. Хууль санаачлах гуравхан субъект байна. Их Хурлын гишүүн, эсвэл Ерөнхийлөгч, Засгийн газар.

Хэрвээ Байнгын хороо, Их Хурал тогтоолын төсөл санаачилж байгаа бол ажлын хэсэг байгуулаад Их Хурлын гишүүдээр санаачлуулах ёстой.

Түүнээс биш Тамгын газар нэг хуулийн төсөл маягийн юм бичиж оруулж ирэнгүүт нь Байнгын хороо хуралдаад тэгээд тэрийгээ Их Хурал санаачилсан гээд байх юм. Тийм юм байж болохгүй шүү дээ. Наадах чинь Цэцэд очих юм бол шууд унана. Байнгын хороо санаачилна гэж байгаа чинь ажлын хэсэг байгуулж Их Хурлын гишүүдээр санаачлуулахыг хэлж байгаа юм. Их Хурлын тогтоол ч бай бас тэгнэ.

Тэгэхээр ямар ажлын хэсэг байгуулагдаж наад саяын энэ тогтоолыг чинь боловсруулав гэдэг асуудал гарна шүү дээ. Цаашдаа энэ зүйлийг анхаараач ээ гэж би энэ саналыг хэлж байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Тийм. Ер нь их чухал зүйл хөндөж байна л даа. Яг Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхтэй холбоотой асуудал яригдаж байгаа.

Ажлын хэсгийн дарга Г.Тэмүүлэн гишүүн энэ дээр зүгээр тайлбар хийгээдэхье. Түүнээс асуулт хариулт явж байгаа горим биш шүү. Өргөн баригдсан хуулийн төслүүдтэй холбоотой горимын санал гарч байна. Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Би энэ дээр тайлбар мэдээлэл өгөх нь зөв байх.

Тэгээд Улсын Их Хурлын даргын 2025 оны 01 сарын 02-ны 01 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан.

Тэгээд нийтдээ манайх 23 Улсын Их Хурлын гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаад, сая сүүлийн 10 гаруй хоногийн хугацаанд ажиллаад, хуулийн төсөл дээр ажилласны үндсэн дээр энэ хуулийн төсөл маань анх орж ирэхдээ Хархорум хотын гэж явж байгаа юм.

Тэгэхээр нь бид энэ хуулийнхаа төсөлтэй нийцүүлэх үүднээс бусад хууль тогтоомжууд болоод тогтоолууд дээр байгаа нэршлүүдийг нийцүүлэх шаардлагатай байна гэж үзээд саяын энэ 5 тогтоолын төслийн нэрийг нь өөрчлөх энэ санаачилгыг ажлын хэсгээс гаргаад зөвхөн “шинэ” гэдэг үгийг хасаад явж байгаа.

Тэгэхээр хууль тогтоомжтой нийцүүлэх ажлыг ажлын хэсэг хийсэн. Энэ хүрээндээ энэ тогтоолын төслүүдийг оруулж ирж байгаа л гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Ингээд сая Ц.Даваасүрэн гишүүний хэлсэн асуудлыг манай Байнгын хорооны дарга нар, Их Хурлын Тамгын газар онцгой анхаарах ёстой. Хууль, тогтоолын төслүүдийг санаачлах эрх бүхий субъект юм бэ гэдэг дээр их тийм нюанстай зүйл асууж, бас горимын санал гаргаж хэлж байна шүү дээ.

Байнгын хороо гэсэн нэр яваад байдаг. Яг хууль дээр Байнгын хороо санаачилна гэсэн нэг ширхэг ч заалт байхгүй л байж байна шүү дээ. Тийм ээ. Энэ бол их чухал санал гарлаа. Мэдээж Байнгын хороо гишүүдээрээ дамжуулж энэ асуудлаа шийдээд явах нь зүйтэй.

Ингээд Байнгын хорооноос “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” зэрэг, “Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” зэрэг Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлах ийм горимын санал гарч орж ирсэн байна.

Тэгэхээр энэ горимын саналыг эхлээд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах юм байна.

Эдийн засгийн байнгын хороо дуусаагүй байна уу? Бусад гишүүдийг санал хураалтад орж ирэхийг урьж байна. Одоо энэ санал хураалтын араас хуулийн төслүүдийг эцэслэн батлах 10 санал хураалт байгаа. Ирц хангалттай гэж үзвэл өнөөдөр санал хураалт явуулна. Хангалтгүй гэж үзвэл Баасан гарагийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар санал хураалт явуулна.

Тэгэхээр энэ ирц бүртгэлд байгаа гишүүдийг санал хураалтад орж ирж оролцохыг хүсэж байна. Тэгээд Байнгын хороонд байгаа 12, 13 гишүүн байгаа юм байна. Байнгын хорооны хурал дуусчихвал ирц хангалттай болох байх гэж бодож байна.

Гишүүдэд мэдээлэл хүргэе.

Эдийн засгийн байнгын хороо түр завсарласан байна. Одоо санал хураалтууд явуулъя. Бусад гишүүдэд мэдээлэл хүргэе. Дараагийн асуудал хуулийн төслийг эцэслэн батлах 10 төсөл байгаа.

Анхны хэлэлцүүлгээр батлах горимын саналыг Байнгын хорооноос гаргасан.

Тэгэхээр Байнгын хорооноос гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд ээ, О.Батнайрамдал, Ч.Анар гишүүд суудалдаа сууя. Анхаарлаа төвлөрүүлцгээ. Санал хураалтууд явж эхэлнэ.

Тэгэхээр Байнгын хорооны горимын саналаар анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.4 хувиар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй хамт батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

Тав.Хуулийн төслүүдийг эцэслэн батална

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Эцэслэн батлуулах хуулийн төслүүдийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Тэгэхээр нийт гишүүдийн 64-өөр хуулийн төслүүд батлагдана эцэслэн батлагдана.

Эхлээд ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

63 гишүүн бүртгэлд орсон байна. Бүртгэлд орж амжаагүй хэдэн гишүүн байна. 1, 2, 3. 66 гишүүн байна гэсэн үг байна шүү дээ. 68 гишүүн.

Санал хураалтаа эхлүүлье.

1.Хархорум хотын төлөвлөлт бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

65 гишүүн буюу 67.7 хувиар санал дэмжигдлээ.

О.Батнайрамдал, Сүхбаатарын Эрдэнэбат, Загджавын Мэндсайхан нарыг дэмжсэнээр бүртгэлд авъя. Даваагийн Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя.

Хамт өргөн мэдүүлсэн.

2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/-ийг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67 гишүүн буюу 69.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

65 гишүүн буюу 67.7 хувиар санал батлагдлаа.

4.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

68 гишүүн буюу 70.8 хувиар дэмжигдлээ.

5.“Хархорум” хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

69 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Холбогдуулан боловсруулсан.

6.“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.7 хувиар санал дэмжигдлээ.

7. “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

62 гишүүн буюу 64.6 хувиар.

8. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Б.Дэлгэрсайхан сайд дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. С.Замира гишүүн дэмжсэнээр протоколд.

Нийт 65.6 хувиар санал дэмжигдлээ.

9. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.8 хувиар санал дэмжигдлээ.

10. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

74.0 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа. Үдээс хойших хуралдаан 14.00 цагтаа эхэлнэ. /алх цохив/

**Зургаа. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж,
ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Д.Амарбаясгалан: Гишүүд танхимд орж ирье. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Өнөөдөр үдээс өмнө Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна.

Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, цар тахлаас хойш хурдтай өсөж буй эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахын тулд Монгол Улсын Засгийн газраас 14 мега төслийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулахад үндсэн анхаарлаа хандуулж, үе шаттай ажиллаж байна.

▶ **2021 онд 43 их наяд** төгрөг байсан Монгол Улсын эдийн засгийн багтаамж, дотоодын нийт бүтээгдэхүүн

▶ **2024 оны төгсгөлд 82 их наядад** хүрч **“хоёр дахин тэлсэн”** нь чамлахааргүй өсөлт боловч цаашид эдийн засгийг тогтвортой тэлэхийн тулд, эдийн засгийн шинэ бүтцийг бүрдүүлэхийн тулд

- ▶ хүний нөөц,
- ▶ хиймэл оюун ухаан,
- ▶ дэвшилтэт технологи,
- ▶ ногоон шилжилтийг хийж,

хөрөнгө оруулалт бизнесийн орчныг эрс сайжруулах шаардлагатай байна.

Өчигдрийн Засгийн газрын хуралдаанаар **“Бизнес ээлтэй Монгол”** буюу **“Business friendly Mongolia”** хөтөлбөрийг хэлэлцэж, Бахрейн Улсын жишгээр

- ▶ эдийн засгийг төрөлжүүлэх,
- ▶ хөрөнгө оруулалтыг дэмжих,
- ▶ бизнесийн орчныг сайжруулах

туршлага дээр үндэслэн хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоол баталж Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн зөвлөлд “олон улсын экспертүүд”-ийг урьж ажиллуулах улс төрийн шийдвэрийг гаргалаа.

Дэлхийд үнэлэгдсэн шилдэг мэргэжилтнүүдийг Монгол Улсад урьж ажиллуулахад “алт, мөнгө, хүрэл гэрэгэ” өгч байхаар энэхүү тогтоолд мөн тусгагдсан болно.

Өмнө нь бид Эстони Улсын цахим шилжилтийг сайн туршлагад үндэслэн “e-mongolia” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж чадсан шиг “хөрөнгө оруулалт, татварын орчин, бизнес эрхлэхэд бүртгэлээс эхлээд дампуурах хүртэлх эрх зүйн орчин, маргаан шийдвэрлэх процесст” цогц байдлаар дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурлын хаврын чуулганд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Бизнесийн орчныг сайжруулахад нэгдсэн зорилтын хүрээнд төрийн өмчийн компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өнөөдөр ийнхүү өргөн барьж байна.

2012 оноос хойш OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон бизнес төлөвлөгөө, санхүүгийн гүйцэтгэлийн оновчгүй байдал, улс төрийн нөлөө бүхий томилгоо, хүний нөөцийн бүтээмжгүй байдал зэргээс шалтгаалж нийт төрийн өмчийн компанийн 44 хувь нь засаглалын хямралд орж, 120 гаруй төрийн өмчийн компани үйл ажиллагаа явуулж байгаа боловч 10 компани нь нийт ашгийн 85 хувийг бүрдүүлж байна.

Харин 43 хуулийн этгээд нь алдагдалтай ажиллаж байна.

Өмнө нь энэхүү хуультай адил төстэй 3 ч удаагийн хуулийг боловсруулан Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн барьж хэлэлцүүлсэн боловч төрийн өмчит компаниудын лоббид хөтлөгдөж, эрх зүйн орчныг шинэчлэх реформ бүтэлгүйтэж байсан гэдгийг өнөөдөр онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Холимог тогтолцоогоор бүрдсэн 126 гишүүнтэй шинэ парламент хөгжлийн томоохон төслүүдийг гацаанаас гаргаж, хөдөлгөж чадсан шиг энэ удаа төрийн өмчийн компанийн засаглалд өмнө нь хийгдэж байгаагүй далайцтай реформыг хийж түүхэн үүргээ гүйцэтгэж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Энэ хууль батлагдсанаар төрийн өмчийн компанийн засаглалд тавигдах шаардлагыг OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын олон улсын зарчимд нийцүүлж, уул уурхайн компаниуд **“ЭРДЭНЭС МОНГОЛ”** нэгдэлд, уул уурхайн бус компаниуд **“ЭРЧИС МОНГОЛ”**

нэгдэлд нэгтгэхээр зохион байгуулагдаж, олон улсын удирдлагын тогтолцоонд шилжүүлж, компаниудын үр ашиг, үнэлгээг эрс сайжруулах төлөвлөгөө юм.

OECD буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зарчимд нийцээгүй бол тус компаниудыг нэгтгэх, татан буулгах, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, эсвэл нийтийн үйлчилгээний байгууллага болгон өөрчлөн зохион байгуулахаар энэ хуульд тусгалаа.

Энэ зохион байгуулалт хийгдсэнээр төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, чиг үүргийн давхардал, зардлыг бууруулж, цаашид төрийн өмчийн компанийн тоог хоёр дахин бууруулах болно.

Нэг үгээр хэлбэл үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөхүйц, стратегийн хувьд ач холбогдолтой, хувийн хэвшилд шилжүүлэх боломжгүй төрийн өмчит компаниудыг олон улсын засаглалын зарчимд нийцүүлж, бусад компанийг энэ хуулиар өөрчлөн зохион байгуулна гэсэн үг юм.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг уншиж танилцуулна.

Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журам, ангилал, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хяналт, удирдлага, зохион байгуулалт, төрийн болон орон нутгийн өмчит хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах, компанийн сайн засаглал, ил тод байдлыг сайжруулах, санхүүгийн ашигт ажиллагаа, өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ.

Зардлын тооцооллын судалгаанаас үзэхэд энэхүү хууль батлагдсанаар Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэх боловч төрийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн нөлөө үзүүлэхгүй.

Харин төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгжийн ачаалал нэмэгдэх төлөвтэй байна.

Компанийг үүсгэн байгуулахдаа тооцоо судалгаанд үндэслэх, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн оролцоонд тулгуурлаж шийдвэр гаргах, засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, цаашлаад гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажлын гүйцэтгэл, компанийн бизнес төлөвлөгөө, үндэслэл, шаардлага, үр өгөөжийг үнэлэх, хянах тогтолцоог сайжруулах нь дээрх компаниудын үр өгөөжийг ихэсгэх, алдагдлыг бууруулахад чухал нөлөөтэй.

Иймд дээр дурдсан зардлыг хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү байна гэж үзлээ.

Хуулийг “D-Parliament” цахим сайтад байршуулж иргэд олон нийтээс санал авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл хуулийн зорилго амьдрал дээр хэрхэн хэрэгжих талаар, төрийн өмчийн компанийн нээлттэй байдлыг хэрхэн сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд орон нутгийн өмчит уул уурхайн компаниудад үүсэх асуудал, засаглалыг хэрхэн сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг “Эрдэнэс Монгол” компанийг анх ямар зорилгоор байгуулж, үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний талаар, “Эрчис Монгол” компанийн статусын талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг өмчийн эрх зүй талаас нь хууль зүйн дүгнэлтийг анхаарах, цаашид хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороотой хамтран хэлэлцүүлэгт бэлтгэх, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар компанийг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хуульд 50 хувь байх талаар, аудитын тайланг жил бүр олон нийтэд ил тод мэдээлэх, ашигт ажиллагаа, хариуцлага сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр бие даасан Төрийн өмчийн компанийн тухай хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд төрийн өмчийн компанийн засаглалын стандартыг сайжруулах асуудлыг энэхүү хуульд тусгах эсэх асуудал, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай хамтатган шийдвэрлэх, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороотой хамтран уг хуулийг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин төрийн өмчийн компанийн оролцоог багасгах, төсвийн хэмжээг бууруулах талаар хуулийн харилцааг Компанийн тухай хуульд зохицуулах дутагдалтай тал байгаа учраас энэхүү хуулиар харилцааг зохицуулах нь зүйтэй талаар, өмнө нь хэрэгжиж байгаа

хуулиудын хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хуулийн төслийн зарим зүйл, заалтыг нэр томъёо дахин нягтлах, хуульд авлигал, шүгэл үлээгчийн хамгаалах заалт орсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн төрийн өмчит үйлчилгээний салбарт хувийн хэвшлийг түлхүү оролцуулах талаар асуулт асууж хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд компани байгуулах үндэслэл шаардлагыг тодорхой болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг “Эрчис Монгол” компанийг байгуулж эрчим хүчний компаниудыг нэгдсэн үйлдлээр хангах нь хэр оновчтой байх талаар анхаарах, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг төрийн өмчийн компанийн засаглалыг сайжруулах, улс төржилтөөс ангид байлгах чиглэлээр, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн орон нутгийн эрх мэдлийг сааруулахгүй байх талаар хуулийн төсөлд хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр заалтуудыг нэмэх талаар хуулийн төслийн үзэл баримтлалыг хүрээнд хэлэлцэхийг дэмжиж үг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн бүтээмжийн ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай болон Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэх эсэх асуудлаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: П.Сайнзориг гишүүнд баярлалаа.

Уг хуулийн төсөл даргын дэргэдэх зөвлөл дээр хэлэлцэгдээд 3 цагийн хугацаанд хэлэлцэхээр шийдвэрлэгдсэн. Энэ хүрээнд нийтдээ 30 гишүүн асуулт асууж, хариулт авахаар байгаа.

Хэлэлцэх асуудал цагтаа хэлэлцэгдэж амжвал дараагийн асуудлыг оруулж хэлэлцэх хугацаа гарвал бас хэлэлцүүлж эхэлж болзошгүй.

Тэгэхээр Тамгын газар цаг хугацаа юмаа тооцоод бэлэн байна биз дээ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Булгаагийн Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Бат-Эрдэнийн Хулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Манлайжавын Цэлмүүн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Бат-Эрдэмийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч, Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Цагааны Тэгшжаргал Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Ганхуягийн Давааням Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, Очирсайханы Баярмагнай “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Ерөнхий аудитор.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Урьдчилаад авчихсан өчигдөр. Дарааллын дагуу асуулт асууна. Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууна.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд хуулийн төсөлтэй нэлээдгүй нарийн танилцсан.

Өнөөдрийн цаг үе дээр энэ хуулийн төсөл орж ирэх нь зөв байх. Тэгэхдээ нэг талаараа энэ асуудал бас арай дутуу байгаа юм болов уу гэж би анзаарсан.

Өнөөдөр Монгол Улсад төрийн өмчит 122 компани үйл ажиллагаа явуулж байгаа. 99 толгой, 23 охин компани. Эндээс 5 нь ашигтай ажилладаг байх. Бусад нь тэгээд алдагдалтай ажилладаг.

Тэгээд өнөөдөр энэ төрийн өмч дээр үүсээд байгаа нөхцөл байдал нь юу юм бэ гэхээр

Нэгдүгээрт, “**засаглал**”.

Хоёрдугаарт, “**худалдан авалт**”.

Гуравдугаарт, “**төлөвлөлт**”.

Дөрөвдүгээрт, “**үр дүн**” гэсэн ийм дүнгээр явж байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ засаглалаа засахгүй бол ар талын гурвыг нь ярих ямар ч боломж байхгүй.

Тэгээд “засаглал” дээр өнөөдөр хэрхэн яаж энэ хуулийн төсөл дээр орж ирсэн юм бэ гэдэг асуудал. Өнөөдөр олон улсын жишгийг харах юм бол

- “**төвлөрсөн**”,
- “**төвлөрсөн бус**”,
- “**холимог**” гэсэн ийм засаглалын тогтолцоо байдаг л даа.

Тэгээд манайх яг алинд нь хамаардаг юм бол? Аль нь манай өнөөдөр Монголын энэ нөхцөл байдалд тохирох юм бол?

Зарим нэг төрийн өмчит компаниуд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраа хамаарч байх шиг байгаа юм.

Зарим нэг нь салбарын яамд дээрээ хамаараад явж байгаа нь холимог ч юм шиг, төвлөрсөн бус ч юм шиг ийм нөхцөл байдал анзаарагдаад байгаа юм.

Дээр нь энэ төрийн өмчтэйгөөс бид энэ улс төржилтийг арилгахгүй бол угаасаа шинэчлэл, реформ явагдахгүй л дээ. Тэгээд үүнийг өнөөдрийн энэ орж ирж байгаа хуульд ер нь яг хэрхэн орж ирсэн юм бэ?

Хоёрдугаарт, 3 жил ашиггүй ажиллаад татан буугдана гэдэг нэг ийм агуулга орж ирж байгаа юм билээ гэж ойлгосон. Тэгээд магадгүй би үүний цаана арай өөр санаа яваад байна уу гэж хараад байгаа юм. 3 жил ашиггүй ажиллуулаад хувьчилж авах санаа яваад байна уу гэж хараад байгаа юм.

1996 оноос хойш Монгол Улсын төрийн өмчид энэ “өмч хувьчлал” нэрийн доор сэтгэлгүй хандаж ирсэн олон хүн өнөөдөр олигарх болчихоод явж байгаа шүү дээ.

Тэгээд парламентын танхимаас гарч байгаа шийдвэр өнөөдөр үүнийг нь зөв зохицуулалтад ороод засах ёстой байтал буцаагаад хууль, эрх зүйн орчныг

нь нээж өгөөд, илүү тодорхой заалтаар оруулж өгөөд байгаа юм болов уу гэж би хардалт төрж байгаа.

Тэгээд бид засах гэж байгаа үүнийг сууриар нь засах ёстой. Болсон болоогүй зүгээр нэг ийм “БҮТЭЭМЖ САЙЖРУУЛАХ” гэдэг нэрийн доор. Өнөөдөр 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль өнөөдөр мөрдөгдөж байгаа. Засаглалын асуудал нь Компанийн тухай хуулиар явдаг. Хувийн компанийн захирал өнөөдөр өөрийнхөө дэд захирлаар хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр хэнийг томилохоо өөрөө мэддэг.

Гэтэл төрийн өмчийг өнөөдөр захиран зарцуулж байгаа нөхөр өнөөдөр энэ хуулиар асуудалдаа хандаад явж байгаа. Өмчлөлийн асуудал нь Иргэний хуулиар явж байгаа. Тэгээд үндсэндээ төрийн өмч чинь өнөөдөр үнэгүйдээд, төрийн өмч чинь өнөөдөр эзэнгүйдээд байгаа л хэлбэр л дээ.

Тэгээд энэ хуулийг өнөөдөр. Н.Учрал сайдад би их баярлаж байгаа. Ямар ч байсан тодорхой түвшинд дэвшил гаргаад оруулж ирээд хэлэлцүүлье гэдэг нь өөрөө их зориг юм. Үүний цаана асар том системийн авлига, асар том ашиг сонирхол байдаг гэдгийг хүн бүхэн мэднэ. Тэгэхдээ засах ёстой. Засахдаа их зоригтой засах ёстой юм болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр саяын хэдэн асуултад ажлын хэсгээс би асуумаар байна. Энэ хуулийн уялдаа хэр хангагдаж байгаа талаар.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Энэ төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлж, засаглалыг сайжруулснаараа ямар үр дүнд хүрэх вэ буюу яг үнэндээ энэ хууль бараг энэ цаг үеийн шаардлагаар нэг удаа үйлчлээд хэсэг хугацааны дараа энэ хууль заавал хэрэггүй байж болох боломж үүснэ.

Яагаад гэхээр энэ бол нэг талаараа компанийн хуулиараа зохицуулаад явъя гэхээр үнэхээр үүнийг зааглаж өгөхгүй бол цаашдаа төрийн болон орон нутгийн өмчит компани борооны дараах мөөг шиг л ингэж нэмэгдэж байна шүү дээ.

122 компани гээд яриад байгаа бол зөвхөн Төрийн өмчийн хороонд тайлан ирүүлж байгаа л компаниуд.

Түүнээс биш төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд гээд дотор нь

- ▶ төрийн өмчит үйлдвэрийн газар,
- ▶ төрийн өмчийн компани,

- ▶ орон нутгийн өмчит компани,
- ▶ улсын төсөвт үйлдвэрийн газар,
- ▶ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар,
- ▶ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэр

гээд хамгийн сүүлийн байдлаар **1273** хүрчхээд байгаа юм. Энэ тоо. Хамгийн сүүлийн **e-balance** систем дээр үзэхэд.

Гэтэл **1273** компаниас **508** хуулийн этгээд л e-balance-д санхүүгийн тайлан илгээсэн.

Тэгэхээр 50 хүрэхгүй хувь нь идэвхтэй байна гэсэн үг шүү дээ. Бусад нь ямар ч идэвхгүй гэсэн үг.

Тэгэхээр энд нэг **re-engineering** хийхээс өөр ямар ч арга байхгүй.

Тэгэхээр “төрийн өмчит” болон “орон нутгийн өмчит” энэ компанийн хууль батлагдсанаараа орц гарцыг шийднэ. “Бүтээмж” гэдэг бол. Нэг ёсондоо байгаа нөөцийг хэрхэн зөв хуваарилаад үр ашгийг нэмэгдүүлэх вэ. Үүний тулд

- ▶ Ил тод байдал буюу 74 төрлийн мэдээлэл ил болно.
- ▶ Төлөөлөн удирдах зөвлөл хараат бусаар ажиллах нөхцөл бий болно.
- ▶ Шалгуурууд өндөр болно.
- ▶ Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх нь тодорхой болно.
- ▶ Гүйцэтгэх удирдлага бизнес төлөвлөгөөнийхөө дагуу жил болгон ажлаа сунгадаг болно. Яг хувийн компаниудтай адилхан.

Дээрээс нь “**Кей Пи Ай**”^[key performance indicator(KPI)] /Гүйцэтгэлийн гол шалгуур үзүүлэлт/ дээр баримтлах мөрдлөг гол шалгууруудыг хуульд зааж өгснөөрөө компани, салбарууд өөр өөрсдөө “Кей Пи Ай” тавьж байгаад тэр индикаторуудын дагуу үнэлээд санхүүгийн алдагдлыг 3 жил бууруулаагүй бол шууд татан буулгах, өөрчлөх, зохион байгуулах, нэгтгэх, хөрөнгө мөнгө босгох, шаардлагатай бол IPO^[an initial public offering] гаргах ийм арга хэмжээнүүдийг авах бололцоо үүнээс бүрдэнэ.

Одоо яаж байгаа вэ гэхээр “бизнес төлөвлөгөө”-г өөртөө тохируулж хийгээд тэр компани бүрэн потенциал ашиглаж чадахгүй байна. Жишээ нь, салбарын BENCHMARK. Салбарын. Энэ салбарт тухайн компани ажилласнаараа ямар үр ашигтай ажиллаж болох вэ гэдгийг “Кей Пи Ай”-д нь тусгаж өгөхгүй болохоор нэг тийм дорвитой өөрчлөлт хийхгүй, өөртөө тохируулсан ийм нэг төлөвлөгөө хийхээд, түүнийгээ батлуулаад ингээд хараат бусаар орших ийм ямар ч бололцоогүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ хүрээндээ “ТӨРИЙН ӨМЧИТ” болон “ОРОН НУТГИЙН ӨМЧИТ” компани энэ хуулийг батлан гаргаснаар шинэчлэн зохион байгуулалтад орно. Статус ойлгомжтой болно. Хоёр дахин буурна. 122 компанийн хувьд 70, 56 толгой компанитай болно. Эхний байдлаар 26 тэрбум.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Баярбаатар: Тийм. Би өөрөө энэ Их Хурал дээр одоо өнөөдрийн мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсгийг би өөрөө ахалж байгаа юм.

Тэгээд Н.Учрал сайд аа, яг таны ярьж байгаа дэвшилтэт үзлийг би ойлгоод байгаа юм.

Тэгэхдээ миний түрүүний хэлсэн нөгөө засаглалын загвараа бид зөв зүйтэй сонгож чадахгүй бол таны ярьж байгаа наад ажлууд чинь зүгээр салхинд явах гээд байна л даа. Би энд санаа зовоод байгаа байхгүй юу. Энд санаа зовоод байгаа юм.

Тэгээд энэ дээр яагаад зоригтой асуудал руугаа орж чадахгүй байгаа юм бэ гэдэг нэг ийм сонирхол татсан зүйлүүд байгаа юм. Мэдээж цаана нь ашиг сонирхол, янз бүрийн юм байдаг л байх л даа. Тэгэхдээ өнөөдөр Монгол Улсын төр өмчөө мэддэг байх.

Өнөөдөр жишээлбэл ашигтай ажиллаж байгаа 5 компани дээр яагаад нээлттэй компанийн байдлаар хяналтын систем тогтоож болдоггүй юм. Заавал яагаад ашиггүй ажиллаж байгаа нэг АЗЗА_[авто замын засвар арчлалт] мэт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Н.Учрал сайд.

Н.Учрал: Энэ хууль батлагдсаны дараа хуульд заасны дагуу Засгийн газар төрийн өмчит компаниуд дээр баримтлах үндсэн чиглэлийг оруулаад чиглэлийг дагуулаад тогтоол оруулна.

Тогтоол дээр аль аль компанийг нээлттэй болгох вэ гэдгийг оруулж ирнэ. Нэгтгэх, өөрчлөх, зохион байгуулах шийдвэрүүдийг Их Хуралд оруулж ирнэ. Ингэсний хүрээнд нээлттэй аль аль компани болох вэ гэдгийг шийднэ.

Цаашдаа энэ хууль батлагдсанаараа төр 5 үндсэн чиглэлээс өөр салбарт төрийн өмчийн компани байгуулахыг хориглоно. Бүрэн хориглоно гэсэн үг. 5 салбарыг 8 дугаар зүйлүүд дээр тухайлан заачихсан. Энэ заалтаас өөр буюу зах зээлийн төвлөрөл багатай хувийн хэвшил орох боломжгүй салбарт зах зээлийн бүрэн судалгааг хийж, түүнд үндэслээд төрийн компанийг Засгийн газар байгуулах шийдвэрийг гаргана. Орон нутгийн өмчит компанийг нутгийн өөрөө

удирдах байгууллага шийднэ. Бусад салбарт төр компани огт байгуулахгүй гэдэг ийм хатуу шийдвэрийг одоо энэ хуулиар гаргана гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Өнгөрсөн 30 жилийн хугацаанд эдийн засаг маань бас хангалттай улс төрөөс хамааралтай болж чадаагүй байгаа.

Тэгээд үүний жишээг тоонуудаас харж болно. Төсвийн нийт зарлагын хэмжээ маань дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрч байгаа. Төрийн өмчит компаниудын нийт хөрөнгийн хэмжээ, зарлагын хэмжээ нь бас үүнээс дутахгүй байгаа. Нийлээд бараг төсвийн 70 орчим хувь болж байгаа. Үлдсэн хувийн аж ахуйн нэгжүүдийн топ 100 аж ахуйн нэгжийг аваад үзэхэд бараг 90 орчим хувь нь төрөөс олгодог зөвшөөрөл, лиценз дээр суурилж бизнес хийж байгаа юм.

Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд бид хэд хангалттай хувийн хэвшил. Одоо яг бор зүрхээрээ явж байгаа энэ чөлөөт зах зээл, өрсөлдөөнд суурилсан эдийн засгийн сууриа бас хангалттай бий болгож чадаагүй байна.

Тэгээд энэ чиглэлээр өнгөрсөн хугацаанд тодорхой алхмууд хийж байна гэж харж байгаа. Тэгээд төсвөө тодорхой хэмжээнд 37 хувь, хүргэх гэж байгаа хэмжээгээ 35 хувь болгож буулгалаа. Тэгээд өнөөдрийн энэ орж ирж байгаа хуулийн хувьд зарчмын хувьд дэмжиж байгаа. Үүнийг өөр бусад хуулиуд дээр зохицуулж болох боломжууд өнгөрсөн хугацаанд байсан.

Тэгэхдээ бид тэгж чадаагүй. Төрийн өмчит компаниуд алдаа хийх тусмаа улам томордог. Хувийн хэвшил хэрвээ алдаа хийвэл дампуураад байхгүй болдог ийм жишиг байхад тоонуудаас харагдаж болж байна. Төрийн өмчит компанийн нийт хөрөнгө 11 жилийн хугацаанд 12 дахин нэмэгдсэн ийм дүн байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл асуудлууд үүсээд ирэхээр. Эдийн засгийн байнгын хороон дээр Н.Учрал сайд хэлж байсан. Төрийн өмчит компаниуд дээр асуудал үүсэхээр энэ нь буцаад асуудлаа сайжруулъя гэж биш яаж тэр асуудлаас гарах вэ гэдэг улс төрийн ч гэдэг юм уу, ямар нэгэн дэмжлэг хайж явдаг иймэрхүү дүр зургууд байгаа учраас энэ хуулийг цаг алдахгүй хэлэлцэх нь зүйтэй гэж бодож байгаа юм.

Тэгээд Монгол Улсын хувьд нийтээрээ хурдан эдийн засгийн хувьд чадавхжих, хөгжих тийм зайлшгүй шаардлага байгаа. Геополитикийн үүссэн нөхцөл байдлаас ч гэсэн.

Тэгэхээр энд хамгийн хурдан эдийн засгийн хувьд боломжтой болох мотор бол хувийн хэвшил байгаа.

Тэгэхээр энэ чиглэлийг дэмжих. Тэгээд төрийн оролцоог багасгах чиглэлийн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлж дэмжинэ.

Тэгэхээр энэ чиглэлээр төслийг хэлэлцээд. Сайжруулах зүйлүүд энд олон байна.

Тэгэхээр Н.Учрал сайдын саяын хэлдэг шиг энэ хууль маань түр зуурын шинжтэй болоод, энэ төрийн өмчид үүсээд байгаа асуудлуудаа шийдээд, тэгээд үүргээ гүйцэтгээд дуусгавал бүр сайн байна гэж бодож байгаа юм.

Үүнтэй холбогдуулаад нэг асуулт байна. Н.Учрал сайдаас. Өнгөрсөн хугацаанд хуулиуд нэлээн байсан. Тэгээд зарим нэг хуулиудын хэрэгжилтүүд хангалтгүй байгаа. Би яах вэ, эндээс нэг зүйлийг л онцолж асууя.

2022 онд 25 компанийг хувьчлахаар Улсын Их Хурлын тогтоол гарсан байгаа. Тэгээд энэ тогтоол маань хангалттай хэрэгжихгүй байгаа. Энэ талаар Та яагаад ямар асуудал үүсээд энэ асуудлууд хэрэгжиж чадахгүй байгаа талаар бас мэдээлэл өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Тийм. Олон улсад нэг ийм agency асуудал буюу problem гэдэг нэг ийм агуулга байдаг юм байна. Тэр бол ерөөсөө энэ

- засаглал,
- эрх мэдлийн хуваарилалт,
- хяналт тэнцвэр,
- гүйцэтгэх удирдлагын хөшүүрэг юм билээ.

Тэгээд төрийн өмчит компаниуд дээр зөвхөн манайд ч нэг тийм асуудал үүсчээд байгаа зүйл бас байхгүй.

Энэ бол үнэхээр дэлхий дахинд, олон улсад л ийм проблем, асуудал үүсээд шийдвэрлэж байсан. Жишээ нь, тэр Маргарет Тэтчер /Margaret Thatcher/ яг энэ төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах чиглэлээр маш олон компанийг хувьчилж, шийдвэр гаргачхаад, түүнийхээ дараа дүгнэлт гаргасан байсан.

Ялангуяа эрчим хүч, зарим үндэсний аюулгүй байдалтай холбоотой салбарууд дээр бас шууд хувьчлал хийхээсээ илүүтэйгээр өөрчлөн зохион байгуулах, үр ашгийг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргах нь илүү оновчтой байдаг. Энэ сургамжийг бас авч үзэх ёстой гэж.

Тэгэхээр энэ хууль гарснаараа төрийн өмчит компанийн бүх “үйл ажиллагааг бүрэн зохицуулна” гэхээсээ илүүтэйгээр энэ хууль гарснаараа “засаглал” маш оновчтой болж байгаа юм.

Дээрээс нь Засгийн газар хувьцаа эзэмшигчийн хувиар тэр “төлөөлөн удирдах зөвлөл” болоод “бие даасан засаглал”-д хэрхэн оролцох вэ гэдэг заагийг нь маш тодорхой болгож өгч байгаа юм.

Дээрээс нь яг хувийн хэвшилтэй адилхан, Компанийн хууль дээр мөрддөгтэй адилхан тэр гүйцэтгэлийн үнэлгээ, тэр “Кей Пи Ай” индикаторуудыг тавьж байгаад үнэлдэг зөв тогтолцоо руугаа төрийн өмчийн компани яг өрсөлдөөний зарчмаар бүрэн шилжиж байгаа юм.

Ингээд эхлэхээр энэ төрийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх хууль гарснаараа шалгууруудын дагуу статус шинэчлэгдэнэ. Төлөөлөн удирдах зөвлөл шинээр нээлтийн сонгон шалгаруулалт хийгдэнэ. Ингээд зах зээлийн төвлөрөл багатай хувийн хэвшил оролцох боломжгүй салбарын үндэслэлүүдийг Засгийн газар оруулаад төрийн өмчийн компани байх шаардлагатай гээд тэр 5-хан чиглэл дээр зөвшөөрөгдвөл тэр зах зээлийн судалгаанд суурилсан, түүнийг биелүүлэх, тэр ажлыг явуулах бололцоотой хүний нөөцийг бид нийт хүний нөөцийн бүрдүүлбэрт нь өөрөө нөгөө хиймэл оюун ухаанд үндэслээд эхний байдлаар RANDOM_[санамсаргүй] хэлбэрээр SHORTLIST үүсгэх эхний давааг бид автоматжуулах ажлуудыг жишээ нь “Эрдэнэс Монгол” дээр хийж байгаа.

Яг үүн шиг хувийн хэвшлээс одоо нэг их түрүүлээд байдаггүй юм гэхэд хоцрохгүй байх, нэг хэлээр ойлголцох ийм боломжийг энэ Компанийн хууль өөрөө зохицуулж өгнө.

Тэгэхээр аяндаа өөрөө нөгөө зах зээлийнхээ журмаар энэ олон төрийн өмчийн компани өөрөө буурна. Ингэж байж тэр 50 хувь буурна гэдэг энэ тооцоо судалгаа гарсан юм.

Эхний үед ч гэсэн яг энэ засаглалын ажлуудыг хийгээд эхлэхээр, баримтлах чиглэл оруулаад эхлэхээр эхний үе шатад шууд 26 тэрбум төгрөг цалин дээр хэмнэгдэх юм байна. Сервис буюу тэр давхардсан чиг үүргүүд арилах юм байна гэдэг судалгаа гарсан.

Тэр төрийн өмчийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгэхээр энэ төрийн өмчит компаниудын засаглал, загваруудыг төвлөрүүлсэн, ялгамжтайгаар авч үзсэн ийм сайн сайн туршлагауд байгаа.

Жишээ нь, Сингапурын сайн жишээ байна. Норвег, Шведэд хийгдсэн гээд.

Эд нар дандаа холдингийн зарчим руу шилжүүлсэн. “Эрдэнэс Монгол” дээр сайн туршлага бид нэвтрүүлж өнгөрсөн хугацаанд чадлаа.

Тэгвэл “Эрчис Монгол” дээр гэхээр уул уурхайн бус компаниудыг яг тэр SHARED SERVICE буюу давхардсан чиг үүргийг оновчлох ажлуудыг зохион байгуулаад эхлэхээр, яалт ч үгүй тэр давхардсан чиг үүргүүд буураад эхлэхээр хүний нөөц ч гэсэн 30 хувиар хэмнэгдэж байгаа байхгүй юу.

Эхний түвшинд гэхэд л одоо жишээ нь холдинг дээрээ хуулийн хэлтэс байлаа гэхэд заавал тэр дэргэдэх охин компаниуд дээр нь заавал тэр хуулийн хэлтэс 10 хүнтэй байх уу, үгүй юу гэдгээр ийм оновчлох ажлуудыг хийгээд үзэхэд яг эхний 2 сарын түвшинд гэхэд л 11 тэрбум төгрөгийг хэмнэнэ гэдэг ийм судалгаанууд гарсан.

Тэгэхээр энэ хуулийг батлан гаргаснаараа бид нэгд статус буюу засаглалын хувьд шинэчлэлүүд хийгдээд эхэлнэ. Засаглалын хувьд.

Тэгэхээр аяндаа энэ шалгууруудад нийцэх нэр дэвшигч нар маш их бэрхшээлтэй болж эхэлнэ. Тэгээд энэ шалгуурууд хэрвээ Их Хурлын ажлын хэсгийн явцад багасаж болохгүй.

Тэгэхээр Их Хурлын ажлын хэсгийнхнээсээ би хүсэх гээд байгаа зүйл нь энэ шалгууруудыг аль болох багасгахгүйгээр бүгдээрээ аваад гарах ёстой. 3 жил санхүүгийн алдагдлаа огт бууруулаагүй байх нь өөрөө компанийг татан буулгах үндэслэл болно гэдгийг төсвийн хуулийг дагалдуулаад хийчихсэн.

Гэтэл санхүүгийн алдагдлаа яаж бууруулах уу гэхээсээ илүүтэйгээр өөрийг нь томилсон хүн рүүгээ залгаж аврал эрдэг энэ дампуу тогтолцоог одоо халахгүй бол болохгүй. Үүнийг халахын тулд энэ хуулийг хийгээд л, хуулиа бариад л, чаддаг сайн мэргэжилтнүүд л энэ компаниа удирддаг. Дагаад төрийн өмчит компанийн удирдлагуудын нэр хүнд нийгэмд өсөх л ёстой гэдэг ийм л агуулгатайгаа ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Болдын Цэнгэл нэмэлт хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Цэнгэл: Д.Энхтүвшин гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

2022 оны Улсын Их Хурлын 16 дугаар тогтоол гарч үндсэн чиглэл баталсан.

Үүний дагуу Засгийн газар жагсаалтыг нь батлаад 26 аж ахуйн нэгжүүдийг IPO гаргах ийм шийдвэр гаргаад явсан.

Хэрэгжилтийн байдал гэх юм бол Хөрөнгийн бирж 34 хувиа амжилттай нэмэлт хувьцаа гаргаад хоёр дахь зах зээл дээр явж байна. Төрийн банк 5.7 хувиа нэмж хувьцаа гаргасан. Цаашлаад 20 хүртэл хувиар явах юм.

Ер нь 20 АЗЗА, Хөрөнгийн бирж, Хөдөө аж ахуйн давхар даатгал, Монголын цахилгаан холбоо, мэдээлэл холбооны сүлжээ IT Park гэсэн ийм аж ахуйн нэгжүүдийг IPO гаргах үндсэн чиглэл гарсан.

Хэрэгжилтийг нь сая би хэллээ. Зарим аж ахуйн нэгж дээр бид бэлтгэл хангах хэлбэрээр ажиллаж байгаа. Тухайлбал, мэдээлэл холбооны сүлжээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Б.Цэнгэл даргын микрофон.

Б.Цэнгэл: Тухайлбал, Мэдээлэл холбооны сүлжээ компанийн хувьд үндэсний оператор компаниуд санал тавиад энэ дээр дахиж эргэж хараач ээ гэдэг асуудал ярьсан учраас үүнийг эргээд бид засаг дээр асуудлыг нь яриад дараагийн үндсэн чиглэл дээр асуудлыг нь 34 хувийг нь өсгөж оруулъя гэдэг ийм хувилбарууд яриад орж ирж байгаа.

Энэ хууль батлагдах юм бол жил болгон Засгийн газар Их Хуралд үндсэн чиглэлээ оруулж батлуулдаг байхаар орж ирж байгаа. Энэ дээр батлах субъект нь Улсын Их Хурал батлаад явах юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тийм. Гол тодруулах шалтгаан нь гэхээр мэдээж тодорхой салбаруудад төрийн оролцоо байх нь зайлшгүй шаардлагатай салбарууд байгаа. Хувийн хэвшлийн хийж байгаа салбарууд аль болох төрийн өмчит компаниуд байхгүй байсан нь өөрөө зөв байгаа.

Тэгэхдээ үүнийг шийдэхэд мэдээж өмнө нь хууль тогтоомжууд байсан боловч гүйцэтгэл хангалттай байгаагүй нь улс төрийн хувьд нэлээн эр зориг шаардсан ийм үйл явдлууд болдог учраас би гол шалтгаануудын талаар мэдээлэл гаргах үүднээс саяын асуултыг асуусан юм.

Тэгэхээр дагаж гарах тогтоолын төсөл нэлээн чухал байх гэж бодож байна. Тэгээд улс төрийн хувьд ч гэсэн нэлээн дэмжлэг хэрэгтэй. Энэ дээр хамтарсан засгийн нэг давуу тал гарна байх гэж бодож байна. Тэгээд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд. Өглөө Эдийн засгийн байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцсэн учраас асуултаа товчилъя.

Хоёрдугаарт, хуулийн ажлын хэсгийнхэнд өглөө танилцуулагдсан хууль зүйн дүгнэлтийг бас сайн нухацтай уншиж танилцах хэрэгтэй юм байна гэдгийг хэлмээр байгаа юм.

Энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалын тухай энэ хуулийн төсөл нь яагаад чухал вэ гэхээр бид намаржингаа хэлэлцсэн төсвийн сахилга бат буюу түүн дотроо төсвийн алдагдал, өрийн удирдлагын асуудал гээд энэ бүхэнтэй шууд холбоотой.

2022 оны байдлаар л гэхэд төрийн өмчит үйлдвэрийн газруудын нийт өрийн хэмжээ нь бараг 7 их наяд төгрөг байсан. Энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 16 хувьтай тэнцүү буюу олон улсад энэ хэмжээ 7 хувьтай байдаг.

Бид бүгдээрээ санал нийлж байгаа зүйл юу вэ гэхээр төрийн өмчит үйлдвэрийн газар, ТӨК-үүдийн засаглал сайжирч, ашигт ажиллагаа нэмэгдэх ёстой.

Гэхдээ гагцхүү энэ зорилго зорилтдоо хүрэхийн тулд энэ боловсруулж байгаа хуулийн төсөл маань яг одообайгаа “төрийн өмчит” болон “орон нутгийн өмчит” компаниудын шилжилтийг хэрхэн хийх вэ? Энэ нь эргээд иргэдэд зайлшгүй шаардлагатай нийгмийн шинжтэй, эрчим хүчний бусад дэд бүтцийн шинжтэй эрэлт хэрэгцээг хангахгүй зөвхөн одоогийн байгаа гибрид бүтцийг илүү дэмжсэн, илүү ашигтай юм уу, зах зээлийн шэйр өндөртэй, багтаамж өндөртэй хэсгүүд рүү орох, эсвэл хувийн салбарт буруу аргаар төрийн өмч орох ийм магадлалыг хэрхэн ямар арга замаар сайжруулж байгаа нь хуулийн төслөөс тодорхой харагдахгүй байгаа юм. Энэ дээр бас илүү итгэл өгөх байдлаар гурван яг гол гэсэн пойнтоор хариулж өгнө үү гэж хүсье.

Тэгээд ер нь цаашлаад маш олон асуулт байгаа. Өглөө заримаас бас хариулт авсан. Дахиад нэмж асуухад энд хэрэгтэй байх. Бусдад сонсоход.

Үндэсний аудитын газрын үүрэг, функцийг төрийн аудитыг хасах замаар, хөндлөнгийн аудитыг оруулж ирэх замаар хийх гэж оруулж байгаа нь зөв үү гэдэг дээр бас хариулт авъя. Баярлалаа.

Б.Баярбаатар гишүүний хэлсэн асуулдалтай санал нэг байгаа юм гэсэн үг. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ хууль гарснаар юу болох вэ.

Энэ хууль гарснаар олон улсын төрийн өмчит компаниудад тавигдах шугам үүснэ гэсэн үг. Тэгээд бид яах вэ гэхээр олон улсын стандарт хангасан

төрийн өмчит компаниудаа авчихна гэсэн үг. Одоогийн байдлаар 120 компани дундаас 10 компани л хангана гэсэн үг.

Ингээд 100 компани үлдчихнэ. 100 компани яах вэ гэхээр OECD буюу энэ олон улсын стандартаа давахын тулд өөрсдөө ажиллана гэсэн үг.

▶ Тэд нэгдэж болно. Тэр шалгуураа давахын тулд.

Хоёрдугаарт,

▶ Дүрэм, журмаа өөрчлөөд сайжруулалт хийж болно.

▶ Үр өгөөжөө дээшлүүлж болно.

▶ Татан буугдаж болно.

▶ Хувьчлагдах санал гаргаж болно.

Тэгэхээр энэ бүх шалгуураа л олон улсын болгоод биднээс хамааралгүй болгочхож байна л гэсэн үг.

Дээрээс нь “төрийн өмчит компани” гэдэг статус дунд одоо бас их олон байгууллагууд байдаг. Энэ 120 компани дунд жишээлбэл

▶ “Кувейтийн сан” гээд нэг байшин байгаа. “Төрийн өмчит компани” гэдэг нэртэй.

Жишээлбэл,

▶ Соёл, урлагийн салбарт “Кино үйлдвэр” байгаа.

▶ Хууль, хяналтын байгууллагууд дээр “дуурь” болон зарим “театрууд” байгаа.

▶ Зарим нь оёдлын үйлдвэрүүд байгаа.

Эднийг Эрдэнэт юм уу, “Эрдэнэс Монгол”-той харьцуулаад адилхан байхыг шаардаад байхаар бас энэ нь өөрөө болохгүй. Бүхэлдээ өөрөө төрийн өмчит компаниуд ашиггүй байгаа гэдэг зүйл дунд бас энэ асуудлууд гараад байгаа.

Дээрээс нь орон нутгийн баахан компаниуд байгаа. Тэр дунд АЗЗА-ууд байгаа. Ашигтай ажиллах боломжгүй. Тэгсэн мөртлөө замын асуудлыг хийхгүй болохгүй ийм бүтэцтэй.

Тийм учраас бидний хувьд одоо энэ хууль батлагдсанаар “төрийн өмчит компани” Монгол Улсын хувьд ямар байх вэ гэдэг статусаа л тодорхойлчхож байна гэсэн үг. Тэгээд тэр статусдаа бид тэнцсэнийг нь татаж гаргаад, тэнцээгүйг нь яах вэ гэхээр яаж зохион байгуулах вэ гэдгийг үе шаттай хийгдэнэ.

Түүнээс үүнийг ямар нэгэн байдлаар хүчээр хувьчлал явуулах ч юм уу, ямар нэгэн байдлаар хүчээр механикаар нэгтгэх ч юм уу ийм асуудал үүсэхгүй. Энэ шалгуурт нийцсэн компани нь 120-оос 10 компани. Тэгээд 10 компани болон бусад компаниа хоёр хуваачхаж байгаа.

- ▶ Уул уурхайн компаниуд “ЭРДЭНЭС МОНГОЛ”-ын харьяанд.
- ▶ Уул уурхайн биш компаниуд “ЭРЧИС МОНГОЛ”-ын харьяанд.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын нэгдсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо хийнэ. Менежментэд оролцохгүй.

Яг ийм агуулгын л хууль гэж ойлгож болно.

Тэгэхээр яг ингээд зааглачихаар саяын “БҮТЭЭМЖ”, тэгээд ашигтай байх уу, үгүй юу гэдэг асуудлыг OECD-гийн олон улсын шалгуур тавьчхаар арын хаалга байхгүй. Тэгээд шалгуураа давсан нь үлдээд, даваагүй нь өөрчлөлт нь зохион байгуулагдана л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2017 онд Ч.Хүрэлбаатар сайд баахан төрийн өмчит компаниудыг ашигт ажиллагааг нь сайжруулах, ер нь татан буулгах тэр асуудлаар нэлээн ярьсан юм. Тэгээд ажил болоогүй.

2021 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар баахан АЗЗА, бас нэлээн олон компаниудыг нэгтгэх, хувьчлах тухай асуудал оруулж ирсэн. Тэр нь тэгээд ажил болсонгүй бас.

Тэгээд гурав дахь удаагаа орж ирж байгаа юм байна. Тэгээд энэ хамтарсан засгийн үе дээрээ илүү үр дүнтэй явах байх гэж би харж байгаа.

Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар 122 “төрийн өмчит компани” байна. 64 их наядын хөрөнгөтэй юм байна. 87 мянга 900. Энэ бол 2013 оны тоо шүү. 87 мянга 900 ажилтантай.

Тэгээд Дэлхийн банкны үнэлснээр хөрөнгийн өгөөж “тэг”. Ашигт ажиллагаа 5.9-хөн хувь. Ийм л үр дүн гарч байгаа юм.

Тэгээд яагаад ийм өгөөжгүй, үр дүнгүй, эдийн засгийг хойш нь татсан, тэгсэн мөртлөө бүх тийм тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлж байж яагаад ийм ашиггүй ажиллаад байгаа юм бэ? Энэ бол цэвэр томилгооноос л шалтгаалж байгаа. Өөрөөр хэлбэл Их Хурлын гишүүдийн болон сайд дарга нарын сонгуульд яваад тэнд нь том амжилт гаргасан нөхдүүд тэнд очиж эзэн суудаг. Тэгээд тэр гишүүний хүн юм чинь гээд эх замбараагүй иддэг уудаг ийм л зүйл болоод байгаа.

Тэгээд энэ TRANSPARENCY INTERNATIONAL-ийн гаргасан авлигалын төсөөллийн судалгаагаар манайх байнга хойшилж байгаа. Энэ хойшилж байгаа үндсэн шалтгаан бол энэ буруу томилгоо.

Өөрөөр хэлбэл хэт улс төрчөөс хамаарсан томилгооноос болж энэ “төрийн өмчит компани” үр ашиггүй ажиллаж байна, иддэг уудаг нь хэтэрч байна л гэж гарч байгаа.

Тэгээд дээрээс нь нэг зүйл их чухал байгаа. Одоо жишээ нь бид энэ авлигын эсрэг хууль, янз янзын эрүүгийн хуулийг маш их чангалж байгаа. Гэтэл яагаад бид нарын тэмцлийг энэ олон улсын байгууллага үнэлэхгүй байгаа юм бэ гэхээр төрийн өмчит компаниас гарч байгаа тэр экспортын хэмжээ нь тодорхой байгаа. Гэтэл түүний буцааж орж байгаа төлбөрийн нэг хэсэг нь алга болж байгаа учраас энэ бол хулгайлж, луйвардаж явж байгаа хөрөнгө мөнгө гэж үзээд л авлигалын эсрэг байгууллага чинь энэ “төрийн өмчит компани” дээр манай Монголын авлигалын төсөөллийг дандаа хойш нь татаж хойшоо оруулаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ ажлыг дэмжинэ. Ер нь чөлөөт зах зээлийг Ардчилсан нам дэмждэг. Баруун төвийн үзэлтэй нам учраас яг энэ асуудлыг маш их дэмжинэ.

Дээрээс нь би “Эрдэнэс Эм Жи Эл” гэж компани руу албан бичиг явуулсан юм. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар дамжуулаад явуулсан. Танайх 2016 онд хэдэн албан хаагчтай байж байгаад өнөөдөр хэдэн албан хаагчтай болсон бэ гээд асуулга явуулсан чинь хариу нь “нууц” гээд ирээгүй. Ичиж үхмээр тоо гарч байгаа. Би тэрийг дотор нь мэдээллээ авчихсан байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ баталгаажуулах гэж явуулж байгаа байхгүй юу.

Зүгээр л ерөөсөө ингээд л нэг тийм сонгуульд ажилласан хүмүүсийг л тэр төрийн өмчит компаниуд дээр бүгдэд нь ямар ч үүрэггүйгээр бүгдийг нь чихдэг тийм л компаниуд болж хувирсан байгаа.

Үүнийг яг энэ хамтарсан засгийн үед л шийдвэрлэх ийм л боломжийг өнөөдрийн нөхцөл байдал бий болгож байгаа.

Тэгэхээр энэ дээр бүгдээрээ хамтдаа сайн оролцоод явъя. Ер нь яаж хулгай хийдэг тэр детальный юмнууд намайг нэг Их Хурал дээр нэг үг хэлчихнэ гээд тэр бүх байгууллагууд чинь бүгдээрээ надад мэдээллээ ирүүлдэггүй байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би яг Б.Пүрэвдорж гишүүнтэй яг санал нэг байгаа.

Бас яг залгуулаад хэлж байна гээд бодчихоорой л гэж би хүсэж байгаа юм. Үнэн шүү дээ. Яг Пүүжээ гишүүн сая зүгээр маш даруухнаар л хэлж байна.

Өнөөдөр Монгол Улсын авлигын индексийг хойш татаж байгаа гуравхан зүйл байгаа. Ерөөсөө л энэ “төрийн өмчит” болон “орон нутгийн өмчит” компанийн засаглал, ил тод байдлын асуудал.

Үүнээсээ үүдээд улс төрийн намын санхүүжилтийн асуудал яригддаг. Одоо нууц биш.

Тэгээд олон жил хэдүүлээ бас аргалж явж ирлээ. Асуудлуудыг ярьдаг мөртлөө, шийдье гэх мөртлөө шийдвэр гаргаж ирсэнгүй. Тэгээд энэ парламент хамтарсан Засгийн газрын үед үүнийгээ шийдэх хэрэгтэй байна.

Дээрээс нь яах вэ зүгээр 14 мега төслөөс дутахааргүй энэ бол мега прожект юм. Энэ асуудлын цаана шийдэж чадвал хувийн хэвшилд маш том бизнесийн орон зайг гаргаж өгнө. Төрийн бараг оролцоогүй бизнесийн салбар байхгүй болсон. Гал тогооноосоо эхлээд уул уурхай. Бүх салбарт байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг цэгцэлж чадвал бид Монгол Улсад бизнес хийж болох юм байна. Тэгээд магадгүй бид нарын том амбиц бол цаашдаа нэгээс хоёр компани дэлхийн зах зээл дээр гаргаж ирэх ёстой байхгүй юу. Тэгж хувийн хэвшил эндээс сэдэлжих ёстой юм. Тэгээд байгаа төрийн өмчит компаниудаа засаглалыг нь сайжруулж, төсвийн бодлоготойгоо уялдуулмаар байна.

Түүнээс биш нэг улс төрийн шийдвэр гэдэг юм уу, нэг дарга гаргаад төмөр замыг санхүүжүүл. Нэг дарга шийдвэр гаргаад ноль барь, нэг дарга гаргаад тэр орон нутгийн тэрийг шийд. Ийм байдлаар яваад байхаар Монгол Улс чинь давхар төсөвтэй болоод байгаа юм.

Өнөөдөр энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн нийт орлого 23 их наяд байгаа. Үүнээсээ 16, 17 их наядыг буцаагаад үйл ажиллагааны зардалдаа зараад, 5 их наядын цэвэр ашигтай. Тэгэхдээ ямархуу хэмжээний хөрөнгийг барьчхаад 5 их наядын цэвэр ашиг хийж байгаа вэ гэвэл бас өөр үзүүлэлт гарна. Бараг хангалтгүй. Магадгүй энэ хувийн хэвшилд байх юм илүү ч үр өгөөжтэй байхыг бас үгүйсгэхгүй.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг цэгцлэх цаг болсон. Тэгээд бид авлигалтай тэмцье гэж байгаа, эрчим хүчний реформ хийе гэж байгаа, баялагтаа эзэн байя, баялгийг шударгаар хуваарилъя гэж байгаа. Яг энэ хуулиас эхэлнэ шүү.

Энэ хуулийг зөв гаргаж чадвал бид яг энэ яриад байгаа зүйлүүдийг энэ хамтарсан Засгийн газрын хувьд бас нэлээн дөхүүлнэ. Дөхүүлнэ. Би бүх зүйлийг шийдчихнэ гэж хэлж чадахгүй. Тэгэхдээ энэ эхлээд Хууль, эрх зүйн шийдвэр

гаргах тэр хүмүүсийн нөхцөл байдлыг нь бүрдүүлж өгөхгүй бол энэ нөхцөл байдлууд чинь болохгүй байгаа юм.

Тэгээд өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчит компанид 58 мянган хүн байна. Зургаахан нь листэд буюу олон нийтийн компани болсон байна. Түүрүүн 23 их наядын 16 их наядын буцаагаад зардаг гэж ярилаа. Үүнийгээ ингээд бодох юм маш их хэмжээний гуниг л төрж байгаа юм. Тэгээд энэ хууль батлагдвал “Улаанбаатар төмөр зам” гээд нийгэмлэгээс бусад нь бүгд компани болно. Компанийн яг засаглалын стандартыг хангаж эхэлнэ.

Яагаад гэхээр Оросын Холбооны Улстай байгуулсан “Улаанбаатар төмөр зам”-ын хэлэлцээртэй учраас энэ яах ч арга байхгүй.

Бусад нь бүгд компанийн хэлбэрт орж, ямар нэгэн байдлаар улс төрийн томилгооноос л ангид байлгаж, үр өгөөжийг нь нэмэгдүүлье л гэж байгаа юм.

Тэгээд энэ хуулийн төслийг сайжруулахад нэлээн олон юм байна. Гишүүд маань бас эргэлзээд байх шиг байна. Бид хэд ингэж тухайлан төрийн өмчит компанийн хууль баталж байгаагүй шүү дээ гээд. Баталж байсан. Хөгжлийн банкны хууль гэдэг тэр чигтээ Хөгжлийн банкны тухай, Компанийн тухай хууль байхгүй юу.

Яг үүнтэй адилхан. Тэгээд энэ нөхцөл байдлуудыг бүрдүүлээд өгвөл бас олон зүйлийг цэгцэлж чадна гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд ерөнхийдөө ашигтай ажиллуулах, хяналтыг сайжруулах үүднээс дотор нь ажиллаж байгаа ажилтнуудад захиран зарцуулах эрхгүйгээр хувьцаа өгч хяналтыг тавьдаг жишгүүд байгаа юм.

Тэгэхээр энэ уул уурхайн компаниуд ийм буруу жишиг байж магадгүй. Магадгүй ИТ, патент эзэмшдэг, ноу хау эзэмшдэг, магадгүй энэ эрчим хүчний компаниудад бас энэ хувилбарыг өгчих юм бол дотоод хулгай нь бас байхгүй болно шүү.

Тэгэхээр үүнийг ажлын хэсэг бас судалж үзээч ээ гэж байгаа юм. Тэгээд цаашдаа ер нь зүгээр яах вэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Н.Учрал сайд.

Н.Учрал: Их Хурлын тогтоолоор олон нийтэд нээлттэй болгох компанийн жагсаалтыг баталсан.

Тухайн үед Засгийн газар чиглэл өгөөд зарим салбарын компаниудыг нээлттэй болгох ажлыг эхлүүл гээд чиглэл өгсөн. Тухайн үед би Цахим хөгжлийн сайд байсан.

Тэгэхээр “Монголын цахилгаан холбоо” гэдэг компанийн үнэлгээ нь юу билээ. 11 тэрбум л байсан байх. Тэгээд өртэй. Тэгээд та нар IPO гаргах гэж байгаа бэлтгэл хангана. Та нар олон улсын аудит хийлгэнэ. Ингээд UNDERWRITER-аа хөлсөлж ав гэсэн. Бид нарт санхүүжилт байхгүй л гээд байсан.

Тэгээд яасан. Их Хурлын тогтоол гэнэт гарчихсан. Одоо бид яахаа мэдэхгүй. Зарим компанийн үнэлгээ нь асар бага.

Тэгэхээр бид ер нь цаашдаа энэ хуулийг гаргаж байгаагийн зорилго энэ засаглал, энэ бие даасан байдал, энэ цаашдаа төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, ямар ямар салбарт төр нь орно, орохгүй. Бизнес өөрөө өдөр тутам өөрчлөгддөг учраас энэ хуульдаа нийцүүлсэн “төрийн өмчит компани” дээр баримтлах Засгийн газрын чиглэл. Энэ дээрээ тооцоо судалгаанд нийцүүлж байж тэр нээлттэй болгох, нийлүүлэх, өөрчлөх, зохион байгуулах ажлуудыг хийхгүй бол шууд хувьчилна, шууд татан буулгана гэж ярих нь өрөөсгөл.

Үүнээс хамгийн зөв нь одоо жишээ нь SHARED ECONOMY гээд холбох эдийн засаг хөгжиж байна. Тэгвэл ядаж сервисээ shared болгоё гэдэг байдлаар эхний алхмуудыг хийгээд яваад байгаа байхгүй юу.

Түүнээс шууд гаргаж ирээд л нийлүүлснээрээ бүх юм сайхан болчихдог юм байна, эсвэл татан буулгаснаараа сайхан болчихдог юм байна гэж тооцоололгүй хандаж болохгүй.

Тийм учраас төсвийн хуулийг дагалдуулаад тухайн үед Төрийн өмчит болон орон нутгийн өмчийн хууль дээр яагаад Засгийн газраас олон улсын аудит хийлгэх жагсаалтыг батлуулах гээд байсан юм бэ гэхээр энэ бол тэр чигээрээ бэлтгэл ажилтай холбоотой байсан. Тэгэхэд Их Хурлаар дэмжигдээгүй л дээ.

Тэгэхээр IPO гаргана гэдэг бол өөрөө бүхэлдээ их ул суурьтай хандах, олон нийтээс хөрөнгө оруулалт татна гэдэг бол маш их хариуцлага учраас ул суурьтай хандах ийм шаардлага байгаа.

Тийм учраас бид цаашдаа яг ямар ямар компаниудыг LIST-д болгох вэ гэдгийг энэ хуулийг дагалдуулсан чиглэлтэйгээ оруулж ирээд шийдвэрлэх ёстой. IPO гаргана гэдэг бол нэгд засаглалыг ил тод болгохоос гадна хөрөнгө мөнгө татан төвлөрүүлэх гээд байна шүү дээ. Түүний ард тэр хувьцааг худалдаж авсан цалингаасаа илүүчилсэн иргэдийн маань мөнгө хэр найдвартай вэ гэдгийг хамгаалахгүй бол хувьцааны талаарх ойлголт ч гэсэн ард иргэдийн дунд муу байгаа.

Тэгэхээр энэ дээр Засгийн газраас бэлтгэл ажил хангуулах ажлуудыг хийж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд цаашдаа үндсэн чиглэл, гол зорилго нь яг тухайн Засгийн газар “төрийн өмчит компани” дээр ямар бодлогоо баримтлах вэ гэдгээ л баримталж байгаа зарчим.

Тэгэхээр цаашдаа энэ хуулийг хөндөх гэхээсээ илүүтэйгээр Засгийн газар болгон байгуулагдахдаа энэ хуулийг нийцүүлээд л “төрийн өмчит компани” дээр баримтлах чиглэлээ оруулж ирээд л Их Хурлаар хэлэлцээд л явдаг энэ зөв жишиг рүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Н.Учрал сайдын хариултад.

Тэгээд нэг зүйлийг бас анхаарч өгөөч ээ гэж байгаа юм. Бас хурлын дарга энэ дээр жоохон дэмжээд өгвөл яадаг бол.

Хууль зүйн байнгын хороотой Эдийн засгийн байнгын хороо үүнийгээ хамтраад хэлэлцвэл бас их зөв болов уу гэж бодож байгаа юм. Гишүүд маань энэ дээр анхаарч өгөөч. Бас нарийн нюанстай хууль зүйн үр дагавартай, хуулийн этгээдийн засаглал талдаа Хууль зүйн байнгын хорооны асуудалтай хамаатай байгаа юм.

Тэгэхээр үүнийг Улсын Их Хурлын удирдлагууд анхаарч өгөөч.

Би тэгээд асуулт дээрээ асууж чадаагүй юмыг хэлчихье. Тэгээд Н.Учрал сайд боломжтой хариулаач.

“Эрдэнэс Тавантолгой” нөгөө 1072 хувьцааг эзэмшүүлчихсэн. Тэгээд түрүүчээсээ зарим хүмүүс маань бурхны орныг зорьсон хүмүүс байна. Тэгээд хувьцаа нь өвлөгддөггүй. Ингээд нэг ийм тодорхойгүй нөхцөл байдалтай байгаад байгаа юм.

Тэгэхээр төрийн болон орон нутгийн өмчийн энэ хуультай холбоотойгоор бас энэ “Эрдэнэс Тавантолгой”-н тэр эзэмшүүлсэн, тэр хүний өмч гэдгээр нь өгчихсөн байхгүй юу. Тэгэхдээ үүнийг захиран зарцуулах эрхийг нь тодорхой хүрээ хязгаартайгаар, магадгүй гадаад улсын иргэнд зарахгүй ч гэдэг юм уу, эсвэл одоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье. Нэмэлт хариулт.

Н.Учрал: Тэгээд би бас түрүүн хэлсэн. Ер нь энэ хувьцааны талаар иргэдэд соён гэгээрүүлэх энэ үйл ажиллагааг тасралтгүй явуулах ёстой. Энэ ч утгаараа Ерөнхий сайдын захирамжаар нэг ийм ажлын хэсэг байгуулаад би энэ хувьцааны талаар мэдээ мэдээллийг өгөх.

Дээрээс нь энэ “Эрдэнэс Тавантолгой” 1072 хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх энэ бэлтгэл ажлыг хангуулах ийм урт хугацааны төлөвлөгөө хэрэгтэй.

Түүнээс биш шууд энгийн хувьцаанд хөрвүүлээд л зарж үр гэх юм бол иргэд хувьцааны талаар ойлголтгүйгээсээ болоод эргээд цаашаа ногдол ашиг хүртэх эрх ашиг нь хөндөгдөх эрсдэлтэй болж таарна.

Тийм учраас бид бэлтгэл ажлыг хангуулах цаг хугацааны ийм ажлуудыг шат дараалалтайгаар хийх ажлыг эхлүүлж байгаа. Энэ хүрээндээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хүний нөөц, санхүү, COMPLIANCE_[нийцлийн удирдлага] хариуцсан гээд 5 удирдах түвшний, “Си” /C-level executives, “chief” executives/ түвшний удирдлагыг олон улсад сайн менежерүүд авъя гээд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.

Д.Амарбаясгалан: Тийм. Энэ 1072 хувьцаа П.Сайнзориг гишүүн ээ, энэ чинь өнгөрсөн оны 01 сарын 07-ны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэгдээд, энгийн хувьцаа гэдэг зүйл маш тодорхой болчихсон шүү дээ. Тийм ээ.

Тэгээд ер нь яах вэ, хувьцаатай холбоотой асуудал бол яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиараа зохицуулагдах нөхцөлүүд мэдээж нээгдсэн. Зүгээр яг арилжуулах, өвлүүлэх тэр асуудлыг хэрхэн, хэзээ, яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал засгаас хамаарсан асуудал байж байгаа. Тэгээд энэ дээр бас гишүүд үе үе санаачилга гаргаж байгаа. Засаг бас энэ дээр анхаарахгүй юу.

Ер нь цаашдаа урт хугацаандаа “Эрдэнэс Тавантолгой” 1072 хувьцаатай холбоотой асуудлыг амь оруулах буюу иргэн өөрийнхөө эзэмшиж байгаа өмч хөрөнгийг хэрхэн яаж хөдөлгөөнд оруулж байх вэ гэдэг асуудал тодорхой хуулийнхаа дагуу зохицуулагдах шаардлагатай байх гэж.

Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн ач холбогдлыг бараг Үндэсний баялгийн сангийн хуулийн ач холбогдолтой ялгаагүй хэмжээнд гэж үзэж байгаа юм л даа.

Ер нь Монгол Улсад сүүлийн 30 жил байгалийн баялагтай холбоотой авлигын томоохон хулгай, үүнийг дагасан шударга бус хуваарилалтууд дандаа л яг түүний ард нь орлогыг төвлөрүүлж байгаа төрийн өмчит компаниудтай холбоотой явж ирсэн.

Тэгэхээр ямар ч байсан хуваарилалтын хувьд Үндэсний баялгийн сангаараа дамжуулаад баялгийн илүү шударга, иргэддээ очсон Үндсэн хуулийнхаа 6.2-ын хүрээнд амилуулъя гээд Үндэсний баялгийн сангийн тухай хуулиа хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг амилуулах, урт хугацаандаа мөнгөжих, тогтвортой явах, Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулсан энэ хууль гэж хараад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ хууль өөрөө маш сайн чамбай хэрэгжиж байж цаашдаа Үндэсний баялгийн сангийн орлогыг төвлөрүүлэх боломжтой болно гэж харж байгаа юм л даа.

Тэгэхээр ер нь бараг нэг зоосны хоёр тал гэж харахад болохгүй юм байхгүй.

Тэгэхээр энэ дээр хэд хэдэн асуултууд байна. Энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль дотор 8 дугаар зүйл болоод 5 заалттай яваад байгаа илүү, энэ бараг хуулиасаа давсан том концепт яваад байна л даа.

Ер нь цаашдаа төр ямар үйлчилгээ, ямар бизнест байхаа ойлгомжтой болгох ёстой байгаа юм. Яг Үндсэн хуулийнхаа хүрээнд ч гэсэн ер нь төр ямар үйлчилгээ, бизнест орох вэ. Ямар үйлчилгээ, бизнест ерөөсөө орохгүй хувийн хэвшилд өгөх вэ?

Тэгэхээр энэ бараг өөрөө малгай түвшинд шийдэгдэж байж буцаад тэгвэл энэ салбарт яг энэ үйлчилгээнд төр оролцох юм байна. Тэгвэл энэ дээр байгаа компанийн статус, компанийн үйл ажиллагаа, ил тод байдал хэрхэн явах вэ?

Тэгэхээр одоохондоо яг энэ хууль дээр зүгээр 8 дугаар зүйл дээр 8.1-ээс 5-ын хооронд энэ том концепт маань 5 зүйл болоод энэ хууль дотор жоохон булагдчихсан юм шиг л санагдаад байна л даа.

Яагаад гэх юм энэ концепт өөрөө бараг энэ хуулиас өмнө зайлшгүй шийдэгдэх ёстой нэг том концепт болж таарч байна гэж хараад байгаа юм.

Хоёрдугаарт, Монголын томоохон төрийн өмчит компаниудыг аваад үзэх юм бол түрүүн Н.Учрал сайд хэлж байна. Засгийн газраас ч шийдвэр нь гарсан. “Эрдэнэс Монгол”, “Эрчис Монгол” гээд. Уул уурхайн, уул уурхайн бүс гээд төрийн өмчит томоохон компаниуд ингээд төвлөрүүлж байгаа юм.

Энэ хоёр холдинг компани буюу толгой компаниуд. Мэдээж доор нь янз бүрийн хэмжээтэй жижиг охин компаниуд байгаа.

Тэгэхээр яг энэ хуулийн зохицуулалтаар яг энэ хоёрын хоорондын ялгаа энэ хуулиар ороогүй л байна л даа.

Тэгэхээр үүнийг юу гэж харж байгаа юм бол гэж асуумаар байна. Мөн цаашдаа энэ улс төрөөс ерөөсөө л энэ компани дээр үйл ажиллагаа, ашигт үйл

ажиллагаанд нь, томилгоонд нь, улс төрөөс, болж өгвөл Засгийн газрын хурлын шийдвэр болгоноос уг нь ангид байх ёстой байгаа юм л даа.

Яагаад гэхээр энэ компаниуд ашигт ажиллагаагаар ТУЗ-тай, дээрээ холдинг компанитай, яг түүнийхээ ашигт ажиллагаагаар уг нь явж байж бусад урт хугацаандаа ашигтай, үйл ажиллагаа нь ч гэсэн тогтвортой байна гэж харж байгаа юм.

Энэ дээр нэг заалтыг онцолмоор байгаа юм. Жишээлбэл, үнэт цаас гаргах, зээл авах компани болгоны хүрээнд заавал Засгийн газраас, ялангуяа тэр дундаа Сангийн яамнаас зөвшөөрөл авна гэж байгаа юм л даа.

Тэгэхээр уг нь охин компаниудын зээл авах тэр түвшинг тэр холдинг компани буюу “Эрдэнэс Монгол”, “Эрчис Монгол”-ын түвшинд хийх ёстой юм л даа. Энэ чинь санхүүгийн талаасаа CAPITAL STRUCTURE буюу капитал тэр бүтцийг нь хамгийн оновчтойгоор гаргаж ирээд нэгдсэн түвшинд нь магадгүй Сангийн яамнаас зөвшөөрөл авах ч юм уу.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүнд нэмэлт 1 минут өгье.

О.Батнайрамдал: Охин компани бүрээс Сангийн яамнаас зөвшөөрөл авах нь өөрөө буцаад Сангийн яам компанийн охин компани болгоны үйл ажиллагаа руу орох хэт бас дахиад нөлөөлөл орох тийм дүр зураг энэ дээр харагдаад байна.

Мөн гүйцэтгэх удирдлага байгаа. Гүйцэтгэх удирдлага дээрээ болж өгвөл цалин хөлс сайтай INCENTIVE тэр бүтцийг нь зөв гаргаж өгсөн, сонгон шалгаруулалтаар тийм мэргэжлийн томилгоонууд явах ёстой.

Тэгэхээр төлөөлөн удирдах зөвлөл дээр энэ дээр нэлээн детальчилж сонгон шалгаруулалт яаж явах юм, яаж чөлөөлөх юм, яах ёстой бүгдийг нь тусгасан боловч яг гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт, томилгоон дээр илүү тайлбар авмаар байна л даа.

Тэгээд хамгийн сүүлд нь бид түрүүхэн Монголын томоохон төрийн өмчит сургуулиуд дээр ажилласан. Одоо жишээлбэл Монгол Улсын Их Сургууль төрийн өмчит үйлдвэрийн газар гэж явдаг юм байна. Эрдэнэт үйлдвэр бас яг адилхан төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн энэ хоёр шал хоёр өөр байгууллага хоёулаа адилхан статус дээр явдаг юм билээ. Энэ хуулиар цэгцлэгдэж байгаа юу гэж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль бүхэлдээ энэ засаглалыг

сайжруулснаараа компанийн үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг чиглэл рүү л бид харж энэ хуулийг бичсэн.

Тэгэхээр одоо жишээ нь ашигт ажиллагаа гэхээр нэг зүйлийг бодож чадахгүй байгаа юм билээ. Яагаад гэхээр хувийн хэвшлийн буюу тэр салбарын тэр BENCHMARK-тай нь харьцуулж явах ёстой.

Гэтэл жишээ нь нүүрсний үнэ зах зээл дээр өсөж байхад тухайн компани өмнөх жилээсээ багахан ашигтай ажиллах биш байхгүй юу. Тэр чинь тухайн зах зээлийн өрсөлдөөнтэйгөө нийцээд илүү үр ашигтай ажиллах шаардлага байна шүү дээ. Гэтэл тэр бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр буурч байвал тооцоолсноос илүү ашигтай ажиллах бололцоо байхгүй үе тохионо.

Тэгэхээр энэ бол өөрөө агуулгын хувьд нэлээн өөр ойлголт.

Тийм учраас “ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ” гэдэг өөрөө цаашдаа өнгөрсөн хугацааны зөвхөн ажлаасаа гэснээс илүүтэйгээр тухайн цаг үеийнхээ тэр салбарынхаа BENCHMARK-тай уялдах ёстой л гэж ийм байр суурьтай байдаг.

Жишээ нь, “Эрдэнэс Монгол” нэгдэл баялгийн сангийн орлогыг төвлөрүүлж байгаа байгууллага. Орлогыг төвлөрүүлж байгаа. Энэ хууль гарснаараа баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэхэд маш том дөхөм хөшүүрэг өгнө.

“Эрчис Монгол” ч гэсэн өөрөө менежментийг сайжруулах ажлыг нь зохион байгуулах болохоос биш зүгээр өмч бүртгэдэг ажлыг тэд хийхээ болино.

Ингэхээр Засгийн газрын тохируулагч агентлагийн хувиар Төрийн өмчийн хороо өөрөө тэр хяналтаа тавьдаг, өмчийг бүртгэдэг, түүндээ эзэн болно. Төр өөрийнхөө өмчид эзэн болох ийм бололцоо бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

Ингээд энэ 8.1.1-ээс 8.5 дээр нийтийн зориулалттай нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах.

Хоёр нь, үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт үйл ажиллагаа явуулах буюу одоо энэ Эрдэнэт, Эрдэнэт үйлдвэр, МИАТ ч гэдэг юм уу.

Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нөгөө хууль хяналтын байгууллагын дэргэдэх байгууллагууд.

Дээрээс нь хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу буюу энэ Их Хурлаар батлагдсан. Жишээ нь, “Оюу Толгой”, саяын “Бадрах Энержи” ч гэдэг юм уу. Эсвэл хуулийн дагуу буюу Хөгжлийн банк. Хуулиар

байгуулагдсанаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахыг хуулиар хориглож байна гэсэн үг.

Энэ бол үндсэн чиглэл. Гэхдээ үүний үндэс шаардлага нь юу вэ гэхээр зах зээлийн төвлөрөл багатай хувийн хэвшил оролцох боломжгүй салбар гэдэг нь өөрөө үндсэн шаардлага байна.

Тэгэхээр зах зээлийн төвлөрлөө судлаад, үндэслэлээ бариад холбогдох салбарын яам нь Засгийн газарт саналаа оруулна. Засаг дарга иргэдийн Хурал саналаа оруулснаараа л байгуулагдана. Бусад байгуулахгүй л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн горимын санал гаргая.

Ц.Даваасүрэн: Баярлалаа.

Тэгэхээр энэ хууль дээр нийт ард түмний өмч, төрийн өмчийн асуудал яригдаж байгаа. Гэтэл энэ өмчийн асуудлыг Их Хурал мэддэг байсныг Засгийн газар мэддэг болгочихсон ийм заалт орж ирж байгаа юм. Тухайлах юм бол одоо энэ компаниудыг татан буулгах бол Засгийн газрын хүрээнд, энэ хувьцааны асуудлыг шийдэхэд та нар тэр 12, 13-ыг хараарай. Ерөөсөө ингээд л Засгийн газрын түвшинд шийднэ.

Тэр битгий хэл “төрийн өмчийн компани” хувьцаа гаргах асуудлыг зөвхөн Сангийн сайд шийдэхээр хийсэн байгаа байхгүй юу. Энэ чинь болохгүй ээ. Нэг өглөө босоод ирэхэд л нөгөө компани хувьцаа гаргаад л аль нэг этгээд шилжчихсэн байхаар ийм юм хийчихсэн байгаа байхгүй юу. Энэ болохгүй.

Тэгээд төрийн өмчийг 9 бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлийн 3 хүн нь л төрийн өмчийн төрийн албан хаагч байна. Бусад нь үгүй гэж байгаа байхгүй юу. Хэн хэний ах дүү нь орохыг нь бүү мэд.

Тийм учраас төрийн өмчийг ингэж наргиж Засгийн газрын түвшинд шийдэх тухай ийм хуулийн төслийг бид яаралтай горимоор хэлэлцэж болохгүй. Энэ чинь Монголын ард түмний өмч.

Тийм учраас энэ асуудлыг би ирэх хаврын чуулганаар хэлэлцэх горимын саналыг хураалгаж өгөөч гэж хүсэж байна. Ингэж болохгүй. Улс орныхоо өмч хөрөнгийг ингэж Засгийн газрын түвшинд, ганц сайдын хүрээнд, сайд нарын хүрээнд шийддэг байж огт болохгүй. Их Хурлаар заавал орж ирнэ.

Энэ чинь хувьцаа гаргах тухай асуудлууд Их Хурлаар орж ирдэг биз дээ. Бид нээлттэй болгох энэ тэрийг Их Хурлаар оруулж ирсэн шүү дээ. Чи битгий худлаа яриад байгаарай. 15.1-ийг хар чи.

Төрийн өмчийн хувьцаа гаргахад төрийн. За чи. Би уншаад өгчихье. Битгий солироод байгаарай, чи зүгээр.

Энд ингэж байна шүү дээ. Төрийн өмчит компанийн хувьцаа гаргах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэж гаргана. 15.1-ээ хар чи.

Д.Амарбаясгалан: Ц.Даваасүрэн гишүүн. Энэ юу шүү дээ. Яах вэ өнөөдөр бол хэлэлцэх эсэх асуудал яригдаж байгаа.

Мөн дээрээс нь энэ яаралтай горимоор хэлэлцэгдээгүй. Ердийн горимоор явж байгаа. Улсын Их Хурал дээр процесс нь анхдагч хуулийн төсөл өргөн баригдсантай холбоотой хууль зүйн дүгнэлт 10-аас 15 хоногийн дотор гарах ёстой.

Тэгээд Улсын Их Хурлын Хууль зүйн хэлтсээс хууль зүйн дүгнэлт гаргаад өнөөдөр Байнгын хороо руу орж хэлэлцэх эсэх асуудал явж байгаа.

Тэгээд энэ хэлэлцэх эсэх асуудал шийдэгдчихвэл Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэг байгуулагдаад хаврын чуулган хүртэлх хугацаанд дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулахаар байгаа юм. Ер нь хуваариараа. Яаралтай биш. Хаврын чуулганаар орно шүү дээ.

Өнөөдөр бид зөвхөн хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудлаа л шийдэж байгаа юм. Тэгээд сая П.Сайнзориг гишүүн санал гаргаж байна. Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хурал хийж асуудлаа шийдмээр байна гэж байна.

Ер нь бүх Байнгын хороогоор хэлэлцэнэ. Хаврын чуулган эхлээд Хууль зүй, Төсөв, Төрийн байгуулалт, Эдийн засгийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн байнгын хороо гээд Байнгын хороод бүгдэнгээр нь орж хэлэлцэгдэнэ. Магадгүй тухайн үед нь шаардлагатай гэж үзвэл Байнгын хороодын саналаар зарим Байнгын хороодыг хамтад нь хуралдуулж асуудлыг шийдвэрлэх дэгийн зохицуулалт ч байгаа.

Тэгэхээр өнөөдөр төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулахтай холбоотой хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг л шийдвэрлэнэ гэж ойлгох хэрэгтэй.

Мэдээж Улсын Их Хурлын гишүүдэд зарчмын зөрүүтэй маш олон саналууд байгааг анзаарч байна. Өнөөдөр үдээс өмнө болсон Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр ч гэсэн гишүүд зарчмын зөрүүтэй маш олон саналуудыг хэлж байгаа анзаарагдсан.

Тэгэхээр үүнийг ажлын хэсэг хэлэлцүүлэгт бэлтгэх чиглэл дээр гишүүд яг энэ санал санаачилгаараа маш өргөн хүрээгээр орох нь зүйтэй. Ажлын хэсгийг ч

гэсэн өргөн бүрэлдэхүүнтэй байгуулаад ажиллах нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байгаа.

Тэгэхээр яах вэ, горимын саналыг ер нь хаврын чуулганаар хэлэлцэнэ. Өнөөдөр зөвхөн бид цаг хугацаагаа хэмнэх үүднээс энэ намрын чуулганы төгсгөл дээр хэлэлцэх эсэхийг нь шийдэж өгөөд ажлын хэсэг байгуулаад ажиллах боломжийг нь л олгож өгье. Цаг хугацаа гаргая л гэж байгаа юм.

Ц.Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Тэгвэл яаралтай горимоор хэлэлцэхгүй гэж ойлголоо. Энэ угаасаа яаралтай горим хэлэлцэх асуудал биш.

Тийм учраас би яаралтай горимоор хэлэлцэх саналаа татлаа.

Ер нь энэ асуудлыг маш нухацтай Их Хурлын гишүүд минь хэлэлцэхгүй энэ болохгүй шүү. Үеийн үед энэ төрийн өмчийг хувьчилж авах гэсэн оролдлого явсаар ирсэн. Түүний нэг орж ирж байна гэж ингэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт тайлбар өгье.

Н.Учрал: Ц.Даваасүрэн сайд энэ олон нийт харж байна шүү дээ. Аливаа зүйлд хариуцлагатай яриарай.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн 21.16 одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар “төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч үнэт цаас гаргана” гэдэг ийм заалт угаасаа байдаг биз дээ.

Түүнээс биш нээлттэй болгох, хувьцаа гаргах асуудал Их Хуралд байгаа. Одоо таны наад заалт чинь бид шинээр оруулж ирж, төрийн болон орон нутгийн өмчийн хуулиараа Сангийн сайдаас үнэт цаас гаргах бол, зээл авах бол зөвшөөрөл авдаг. Үе үеийн Засгийн газрын ийм ажил хийгээд л явдаг шүү дээ.

Түүнээс биш хувьцаа гаргах тэр үйл ажлыг чинь Их Хурлаар шийддэг. Би энэ хуулийг яриагүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар ингэж шийддэг. Үнэт цаас гаргах зөвшөөрлийг одоогийн Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн 21.16 дээр байна шүү дээ. 21.16 буюу одоогийн таны хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа таныг сайд байх үед угаасаа байсан дээр үнэт цаас гаргах бол, зээл авах бол Сангийн сайдаас зөвшөөрөл авдаг биз дээ.

Хувьцаа гаргах асуудлуудыг энэ хуулиар яах вэ гэхээр Засгийн газар тэр төрийн өмчид баримтлах чиглэлээ хэрвээ тэр компанийг нээлттэй болгох гэж байвал, хувьчлах гэж байвал тэр шийдвэрээ Их Хурлын тогтоолоор Их Хурлаар оруулж ирж шийдэх эрх нь энд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид бас нийгэм, олон нийтийн хэлэлцүүлэг хийж байхад ингэж ярьж болохгүй л дээ.

Энэ бол өөрөө OECD-гийн үндсэн зарчим. Үндсэн зарчим шүү дээ. Бид OECD /**Organisation for Economic Co-operation and Development**/ буюу Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын үндсэн зарчмыг барьсан.

Хоёрт, өнгөрсөн хугацаанд 8 жилд үүнийг EBRD /**The European Bank for Reconstruction and Development**/ зөвлөх үйлчилгээгээр ажилласан юм билээ. Энэ миний яриад байгаа ч юм биш. Энэ үе үеийн Засгийн газарт боловсруулагдаж байсан хууль.

Нэг ч эрхийг Засгийн газарт аваагүй.

Хоёрт, та Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хуулийн 21.16-г хараарай.

Түүнээс биш өөр ямар ч заалт ямар ч Засгийн газарт эрх мэрх авсан юм байхгүй. Харин энэ хууль гарснаараа зүгээр амьдрал дээр энэ асуудлууд нэг тал руу шийдэгдээд явна. Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд аль компанийг нээлттэй болгох юм, яах юм, ийх юм гэдгээ шийднэ.

Түүнээс биш тэгж дураараа тэгж хувьчилж, нээлттэй болгож байдаг эрх салбарын сайдад байх боломж байхгүй. Та төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн 21.16-г хараарай. Баримтлах чиглэлийг Их Хурлын хуулийн дараа заавал Их Хурлаар засаг оруулж ирэх юм. Баримтлах чиглэл гээд.

Тэр чиглэлээрээ тогтоолынхоо хүрээндээ яаж шийдэх вэ гэдгээ оруулж ирэхээс биш энэ хуулиар ч шийдэх юм биш. Үндсэн чиглэлийг оруулж ирж байя гэдэг ийм заалтыг оруулж ирсэн юм. Та наадхаа хараарай гэж.

Д.Амарбаясгалан: Тэгээд яах вэ гишүүд бас энэ ярьж байгаа санал их зөв юм байгаа юм. Н.Учрал сайд аа, ажлын хэсгийнхэн энэ дээр анхаарчих.

Ер нь нэгэнт бид энэ төрийн өмчийн. Ц.Даваасүрэн гишүүн ээ, төрийн өмчит компанийн засаглалтай холбоотой асуудлыг хөндөж байгаа энэ хууль маш өндөр ач холбогдолтой өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийгдэж батлагдах ёстой.

Зүгээр ийм хууль гарангуутаа зөвхөн төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг нь зохицуулдаг хэмжээнд Компанийн тухай хуулиас салангид нэг хууль гарч байгаа хэлбэрээр явбал зохимжтой зүйл биш.

Зүгээр энэ хууль батлагдсанаараа яаж ил тод байх вэ, яаж үр ашигтай байх вэ, төр ямар төрлийн ажил үйлчилгээ, бизнес рүү оролцох боломжтой юм,

аль руу нь орохгүй юм бэ гэдгийгээ тодорхойлох гэж байгаа зарчмуудыг нь ойлгож байгаа юм. Гэхдээ засаж залруулах юм бол энэ дотор их байгаа гэж харж байна.

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр төрийн бодлого, шийдвэр, хууль юун дээр үндэслэж гардаг вэ гэвэл нийгэмд үүсэж байгаа проблемыг шийдэхийн тулд л бид төрийн шийдвэр гаргаж ингэж сууж байгаа.

Өнөөдөр нийгэмд энэ төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой хулгай их байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн захирлууд гэмт хэрэгт холбогдож байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зардал нь өндөр байна. Ашиг нь бага байна. Ашиггүй ажилладаг төрийн өмчит компанид төлөөлөн удирдах зөвлөл ажиллана гэдэг нь ямар утгатай юм. Би тэрийг сайн ойлгохгүй.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд зах зээлд оролцох оролцоо нь нэмэгдсээр байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төлөөлөн удирдах зөвлөл нь нэр төдий ажиллаж байна. Гэх мэтчилэн ийм проблемууд байгаад байгаа юм. Ийм проблемууд байгаад байгаа юм.

Энэ проблемыг шийдэхийн тулд төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулахтай холбоотой хууль орж ирж байна гэж харж байгаа. Хуулийн төслийг нь уншаад үзэхэд яг энэ бүрэн шийдэгдсэн хууль болж чадаагүй байна. Маш их хэмжээний найруулгын бөгөөд агуулгын зүйлүүд байна.

Би намын бүлэг дээр орж ирэхэд энэ саналыг хэлсэн. Өнөөдөр дахиад л яг энэ чигээрээ л орж ирж байна. Их Хурал дээр ажлын хэсэг гаргаад цаашаа хэлэлцээд явах уу, эсвэл үүнийг нь хэлэлцэх журмаар дэмжээд явах уу, эсвэл буцаах уу гэдэг шийдвэр гаргахаар хуралдаж байгаа гэж өнөөдрийн хурлыг би ингэж ойлгож байгаа.

Ингээд би хэд хэдэн асуултуудыг асуумаар байна. Өнөөдөр энэ төрийн өмч гэдэг цаанаа угтаа ард түмний өмч. Эцсийн өмчлөгч, эцсийн ашиг хүртэгч нь ард түмэн.

Үүнийг менежментийн хийх, сайжруулах, ард түмэнд ашигтай хэлбэрээр авч явах үүрэг нь төрийн үүрэг. Төрийн үүрэг.

Өнөөдөр энэ хуулийг би орж ирэхдээ яагаад энэ төрийн өмчийн тухай хууль болон төрийн өмчийн засаглалын хууль хоёр яагаад хамтдаа нэг ч цогц болж орж ирээгүй юм бэ гэдэг дээр би жоохон гайхаад байгаа юм.

Миний хувьд Төрийн өмчийн хороонд ажиллаж байсан хүний хувьд “төрийн өмч” гэдэг “орон нутгийн өмч” гэдэг агуулга дээр би өнөөдрийг хүртэл эргэлзсэн хэвээрээ явдаг юм. Хуулийг аваад үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дээр “төр нь нийтийн өмчийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар тогтооно” гэдэг заалт байгаа. Үндсэн хуулийн 59.2 дээр “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлнэ” гэдэг ийм заалт байгаа. “Орон нутгийн өмчтэй байна” гэсэн ийм зүйл, заалт байхгүй.

Тэгэхээр энэ өмчийн ойлголтын асуудлуудыг нэг болгох үүднээс энэ хоёр том хуулийгаа, төрийн өмчийг зохицуулсан хоёр том хуулийг хамтад нь оруулж ирэх асуудлыг оруулж ирж болоогүй юм уу гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нь, төрийн өмчийн эцсийн ашиг хүртэгч нь ард түмэн юм бол энэ хувийн хэвшилтэй төрийн байгууллага, төрийн өмчит компаниуд өрсөлддөг явдлыг бүрмөсөн хаах хэрэгтэй гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн хийж чадах ажлыг төрийн өмчит компаниуд хийнэ гэдэг үндсэндээ хувийн өмч рүү халдаж байгаа хэлбэр.

Тийм учраас үүнийг хаасан заалтыг оруулж ирж өгөх ёстой байсан гэж би үзэж байгаа юм.

Мөн төлөөлөн удирдах зөвлөл компанийг ашигтай ажиллуулах бүх зүйлийг хийх ёстой. Гүйцэтгэх удирдлага болоод төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Гэтэл гүйцэтгэх удирдлагууд өнөөдөр өөрийгөө төрийн өмчийн эзэн гээд ойлгочихсон. Яг эзэн мэтээр төрийн бусад байгууллагууд, гүйцэтгэх удирдлагатай харьцдаг. Үүнтэй чинь холбоотой төрийн өмчит компаниудын засаглал муудаад байгаа юм. Алдагдаад байгаа юм.

Ийм учраас энэ хууль дээрээ хувьцаа эзэмшигчид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Заяабал: Хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүрэг, гүйцэтгэх удирдлагуудын эрх үүргийг маш тодорхой тусгаж өгөх хэрэгтэй.

Гүйцэтгэх удирдлага өнөөдөр төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр ирээд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрүүдийг хүлээж аваад, Засгийн газруудын шийдвэрийг хүлээж аваад шууд хэрэгжүүлэх тийм субъект биш шүү дээ. Биш.

Өнөөдөр яг үүнээс чинь болоод төлөөлөн удирдах зөвлөл нэр төдий ажиллаж байгаа. Өнөөдөр гүйцэтгэх удирдлага хариуцлага хүлээх биш

төлөөлөн удирдах зөвлөлүүд нь өнөөдөр гүйцэтгэх удирдлагын өмнөөс хариуцлага хүлээх ёстой.

Энэ засаглалын хууль батлагдсантай холбоотойгоор үүнээс цааш гүйцэтгэх удирдлага биш төлөөлөл хэрэгжүүлж байгаа нөхдүүд хариуцлага хүлээдэг ийм зохицуулалтууд орж ирж байж энэ засаглалын чинь энэ хууль сайжирсан байх ёстой. Гэтэл энэ агуулгаараа орж ирээгүй байна шүү гэдгийг би Та бүхэнд хэлэх гэж байгаа юм.

Хуулийн хуулийн төслөөс задлаад асуух юм бол 7 дугаар зүйл ямар учиртай юм бүү мэд. Төрийн өмчит компанийн үндсэн чиглэлийг оруулж ирнэ гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Н.Учрал сайд. Б.Цэнгэл дарга хариулт өгье. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Цэнгэл: Б.Заябал гишүүний асуултад хариулъя.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Тэгээд ач холбогдлоор нь энэ Компанийн хуулийг эхлээд өргөн барьчихъя гэж байгаад Засгийн газар хуралдаанаараа шийдээд Их Хуралд өргөн бариад явж байгаа юм.

Сая Эдийн засгийн байнгын хороо дээр ч гэсэн санал гарч байна лээ. Энэ хоёр хуулийг хамтад нь хэлэлцээд явъя гэсэн.

Тэгээд үүнийг хэлэлцэх эсэх нь дэмжигдээд цаашаа явчих юм бол ажлын хэсэг гараад ажлын хэсэг дээр саналуудаа гаргаад явахад бүрэн бололцоотой гэж үзэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх хүн байна уу?

Б.Цэнгэл дарга аа, гишүүдийн ярьж байгаад нэг зүйл байгаа шүү дээ. Мэдээж энэ дээр маш болгоомжтой хандахгүй бол төрийн өмч ямархуу хэмжээнд байх юм, яагаад ер нь “төрийн өмчит компани” гэж байх ёстой юм гэдэг энэ ойлголтууд энэ дунд маш сайн яригдах ёстой. Тийм ээ.

Жишээ нь, “Эрчис Монгол” гэж компани байгуулъя гээд засаг шийдэж байгаа гэсэн. Жишээлбэл, төр, хувийн хэвшил нь сонирхохгүй байгаа зарим төрлийн бизнес үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд авч явах зорилгоор төрийн өмчит компаниудыг байлгаж байгаа гэдэг ерөнхий ойлголт явж байгаа юм. Тийм ээ.

Өнөөдөр яригдаж байгаа зүйл дотор “ашиг олохгүй байгаа бол” гэдэг үг гарч ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр “төрийн өмчийн компани” чинь өөрөө ашиг олох зорилго юм уу, хувийн хэвшлийн сонирхохгүй нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагатай. Жишээлбэл, цахилгаан станцуудаас өгсүүлээд төр заавал нуруундаа үүрч явах хэрэгцээ шаардлага байгаа учраас энэ хууль гарах гэж байгаа юм уу гэдгийгээ Та хэд маань ялгаж салгахгүй бол эхнээс нь болгоомжлуулж хэлж байгаа зүйл төрийн өмчит компанийн нэг хуультай, хувийн өмчит компанийн нэг хуультай. Нөгөө олон нийтийн шүүмжилдэг төр болохоор нэг өөр, хувийн хэвшил болохоор нэг өөр гэдэг ойлголт, дүгнэлтэд бид аваачиж болохгүй.

Хэрвээ тийм зорилго явж байгаа тохиолдолд бид энэ хуулийг батлах шаардлагагүй. Компанийн тухай хуулиа сайжруулаад л, Компанийн тухай хуулиараа эзэмшигч нь хэн байх юм бэ гэдэг дээр бид тодруулах асуудлыг ярих ёстой.

Н.Учрал сайдын танилцуулга дээр үүнийг төлөөлөн удирдах зөвлөл, төрийн өмчит компаниудын удирдлагын тогтолцоо, цаашлаад тодорхой үр өгөөжийн асуудлыг яриад байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр үүнийгээ сайн ялгаж салгаж тайлбарлаж ойлгохгүй бол гишүүд их болгоомжилж байгаа нь нэг талдаа зөв шүү. Нэмж хариулъя. Б.Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Тэгэхээр бид компаниудаа ерөнхийдөө ангилж авч үзье гэдэг ийм зарчим барьж байгаа.

Өөрөөр хэлбэл нийтийн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа компаниудыг заавал ашигтай ажиллахыг шахах шаардлагагүй.

Тэгэхээр тийм компаниуд буюу улсын үйлдвэрийн газар төсөвт аж ахуйн тооцоотой гэдгээс салгаад улсын үйлдвэрийн газрын статусыг компанийн хэлбэрт шилжүүлээд сонгодог компанийнх нь зарчмаар нь явъя.

Нэн ялангуяа төсөвт гэдэг нь нэр зүүж байгаа буюу ашиг шаардагдахгүй ашгийн төлөө ажил гэж шахах ийм боломжгүй компаниудыг тухайлбал бид төрийн болон орон нутгийн өмч дээрээ ангилалт бас оруулж ирэх гэж байгаа. Энэ дээр тухайлбал “албан байгууллага” гэдэг статус “паблик” тал руу нь ангилаад явчихъя гэдэг зүйл яригдаж байгаа.

Тэгэхээр нөгөө хоёр хуулийн хоорондын уялдаа холбоог хангах тухай асуудал чухал гээд Их Хурлын гишүүдээс яриад байгаа санал анхаарах ёстой санал гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Харин тийм. Тэгээд ашиггүй ажиллаад 3 жил ажиллавал татан буулгана гэдэг заалт ороод ирж байгаа. Яг энэ хариултын заалт хоёр яаж зөрчилдөх вэ гэдэг асуудал гарч байна шүү дээ.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Дөнгөж сая оюутнуудтай уулзаад орж ирлээ.

Тэгээд Улсын Их Хурлын тамгын газраас “Open Parliament” гээд 100 оюутны хүрээнд дадлагажих хөтөлбөр зохион байгуулж байгаа. Энэ хүрээнд 100 оюутандаа “Эдийн засгийн эрх чөлөө” гэдэг сэдвээр ярилцаад, илтгэл тавьчхаад орж ирээд яг өнөөдрийн энэ уур амьсгал руу, өнөөдрийн хэлэлцүүлгийн уур амьсгал руу ороод ирсэн байгаа.

Тэгэхээр ер нь өнгөрсөн 30 хэдэн жилийн туршид Монголчууд бидний хувьд эдийн засгийн эрх чөлөөгөө баталгаажуулах, бизнесийн орон зайгаа тэлэх, эдийн засгаа тэлэх, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах чиглэлд ямагт л нэг номерын асуудал байсан.

Үүн дээр маш олон алдаа оноо, сургамж, сорилтуудыг бид туулсан. Тэгээд энэ төрийн өмчит компанийн засаглалтай холбоотой өнөөдөр энэ орж ирж байгаа хуулийн төсөл бол бас эдгээр сорилтуудыг даван туулахтай холбоотойгоор өргөн баригдаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд яасан бэ гэхээр ер нь төр нь данхайгаад төсөв нь данхайсаар байгаад л бид ерөөсөө цаад талынхаа хувийн хэвшлийнхээ, бизнесийнхээ орон зайг маш ихээр хумьчихсан.

Тэгэхээр сая гишүүд тодорхой тоо баримтуудыг дурдаж байна. Үүн дээр цөөн хэдэн тоо баримтыг дурдъя гэж бодож байна.

Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хэмжээний 99 хуулийн этгээдэд нийт 58 мянган хүн ажиллаж байна. Энэ нь төрийн албан хаагч 230 мянган хүн дээр нэмэгдээд гэж ойлгож байгаа. 99 хуулийн этгээд нийтдээ 23.6 их наяд төгрөгийн орлоготойгоор ажилласан байна. Энэ бол 2023 оны тоо. 2021 онд орлогын хэмжээ 10.6 их наяд төгрөг байсан.

Тэгэхээр юу гэсэн үг вэ гэхээр ерөөсөө 2 жилийн дотор төрийн өмчит компаниудын орлогын хэмжээ даруй 2 дахин буюу 13 их наядаар нэмэгдсэн байна.

Энэ бүхэн маш их хэмжээний тийм хардалт сэрдэлт, авлига, хээл хахууль гэх зэрэг зүйлүүдийг дагуулж байгаа.

Тэгэхээр яагаад энэ орлого нэмэгдээд байна вэ гэхээр яах аргагүй уул уурхайн өсөлттэй холбоотой. Бид их хэмжээний нүүрс гаргаж эхэлсэнтэй холбоотой. Уул уурхайн түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой ийм үзүүлэлтүүд байгаа юм.

Тэгэхээр цаана нь төсвийн хэмжээгээ энэ дээр нэмэх юм бол ерөөсөө цаана нь бизнесийн орон зай дотоодын нийт бүтээгдэхүүний чинь 30, 40 хэдхэн хувь дээр л хувийн хэвшлийн орон зай үлдэж байгаа юм.

Тэгэхээр бид яаж хувийн хэвшлийнхээ орон зайг тэлэх юм бэ? Бизнесийнхээ орчныг сайжруулах юм бэ? Яаж төрийн өмчит компаниудтай эн тэнцүү өрсөлдөх юм бэ гэдэг бодлогыг бодохын тулд л энэ хуулийн төсөл орж ирж байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр төр бол маш муу менежер. Тийм ээ. Төр заавал алдагдалгүй ажиллах ёстой гэдэг бас нэг тийм зүйл сүүлийн үед яригдаад байгаа. Сүүлийн үед ч юу байх вэ. Ер нь өнгөрсөн хугацаанд яригдаж байсан. Гэхдээ жишээлбэл би арай жоохон эсэргүү юм ярих гээд байгаа юм. Юу вэ гэхээр энэ оруулж ирж байгаа хуулийн төслийн 36.1.1 дээр тухайн компани 3 жил дараалан алдагдал хүлээсэн нөхцөлд гүйцэтгэх захирал хариуцлага хүлээхээр байгаа юм.

Тэгэхээр төрийн өмчит компаниуд дээр арай өөр шалгуур, шаардлагууд тавигдах ёстой болов уу гэж харж байгаа юм. Зөвхөн өнгөрсөн 30 жилийнхээ алдаа дутагдал дээр үндэслээд “төрийн өмчит компани” заавал ашигтай ажиллах ёстой гэсэн зүйлийг механикаар тулгаж болохгүй гэсэн нэг зүйл харагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ төрлийн механик заалтууд маш олон байна. Жишээлбэл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, компанийн гүйцэтгэх захирлын захиралд тавигдах шаардлагууд ч гэсэн маш тийм механик зохицуулалтууд орж ирсэн байна. Тухайн нэг тодорхой салбарын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье. Б.Жаргалан гишүүнд.

Б.Жаргалан: Тэгэхээр ямарваа нэгэн салбарт заавал мэргэжил эзэмшсэн байх ёстой ч гэдэг юм уу, ийм механик шаардлагууд тавигдаад байна.

Тэгэхээр заавал ийм механик шаардлага тавилгүйгээр топ менежерүүдийг авахын тулд бид маш тийм нээлттэй, ил тод байх ёстой гэж харж байна.

Тэгэхээр асуулт. Энэ хуулийн төсөлд хувийн хэвшлийн төлөөллөөс санал авсан уу? Өнгөрсөн хугацаанд бий болсон манай хүний нөөц бол маш тийм сайн хүний нөөц хувийн хэвшил дээр бий болсон байгаа. Топ менежерүүдээсээ саналыг нь авсан уу гэсэн нэгдүгээр асуулт.

Тэгээд томоохон төрийн өмчит компаниудын аудитын тайлангуудад дүн шинжилгээ хийсэн үү?

Өнгөрсөн хугацаанд гарсан эрүүгийн хэргүүд ч үүссэн байгаа. Эдгээр хэргүүд дээр дүн шинжилгээ хийсэн үү? Өнгөрсөн хугацаанд хаана алдаа

гаргаад байв? Энэ засаглал хаанаа алдаатай байна гэдэг дээр яг ямар бодит судалгаанууд хийгдсэн бэ гэдэг асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 20 дугаар микрофон.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Д.Цолмон. Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх хуулийн шаардлага байгаа. Тэгээд ерөнхийдөө хуулийн төслийг 3 түвшинд хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Нэгдүгээрт, төрийн өмчит компаниудын удирдлагын хүрээнд энэ хуулийн төслийг хэлэлцүүлж санал авсан.

Хоёрдугаарт, хувийн хэвшлийн төлөөлөл болсон Монгол Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим дээр бид хамтран хуулийн хэлэлцүүлгийг өргөн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж саналыг нь авсан.

Гуравдугаарт, Санхүү, эдийн засгийн сургуультай 100 жилийн ойн арга хэмжээнд тохиолдуулаад бид бас энэ хэлэлцүүлгийг хийсэн.

Энэ хэлэлцүүлгийн хүрээнд яг хувийн хэвшлийн хөндөж байгаа асуудал юу байсан юм бэ гэвэл төр ерөөсөө ямар ч салбартаа орж бизнесийн үйл ажиллагаа эрхлэх. Үүнийг тодорхой болгож өгөөч.

Хоёрдугаарт, засаглалыг сайжруулах чиглэлдээ мэргэжлийн хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлэх чиглэлдээ Та бүхэн илүү хуулийн төсөлдөө нарийвчилж анхаарч өгөөч ээ гээд. Тухайлбал, хараат бус гишүүдийн тоог 3 хувь гэдэг тоогоор хязгаарлахгүйгээр 50-иас дээш хувьд бүрдүүлж өгөх боломж байгаа эсэх талаар дурдаж байсан.

Яг энэ хуулийн төслийн тодорхой заалт дээр Та хэлж байна. 3 жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн аж ахуйн нэгжүүдийг татан буулгах. Үүнтэй холбоотойгоор гүйцэтгэх захиралыг нь ажлаас чөлөөлөх зохицуулалт нь механик байна гээд.

Ерөнхийдөө яг энэ бол гол хөшүүрэг байгаа. Гүйцэтгэх удирдлага ТУЗ-тайгаа гэрээгээ байгуулаад бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлээд, тухайн жилдээ зорьсон үзүүлэлтдээ хүрсэн эсэхийг нь дүгнүүлээд явж байгаа.

Хэрвээ энэ тодорхой амжилтад хүрээгүй, ашигт ажиллагаагаа олж чадаагүй байгаа бол энэ чөлөөлөх үндэслэл болж байгаа.

Хэрэв таны ярьж байгаа нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт явуулж байгаа аж ахуйн нэгж байх юм бол энэ

харилцаанд тодорхой EXCEPTION заалтыг бас энэ 36.5 дээр бид тодорхой тусгасан байгаа.

Нэмэлтээр аудитаар манай тийм ажлын хэсгийн гишүүн нэмэлтээр хариулж болох уу? Улсын Их Хурлын дарга аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

О.Баярмагнай: Аудиттай холбоотой тайлбарыг өгье. “Эрдэнэс Монгол”-оос О.Баярмагнай.

OECD-гийн засаглалын зарчмын ерөнхийдөө 156-аас 160 асуулт байдаг. Төрийн өмчит компаниуд дээр засаглалын үнэлгээ хийхэд ер нь засаглалын үнэлгээгээр унаж байдаг.

Өөрөөр хэлбэл 100 оноо авах ёстойгоос 50-иас 60 оноог бид авч байдаг. Яг тэр гарч ирж байгаа асуудал нь дотоод хяналтын тогтолцоо өөрөө хангалтгүй байна, хараат бус байдал нь өөрөө алдагдаж байна гэсэн ийм үнэлгээнүүд компаниудын засаглалын үнэлгээн дээр ерөөсөө гараад явж байдаг.

Дээрээс нь Үндэсний аудитын гаргасан тайлангууд дээр байж байгаа. Энэ төрийн өмчит компаниудын дотоод хяналтын засаглалыг оновчтой болго, олон улсын **Three Lines of Defense** буюу хамгаалалтын шугаман гурвын хяналтын тогтолцоонд оруулж өг. Хараат бус байдал өөрөө энэ хууль, эрх зүйн орчин дээр тодорхой тусаагүйгээс өнөөдөр энэ юу гэдэг юм, эрсдэл асуудлууд бий болж байна гэж байгаа.

Үүнтэй холбоотойгоор манай энэ хуулийн 37, 38 дээр дотоод хяналтын тогтолцоотой холбоотой холбогдох заалтууд нарийвчлан тусгагдсан. Дотоод аудит бол санхүүгийн аудит хийх биш юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

О.Баярмагнай: Маш олон төрлийн аудитыг хийх хэрэгцээ шаардлага байж байдаг.

- Процессын аудит,
- Үйл ажиллагааны аудит,
- Санхүүгийн аудит,
- Засаглалын аудит,
- IT[Information technology]-ийн аудит,
- Мэдээллийн технологийн, мэдээллийн аюулгүй байдлын аудит,
- Загварчлалын аудит

гээд аудитын өөрөө олон улсын ийм 20-иод төрөл байж байдаг.

Өнөөдөр бид зөвхөн “гүйцэтгэлийн”, “нийцлийн” аудит хийгээд байна.

Энэ бол зөвхөн цааснаас цаас ба COMPARATION буюу харьцуулалтын аудит хийж байгаа учраас энэ аудитын шаардлага хангагдахгүй байна гэдэг үүднээс бид энэ хараат бус байдлыг маш тодорхой тусгаад өгчихсөн байж байгаа.

Тухайлах юм бол манай хуулийн 37.13 дугаар заалт дээр Та бүхэн хараарай.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод аудитын үйл ажиллагааг хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй гэсэн ийм заалт тусгаад өгчихсөн.

Энэ заалт өөрөө бодитойгоор хэрэгжсэнээс хойш дотоод аудит хөндлөнгийн ямар нэгэн нөлөөлөлд автахгүйгээр аудитын ажлыг явуулах боломж өөрөө бүрдэж байгаа.

Тэгэхээр гүйцэтгэх удирдлагын багийг ТУЗ-аас бүрэн хянах хяналтын тогтолцоо энэ хууль дээр тусгагдчихсан байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Чухал хууль орж ирж байгаа учраас хэд хэдэн, өмнө ч гэсэн асуусан санал асуулт хэлье.

Үүний цаана хувьчлалын асуудал явчих вий дээ гэдэг дээр олон хүн болгоомжилж байх шиг байна. Би ч гэсэн тийм санал байгаа. Зөв юмыг буруу тийш нь оруулаад, хуулийн цоорхой гаргаж байгаад ийм юм руу орчих вий дээ.

Зөвхөн ашгаар үнэлгээ хийгээд хувьчлах, өөрчлөн байгуулах гэдгийг нь мушгиж авч яваад ингээд явчих тийм эрсдэл байх вий. Тухайлбал, 90-ээд онд маш олон хувьчлал явсан л даа. Мэдээлэлд ойрхон, тодорхой хэмжээний хөрөнгө мөнгөтэй хүмүүс нь үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагыг аваад. Хөөрхий тэгээд тэнд байсан тэр байгууллагын хамгийн үнэт зүйл болсон тэр ажилчдыг үл тоосноос болоод тэр байгууллагууд ихэнх нь тарсан. Хүүхдийн пионерын зуслангаас авхуулаад хувьчилсан. Одоо тэнд нь дандаа хотхон, хороолол, өөр зориулалттай болсон.

Тийм учраас тэр нийгмийн чиглэлийн ашгийг харахгүй гэдэг энэ үзүүлэлтүүдээ маш нарийн олон хэмжээ хязгаараар авч үзэхгүй бол болохгүй гэдгийг хэлмээр байна.

Ер нь энэ 30 жилийн хугацаанд ажилчид ер нь юу хожсон бэ? Одоо энд чинь 10, 20 жил, 30 жил ажиллаж байгаа хүмүүс байгаа. Тэтгэвэртээ гарахаа

хүлээгээд сууж байгаа хүмүүс байгаа. Ашиггүй ажилласан, компани дампуурсан. Чи өөрөө хаанаа ажиллаж болохоо өөрөө мэд гэдэг байдлаар хөөрхий хамгаалалтгүй ажилчид нь хамгийн түрүүн л гудамжинд гарна л даа.

Тийм учраас яах вэ зүгээр үүнийг би болгоомжилж хэлж байгаа юм.

Хуулийн хувьд нөгөө талаас нь төрийн өмчийн компаниудыг нүүдлийн шувуу шиг улс төрийн зорилгоор маш олон хүмүүс очиж үймүүлдэг. Тэр компанид сэтгэл зүрхээ, оюун бодлоо зориулсан олон хүмүүсийг хоморголон халдаг, явуулдаг, үзэл бодол нийлээгүй гэдгээр нь хавчин гадуурхаж явуулдаг. Энэ нь өөрөө тухайн компанийн хамаг үнэт зүйл нь алга болдог. Тэр мэдсэн зүйлээ өөр компани, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж, өрсөлдөөний “ноухау”-г нь зардаг ийм л зүйл түлхдэг л дээ.

Тийм учраас түрүүн П.Сайнзориг гишүүн хэлж байна. Нөгөө ажилчдад нэг хувьцаа олгоё, дотоод хяналтыг нь хийдэг нэг арга байдаг даа. Бидний дуурайх дуртай тэр Америк гээд улс оронд бүр ийм хөтөлбөр хийж компанийнхаа засаглалуудыг сайжруулж байсан туршлага байгаа юм байна лээ.

Энэ компани дотор хулгай, буруу зөрүү зүйл байх юм бол чи хувьцааны ногдол ашиг авахгүй. Үр ашиг нь сайжраад хяналтыг нь хамгийн ойрхон тэр компанид ажиллаж байгаа хүмүүс нь хамгийн мэдээлэлд ойрхон учраас засаад залруулаад үр ашиг гарах юм бол чи хувьцааны ногдол ашиг авна гээд 5-аас 10 хувийн хувьцаа ажилчид нь өгөөд. Тэгэхдээ бүр өмчилж авдаггүй. Тэгсэн тэр компанийн үр ашигт байдал, засаглалын асуудал эрс сайжирч байсан тийм сайхан түүх байдаг юм билээ.

Тийм учраас үүнийг би олон жил ярьж байгаа. Үүнийг Б.Цэнгэл дарга ч гэсэн нэг ийм хөтөлбөр хийх гэхээр зорьж байгаа гэж ярьж байсан. Тэгээд энэ юу болов гэдгийг хэлмээр байна.

Одоо энэ хамтарсан засаг байгаа дээрээ ажил хөдөлмөр эрхэлж байсан энэ хэдэн төрийн өмчийн компани, аж ахуйн нэгж, байгууллагыг нуруун дээрээ үүрч явж байгаа хүмүүстээ нэг төр алгаа тэнийлгэхгүй юм уу гэдэг ийм зарчмын асуулт байна.

Дараа нь нэг асуудлыг хэлмээр байна. Одоо ингээд төрийн компаниуд шиг л муу юм байхгүй гээд л яриад байх юм. Манай хувийн компаниуд маань нөгөө нээлттэй болно, нөгөө гэр бүлийн компаниасаа сална гээд байдаг юм маань ер нь юу болж байна вэ?

Эд нар чинь энэ чиглэлээр банкаасаа авхуулаад томоохон компаниудыг нээлттэй болго, ард түмэндээ хувьцаагаа олго, ажилчдадаа өг гээд. Зарим мундаг менежменттэй компаниуд нь ажилчдадаа хувьцаа өгөөд эхэлчихсэн юм билээ л дээ. Нөгөө ажилчнаа тогтоож барихын тулд, засаглалаа сайжруулахын тулд.

Тийм учраас зарим компанийн, хувийн компанийн сонирхолтой этгээдүүд төрийн компанид очиж албаар ашиггүй ажиллуулж байгаад тэгээд тэр компанийн уураг тархи болсон мэргэжлийнх нь хүмүүсийг хөөж явуулж байгаад хувьчилж авах, эсвэл ашиг сонирхлоо хавчуулах гэдэг юм руу. Ийм тохиолдлууд байдаг. Үүнээс хэрхэн сэргийлэх вэ?

Д.Амарбаясгалан: С.Эрдэнэбат гишүүнд 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэбат: Тэгэхээр Н.Учрал сайд ажилчидтай уулзаж санал бодлыг нь авъя гэдэг дээр ярьсан. Бас амжихгүй яваад байгаа. Үүнийг нь авах хэрэгтэй. Салбар салбараар нь.

Бид нарын бодож хараагүй олон нарийн зүйлүүд байдаг. Энэ шилжилтийг хийх нь өөрөө их чухал байгаа. Одоо тухайлбал ашиггүй ажиллалаа. Алдагдалтай байна. Тэгээд танай компанийг өөрчлөн байгуулахгүй болохгүй байна. Менежментийг нь сайжруулмаар байна. Нэгтгэмээр байна. Өөрчилмөөр байна гэдгийг зөвхөн дарга нар хийгээд байвал энэ бүтэхгүй.

Нөгөө төрийн өмчөөс томилогдож очдог нь дандаа л яам, элдэв янзын газраас ирдэг дарга нар л байдаг л даа.

Тийм учраас энэ дээр нь хуульдаа энэ чиглэлийн, тэр ажилчдын төлөөлөл энэ тэрийг оруулах, тэр ТУЗ-д нь хүртэл тавихгүй бол тэгээд хаанаас нь мэдэгдэхгүй. Зарим хараат бус гишүүд чинь хамгийн хараат болчихсон гишүүд очдог тохиолдлууд байгаад байдаг юм.

Тийм учраас энэ зөв юмыг хэдүүлээ зөв хийхэд үр ашигтай байна. Харин буруу тийш нь эргүүлчихвэл магадгүй олны хэл ам, түүхэнд буруу зүйл хийсэн гэдгээр үлдчих болзошгүй учраас санаа зовж хэлж байна.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ “үр ашиг” буюу энэ “ашигт ажиллагаа” гэдгийг зөвхөн мөнгөөр хэмжих өрөөсгөл.

Тэгэхээр тэр үйл ажиллагааны үр ашиг, нийгэмд гүйцэтгэж байгаа үүргүүд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байдлыг үнэлдэг болох ёстой. Түүнээс бүгдээрээ мөнгөн дүнгээр ашигтай ажилла гэж шахдаг их өрөөсгөл ойлголт.

Гэхдээ стратегийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа, юу гэдэг юм зарим салбар мэдээж ашигтай ажиллах ёстой. Гэхдээ зарим улсын төсөвт үйлдвэрийн газар, төсвөөс санхүүжиж байгаа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд бүгдээрээ тийм мөнгөн дүнгээр ашигтай ажиллаж болохгүй шүү дээ.

Тэгэхээр нэг саван дотор хийчхээд бүгдийг нь хоорондоо хэн ашигтай ажилласан бэ гэдгээр нь өрсөлдүүлэх бололцоо байхгүй.

Тийм учраас бид “Эрчис Монгол”-ын дэргэд 4 салбар байна. Энэ 4 салбар нийгэмд үзүүлж байгаа үр ашиг нь ямар байх вэ гэдгийг сайн тооцохгүй бол жишээ нь АЗЗА гээд байгууллага байлаа гэхэд замыг хариуцах ажлыг нь төр хийдэг, замыг арчлах дээр нь хувийн хэвшил аутсорсинг хийгээд явдаг. Гэтэл үүнийг 100 хувь хувь руу шилжүүлчихээр тэр аймаг, орон нутгуудын хоорондын замыг хэн хариуцах вэ гэвэл нөгөө зах зээлийн төвлөрөл багатай учраас ашиггүй учраас төр өөрөө түүнийг авч явахгүй л хувийн хэвшил түүнийг даана гэж байхгүй.

Тэгэхээр үүнийг тодорхой хэмжих ёстой гэж ингэж үзэж байгаа. Тэгээд би үйлдвэрчний эвлэл, С.Эрдэнэбат гишүүнтэй ярилцаад ер нь ирэх долоо хоногоос ийм чөлөөт уулзалтуудыг хийж, санал бодлуудыг нь сонсьё гэж зорьж байгаа.

Дээрээс нь энэ төрийн өмчит компаниудад байгаа 58 мянган албан хаагч бас энэ чинь төрийн л чиг үүргийг хэрэгжүүлж байгаа шүү дээ.

Тэгэхээр бид цаашдаа төрийн албаны реформыг орж ирүүлэх хүрээнд энэ төрийн өмчит компанид ажиллаж байгаа ажилтан, албан хаагч нарын нийгмийн баталгааг ч гэсэн их тодорхой болгоод, нийтийн үйлчилгээний албанд тооцох тал руу явах ёстой гэж үзэж байгаа юм.

Тийм ч учраас төрийн өмчит компаниуд өнөөдөр хуучин ямар байгаа. Одоо ямар байгаа вэ гэхээр “Баялгийн сан”-д 270 тэрбум төгрөг төвлөрүүлсэн ч адилхан цалинтай, алдагдалтай компанид алдагдлаа бууруулаагүй байсан ч адилхан цалинтай.

Гэтэл бүтээмж нь өсөөд байгаа газар урамшуулал өндөр байж болох зөв механизмыг нь ашигт ажиллагаанд суурилсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог нь хийгээд төлөөлөн удирдах зөвлөл нь өөрөө тэр үед шийдээд явдаг энэ тогтолцоо руугаа орж байж энэ төрийн өмчит компаниуд дээр мэдлэг боловсролтой, чадвартай хүмүүс ажилд орох юм билээ.

Тийм учраас төрийн өмчит компаниудынхаа энэ ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад анхаарна. Таны хэлж байгаа тэр хувьцаагаар ямар нэгэн байдлаар өөрт нь ажилчдадаа хувьцаа өгдөг ийм тохиолдлууд хувийн компаниудад байдаг хэдий ч төрийн компаниуд дээр энэ тийм боломжтой зүйл биш. Энэ нийтийн өмч учраас.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт “төрийн өмчийн компани” болон “төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд”-ийг үр

ашигтай ажиллуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх гээд 7, 8 заалт байдаг. Энэ заалтын хүрээнд энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа нь маш зөв зүйтэй гэж бодож байна.

Яагаад гэхээр Монголчуудын нийт иргэдийн хамгийн их хардлага юун дээр байдаг вэ гэхээр ерөөсөө төрийн өмчит хөрөнгө дээр л байдаг. Эндээс хулгай гардаг, эндээс авлига гардаг, эндээс хууль бус төслүүдийг санхүүжүүлдэг. Эндээс зарим нэгнийхээ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Энэ нууц ч болчихсон юм зөндөө байгаа.

Тэгээд төрийн өмчит оролцоотой компаниудын нийт активын хэмжээ

- ▶ 2019 онд **37** их наяд төгрөг байсан.
- ▶ 2023 онд **59** их наяд төгрөг болж өссөн.
- ▶ 2024 оны тайлан танилцуулга дээр **64** их наяд **200** тэрбум төгрөг болж өссөн.

Тэгэхээр энэ нь өөрөө юуг илэрхийлээд байна вэ гэхээр төрийн өмчийн оролцоо жилээс жилд улам данхайж байгааг л илэрхийлж байгаа. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр.

Тэгэхээр үүн дээр хамгийн гол чухал зүйл бол өөрөө засаглалыг ил тод болгох асуудал. Улс төрөөс хамааралтай, улс төрчөөс хамааралтайд томилогддог. Буцаад хариуцлага тооцох гэхээр тооцож чаддаггүй ийм нөхцөл байдал үүсчихсэн.

Нийтдээ сая манай Их Хурлын гишүүд 122 компанийн л асуудлыг яриад байгаа болохоос орон нутгийн болон орон нутгийн өмчтэй буюу аймгуудын оролцоотой нийт “төрийн өмчит компани” чинь 472 ширхэг хуулийн этгээд байна шүү дээ.

Тэгээд энэ хуулийн этгээдүүдийн асуудлыг бас ингээд энд давхар ингээд орхигдуулчихсан байна.

Тэгээд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хороонд хамаарагдаж байгаа энэ 122 компаниас нийтдээ 5-хан нь нийт ашгийнхаа 90 хувийг бүрдүүлж байна. 5-хан компани нийт ашгийнхаа 90 хувийг бүрдүүлж байна.

Энд нөгөө “Эрдэнэс Тавантолгой” компани нийт ашгийг чинь бараг 85 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Тэгэхээр энэ бусад компаниудын засаглалын ил тод байдал, нээлттэй байдлыг бид заавал ярих ёстой. Улс төрөөс хамааралтай байдлыг улам халах ёстой.

Ний нуугүй хэлэхэд “Эрдэнэс Монгол” гэдэг компанийг нэг харья. Байгууллагын захирал нь өөрийнхөө амь насыг **3 тэрбум** төгрөгөөр үнэлээд, **30 сая** төгрөгөөр даатгуулчихсан ийм бодит тохиолдол бас байна шүү дээ.

Тэгэхээр энэ өөрөө Та бидний яриад байгаа ил тод байдалтай зохих юм уу, зохихгүй юм уу гэдэг нэг асуудал байна.

Бас энэ Оюу Толгой компанийн 2024 оны санхүүгийн тайланг “маш нууц” хэлбэрээр зөвхөн Төсвийн байнгын хорооны гишүүдэд тараачихсан байгаа. Энэ дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хороо, Төсвийн байнгын хороо ямар байр суурьтай байгаа юм? Яагаад бусад Улсын Их Хурлын гишүүдэд энэ Оюу Толгой компанийн тайланг танилцуулахгүй, зөвхөн Төсвийн байнгын хорооны гишүүдэд нууцаар хүргүүлж байгаа юм. Энэ асуудалд бид ямар нэгэн тодорхой хариулт авмаар байна.

Мөн гадаад улсын зээл, тусламж, хөтөлбөрөөр хэрэгжүүлж байгаа, өнөөдөр бид баталсан зарим төслүүд байна. Эд нарын санхүүгийн ил тод байдлыг ил тод болгохгүй бол эргээд татвар төлөгчдийн нуруун дээр ирнэ.

Тэгэхээр энэ дээр Та хэд маань ямар байр суурьтай байдаг юм бэ?

“Эрдэнэс Монгол” компанийн нэгдлийн хүрээнд нийтдээ 2023 оны Засгийн газрын 108 дугаар тогтоолоор ашигтай ажилласан 5 компаниасаа менежментийн төлбөр гээд 2 хувь хүртэлх орлого татаад 170 тэрбум төгрөг жишээ нь менежментийн төлбөр гээд авчихсан байна.

Энэ нь ингэж орлогын 2 хувь гээд ийм өндөр тоогоор байх нь зөв юм уу, буруу юм уу? “Эрдэнэс Монгол” компани нэгдлийнхээ хүрээнд бусад компаниуд дахь үйл ажиллагаа зардлаа нэг болгоод явах боломж нь юу байгаа юм бэ гээд ийм асуудлууд дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: “Эрдэнэс Монгол” нэгдэл нөгөө Баялгийн сангийн хууль батлагдсаны дараа реформ нь нэлээн сайн хийгдсэн юм гэж би ойлгож байгаа.

Яагаад гэхээр мэдээллүүдийг нь сонссон. Тэгээд тоогоор ярих хэрэгтэй. “Эрдэнэс Монгол” нэгдэл дээр 42 компани байсныг 31 компани болгож бууруулах ажил бодитойгоор хийгдсэн. Тэр 269 төлөөлөн удирдах зөвлөл 66 болтлоо буурсан. Хараат бус гишүүдийн хувь 30 хувь л байсан. Тэр нь 49 хувь хүртлээ нэмэгдсэн.

Тэгээд яг ийм холдингийн зарчмаар ажиллаад, чиг үүргийн давхардлыг бууруулах ажлууд бодитой хийгдсэний үр дүнд энэ Баялгийн сангийн орлого төвлөрөөд, тэр Баялгийн сан дээр хуримтлал үүсэж байна.

Тэгэхээр цаашдаа баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэхдээ л шат дараатай арга хэмжээ авна. Тэгээд ер нь нууж хаагаад байх зүйл ер нь байхгүй л гэдгийг миний хувьд зүгээр энэ эрхэлж байгаа сайдынх нь хувиар хэлдэг.

Тийм учраас одоо бол Шилэн дансны хуулиар, Нийтийн мэдээллийн хуулиар 50 орчим мэдээлэл ил байгаа юм. Гэхдээ үүнийг “төрийн өмчит компани” төдийлөн хууль биелүүлдэггүй байсан. Тухайн үед нөгөө “Шил” ажиллагаа явуулж байхад нэлээдгүй юм болж байж тавиулж олон нийтэд зарлуулсан.

Сая төсвийн хуулийг дагалдуулаад мэдээллийг ил болгох бас 11 байх, мэдээлэл ил болго гэж шахаад. Одоо энэ хууль гарснаараа 74 мэдээлэл ил болно. 74 мэдээлэл ил болоод зүгээр орхих биш компанийн гүйцэтгэх захирлын гэрээн дээр хэрвээ Та мэдээллийг ил болгоогүй бол ажлаас чөлөөлөх үндэслэл болно гэдгийг тусга гэдгийг хуульчилж өгч байгаа юм.

Дээрээс нь тэр мэдээллийг ил болгохгүй байгаа нь өөрөө шууд чөлөөлөх үндэслэл болно гэдэг өөрөө дэвшил авчирна.

Тийм учраас одоо gov.mn гээд Засгийн газрын албан ёсны веб хуудас дээр <https://soe.gov.mn/> гээд ороод үзвэл төрийн өмчит компанийн ашигт ажиллагааны мэдээллийг бүгдийг нь сая сарын өмнө ил болгосон.

Тэгэхээр энэ бол бас том дэвшил авчирсан байх гэж харж байгаа. Тэгээд энэ хууль гарснаараа маш том өөрчлөлтүүд гарна.

Тэгээд ер нь цаашдаа хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ч гэсэн яг энэ тавигдах шалгуурын дагуу яг тухайн компани дээр авч хэрэгжүүлэх өөрийнх нь төлөвлөгөөг нь сонсоод, тэгээд төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрээ гаргаад, нээлттэй сонгон шалгаруулалт, процесс нь хуулийн дагуу явагдсанаар өөрчлөлт гарна.

Тэгээд бид “Эрдэнэс Тавантолгой” дээр гэхэд л сая хүний нөөц эрхэлсэн захирлыг гадаад салбартаа танигдсан шинэ талант, шинэ ур чадвар, мэдлэгийг Монголд авчиръя гэдэг утгаар нь 20 хүний нөөцийн компанитай хамтарч ажиллах саналаа хүргүүлээд олон улсад нээлттэй зарлаж байгаа юм.

Тэгээд ер нь гадаад хүн хүний нөөцийн захирлаар тавья. Тэгээд янз бүрийн хүн амьтан томилъё гээд байх нь ч багасах юм билээ. Тэгээд хараат бус ажиллах нөхцөлийг нь л бүрдүүлээд шахалт шаардлагаа тавиад л явъя.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Хуулийн төслийн 5.1.4 дээр “монопол эсвэл давамгайл байдлаар урвуулан ашиглахгүй байх” гээд ганц өгүүлбэрээр, өгүүлбэр ч хүрэхгүй зүйлээр монопол байдлыг ерөнхий байдлаар оруулчихсан.

Тэгэхээр цаашид ажлын хэсэг дээр байхад үүнийг сайн анхаарч ажиллахгүй бол төр хэдхэн салбар дээр л монопол байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бусад салбаруудын хувийн хэвшлүүдийн оролцоог яаж нээлттэй болгох юм гэдэг ийм асуудлыг бид бүр бодлогын түвшинд оруулж ирэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа юм.

Тэгэхээр ажлын хэсэг дээр бодвол энэ яаралтайгаар хэлэлцээгүй юм чинь хаврын чуулганаар дахиад хэлэлцэх байх. Ийм хуулийн зарим зарим хэд хэдэн заалтуудыг заавал ярилцах шаардлагууд байгаа.

Мөн Н.Учрал сайд тэр Оюу Толгойн тэр тайланг нууц хэлбэрээр зөвхөн Төсвийн байнгын хороодод яагаад хүргүүлсэн. Бусад гишүүдэд хүргүүлээгүй тухайдаа хариулт өгсөнгүй.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тэр Оюу Толгойтой холбоотой мэдээллийг хэрвээ Их Хурлын гишүүд албан хэрэгцээндээ авъя, мэдээлэл авъя гэвэл шууд албан хүсэлтээ явуулаад авах бололцоотой.

Төсвийн байнгын хорооноос мэдээлэл сонсъё гэдэг хүсэлт шаардлага ирүүлсэн учраас тэр мэдээлэл очсон.

Тэгэхээр Их Хурлын гишүүд, бусад Байнгын хороон дээр ч гэсэн Оюу Толгойн талаарх мэдээллийг хэзээд ч гэсэн хийхэд бэлэн байгаа. Тэгээд Ө.Шижир гишүүн бидэн рүү энэ мэдээллийг авъя гэдэг хүсэлтээ ирүүлбэл албан шугамаар танд хүргүүлбэ.

Д.Амарбаясгалан: Ө.Шижир гишүүн нэмж тодруулж асууя.

Ө.Шижир: Төрийн өмчит компанийн тайлангууд аудитын дүгнэлттэйгээ бүгдээрээ ил байгаа юм. Тэгээд энэ ил байгаа юмнууд дээр л бид, манай энэ ажлын албаны тооцоонуудын тоо бодлого л гаргасан юм л даа. Бусад компаниудыг нэгтгээд.

Тэгээд ганцхан Оюу Толгой нууц гээд Төсвийн байнгын хороонд. Тэгээд нэхээд асуусан. Төсвийн байнгын хороонд байдаг гишүүдээс асуухад тийм хариулт өгсөн байхгүй юу. Тэгээд л үүнийг тодруулаад. Яагаад ганцхан Оюу Толгойн нууцаар аваад зөвхөн Төсвийн байнгын хороонд өгчихсэн. Бусад төрийн өмчит бүх компани, төрийн өмчийн оролцоотой бүх компаниуд тайлан, дүгнэлт нь нээлттэй байгаа. Энэ ялгааг л би асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд нэмж хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Ер нь санхүүгийн ба санхүүгийн бус бүх тайлан, аудитын мэдээлэл ил тод болох нь хуулиараа ийм шаардлага байгаа.

Тийм учраас та ч гэсэн Үндэсний аудитын тайланг ч гэсэн нээлттэй үзэх харах бололцоотой учраас энэ дээр анализ хийж байгаа байх.

Зүгээр Оюу Толгойн хөрөнгө оруулалтын тэр гэрээтэй холбоотой үүсээд байгаа шүүхээр явж байгаа процесстой холбоотойгоор зарим мэдээлэл нь нээлттэй байхгүй байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ Монгол талаас “Эрдэнэс Оюу Толгой” гэдэг компани байгаа шүү дээ. Тэр “Эрдэнэс Оюу Толгой” компанийн хуулиар мэдээллийг ил болгох одоогийн байдлаар 51 төрлийн мэдээлэл ил болгох үүрэг нь “Эрдэнэс Оюу Толгой” компанид хадгалагдаж байгаа.

Тийм учраас мэдээллээ ил болгох л шаардлагатай. Зүгээр тэр шүүхийн маргаантай холбоотой асуудлыг нууцалж байхыг үгүйсгэхгүй.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Энэ хуулийг нэн яаралтай бид хэлэлцэж баталж энэ асуудлаа цэгцлэх асуудал дээр дэмжиж байгаа. Үзэл баримтлалын хүрээнд ч гэсэн дэмжиж байгаа.

Тэгээд ингээд ажлын хэсэг байгуулагдаад энэ дээр гишүүдийн хэлж байгаа санал, дүгнэлтүүдээс засах зүйлээ засаад явна гэж бодож байна.

Ер нь энэ хууль манай улсад нэн яаралтай шийдэх хоёр том асуудлыг гогцоо болж байгаа гэж харж байгаа.

Нэгдүгээрт, авлигын асуудал байна. Улс төрийн санхүүжилтийн асуудал байна.

Тэгээд авлигын асуудал түрүүн гишүүд ч дурдсан л даа. Ер нь одоо төрийн өмчит компаниа цэгцлэхгүй бид авлигын индекс дээрээ сайжруулалт гаргахгүй. Үүнийг бид хүлээн зөвшөөрөөд ийшээгээ орохоос өөр аргагүй.

Яах вэ, Б.Пүрэвдорж гишүүн хэлж байна. Энэ чинь улс төрийн томилгооноос л болдог шүү дээ гээд. Тэгээд яг үнэнийг ний нуугүй хэлэхэд бүх ах нар, улс төрч нар бүгд л хаа нэгэн газар “төрийн өмчийн компани” дээр, “орон нутгийн өмчийн компани” дээр өөрийнхөө хүнийг тавьчихъя, өөрийнхөө хүнийг томилуулчихъя гээд л явдаг.

Тэгэхээр энд сууж байгаа тэр хэлээд байгаа гишүүд маань яг энд камер дээр ярьж байгаа шигээ бас дүр эсгэлгүй байгаасай гэж хүсэж байна.

Хоёр дахь юмны гол гогцоо цаашдаа бид дундаж давхаргаа тэлэх, орлогын эх үүсвэрүүдийг илүү сайжруулах, өрхийн орлогыг сайжруулах тал дээр энэ хууль үр нөлөөгөө үзүүлнэ гэж харж байгаа.

Энэ ямар байдлаар вэ гэхээр яалт ч үгүй бид зах зээлийн өрсөлдөөнд хувийн хэвшлийн зах зээлийг тэлэх шаардлага нэгэнт үүссэн. Бид төрийн оролцоотой зах зээл маш их давамгайлсан, төрийн SPENDING гэж ярьдаг. Зарцуулалт маш их ихэссэн энэ үед үнэхээр хувийн хэвшлийн орон зай боогдсон нь үнэн.

Тэгэхээр үүнийгээ бид чөлөөлөх, либералчилж шударга өрсөлдөөнтэй хувийн хэвшлийн ийм орон зайгаа бид гаргаж өгч байж энэ ажил олгогч нар, баялаг бүтээгч нар өөрсдөө ажлын байрыг бий болгож байж бид “дундаж орлоготой иргэд”-ийнхээ тоог тэлэх бодлогоо илүү сайн үр өгөөжтэй хэрэгжүүлж чадна гэж харж байгаа.

Тэгэхээр яг л энэ зорилгын хүрээнд бид хуулийнхаа үзэл баримтлал, бусад зүйлийг сайн нягталж харж хэлэлцэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Хувийн хэвшилд орон зайг нь гаргаж ирэхтэй холбоотойгоор төрийн өмчит компанийг ийм нөхцөлд бий болгох вэ, төрийн оролцоог багасгана гэдэг энэ зарчмын хувьд нөгөө талдаа бид нарын маш сайн барих ёстой юм бол, төр оролцоогоо татаж байгаа бол энэ гарч байгаа орон зай дээр шударга өрсөлдөөн явагдах зохицуулалт, орчныг маш сайн бий болгох дээр давхар анхаарах ёстой юм.

Тэгэхгүй бол бид нөгөө л 30 гэр бүл нь байдаг юм уу, эсвэл 3-аас 4 тэр томоохон аж ахуйн нэгж нь бүхий л зах зээлийн орон зайг эзлээд, нөгөө шинээр гарч ирж байгаа жижиг болон дунд компаниуд өсөн торних, томрох энэ бололцоог нь бүгдийг нь хаагаад хэтэрхий дахиад зах зээлийн төвлөрөл үүсээд монополиуд үүсдэг.

Тийм ч учраас зарим тохиолдолд энэ төрийн оролцоо байх ёстой. Шударга ёс гэсэн байдлаар сүүлийн жилүүдэд төрд нэлээн их юм нааж ирсэн. Одоо бид үүнийгээ либералчлаад зөвхөн нөгөө талдаа яг аж ахуйн нэгжүүдэд шударга өрсөлдөөнийг бий болгох энэ зохицуулалтаа давхар харж нягталж хийх нь зүйтэй болов уу гэж харж байна.

Хамгийн сүүлийн энэ бол санал. Ер нь сая Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцүүлгийн явцыг харсан. Тэгээд энэ хууль бол нэлээн нийтийн эрх зүйн асуудлуудыг хөндөж байгаа. Дээр нь энд компанийн эрх зүйн асуудал, өмчийн эрх зүйн асуудал, групп компани, холдинг компанийн зохицуулалт гээд засаглалтай холбоотой нэлээн зохицуулалтууд орж ирж байгаа.

Тэгэхээр үүнийг Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороогоор хамтран хэлэлцвэл илүү үр дүнтэй няхуур байх болов уу гэсэн

саналтай байгааг энд уламжилж байна. Хоёр Байнгын хороогоор хамтарсан байдлаар ажлын хэсгийг байгуулж хэлэлцүүлэх саналтай байгаагаа хэлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ер нь энэ Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хуулийг оруулж ирэх их зовлонтой юм билээ.

Маш олон хүний эрх ашгийг хөндөж байгаа юм. Хүмүүс их бухимдаж байгаа. Тэгээд одоо ер нь ийм албан бус нэршил бий болчихсон. Хувийн төрийн өмчит компанитай хүмүүс ч гэсэн их байна л даа. Тэгээд хувийн төрийн өмчит компанитай. Тэр төрийн өмчит компаниараа амьдардаг нөхдүүд энэ хууль дээр янз бүрийн байдлаар эсэргүүцнэ. Тэр бол дамжиггүй.

Тийм учраас энэ хууль дээр маш их өндөр шалгууртай болсон. Юу вэ гэхээр эрх мэдэл их төвлөрөөд нэг газар ингээд овоороод байх тусам тэнд авлига үүснэ. Түүнийг задлахын тулд энэ тэнцвэрийг л хангуулах ёстой байхгүй юу. “Хяналт-тэнцвэр”-ийг.

“Хяналт-тэнцвэр”-ийг хангуулна гэдэг бол төлөөлөн удирдах зөвлөлийн бие даасан байдал л байхгүй юу.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрөө дотоод аудиттай, шаардлагатай бол олон улсын аудит оруулчихдаг, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг нь ойлгомжтой. Тэгээд жил жилээр төлөвлөгөөгөө сунгаад явчихдаг, юугаар ажлыг нь хэмжих вэ гэсэн индикаторуудтай. Тэгээд түүнийг нь батлаад төлөөлөн удирдах зөвлөл нь шийдээд, хэн хэний өмнө ямар хариуцлага хүлээх вэ гэдэг нь ойлгомжтой. Тэгээд тухайн Засгийн газар төрийн өмчит компаниуд дээр баримтлах, үгүй байя гэхэд 2 жилийн төлөвлөгөөтэй. Гэнэтийн сюрпризгүй.

Ингэж явахад хувийнхан ч гэсэн төр яг ямар ямар салбарт орох гээд байгаа юм бэ гэдэг мэдрэмжээ авч байж хувийн компаниуд аль аль бизнесийн салбарт орохоо төлөвлөнө шүү дээ. Тэгэхгүй хувийн компаниуд бизнес төлөвлөгөө гаргаад л ажиллаж байтал гэнэт нэг төр очоод л “хувцсыг чинь би оёно”, “хоолыг чинь би хийнэ” гээд эхлэхээр яаж энэ хувийн хэвшил энд амьдрах юм.

Тэгэхээр бид ерөөсөө л нэг ийм бүдүүлгээр энэ хувийн хэвшлийн бизнес рүү гар дүрж ордог. Тэгээд төртэй хамааралгүй амьдрах тийм бололцоогүй болчихсон. Гол мөнгө нь энэ төрд эргэлдээд байгаа байхгүй юу.

Тэгээд яагаад бүгдээрээ нэг ийм төрийн өмчит компанийг хамгаалдаг болчихсон юм. Яагаад тэр хүн санхүүгийн алдагдлыг 3 жил бууруулаагүй захирал байж яагаад тэр хүн алдагдлаа бууруулъя, ажлаа сайжруулъя,

төлөвлөгөөгөө сайжруулъя, хэл ус суръя гэж бодохын оронд нөгөө дарга руугаа залгаж намайг халах гээд байна гэж гоншигноод байдаг юм.

Тэгэхээр ийм юм ярихаар угаасаа л Н.Учрал дахиад л муу хүн болох л байх л даа. Тийм л юм байгаа юм.

Тэгэхээр би бүлгүүдийн хурал дээр хэлсэн. Яг энэ хуулийг явуулахад салбарт нь эрх ашиг нь хөндөгдөөд байгаа улс төрчид янз бүрийн юм ярина. Хувийн юмаа ярина. Заримыг нь авч үлдье гэж хүснэ. Зарим заалт оруулна. Тэрийг битгий тоогоорой. Энэ хуулийг нь гаргаад өгөөд дараа нь Засгийн газар хуультай. Чамайг томилох боломжгүй ээ. Чиний мэдлэг, ур чадвар хүрэхгүй гээд сууж баймаар байна шүү дээ.

Үгүй болохоор энэ хараат байдал яг үнэндээ үргэлжилсээр л байна.

Тийм учраас хуулиа хатуу бариад улам.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Хэлэлцэх асуудлыг ярилцаж байгаа учраас доторх нарийвчилсан зүйлийг асуухгүй. Гэхдээ давхардаагүй хоёр зүйлийг тодруулъя.

Ялангуяа хуулийн өөрийнх нь гарчиг, агуулга, зорилтыг харахаар хууль тогтоомжийн системчлэлийн асуудал дээр манай хуульчид ямар байр суурьтай байгаа вэ? Компанийн тухай хууль, Төрийн орон нутгийн өмчийн тухай хууль гээд байгаа.

Дахиад орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль гээд нөгөө Төрийн өмчит компанийн хууль, төрийн өмчит компанид тавигдах ёстой, ер нь бүх компанид тавигдах ёстой зарчмын заалт шүү дээ.

Тэгээд үүнийг ингээд бие даасан хууль болгож байгаа нь өөрөө хууль тогтоомжийн системчлэлд маань нийцэж байгаа юу? Яагаад ингэж тусдаа хууль болгох ийм зүйл рүү орчхов оо? Бусад хууль тогтоомж, ялангуяа энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гээд цогц хамтдаа орж ирэх гэхээр ямар асуудал тулгараад байгаа вэ гэдэг дээр яг системчлэл талаас маш тодорхой хариулт өгөөч ээ гэж байгаа юм.

Хоёрдугаарт, бүтээмж, ил тод, засаглалын асуудал гээд яг энэ дотор тавигдаж байгаа шаардлагуудыг харахаар ер нь хувийн өмчит компаниуд гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээгээр зохицуулдаг олон асуудлууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр төрийн өмчийн энэ компаниудыг хариуцаж байгаа газраас нь компанийн захирлуудтай байгуулж байгаа гэрээнүүд дээрээ энэ контрактын

асуудал энэ тэр гээд, аудитын асуудал гээд. Энэ олон асуудлуудаа гэрээгээр зохицуулж болохгүй байгаа мйм асуудлууд байгаа юм уу? Үүнийг ер нь өдий болтол зохицуулах гэж оролдож байсан уу?

Нөгөө форматлалын нэг л гэрээний загвартай. Тэрийгээ л байгуулаад явдаг юм уу, яадаг юм гэдэг ийм асуудал яг дагалдаад урган гарч байна.

Хамгийн сүүлд гуравдугаарт орон нутгийн өмчит компани. Би орон нутаг руу эрх мэдэл тарах ёстой гэж боддог. Тэр дээр илүү байр суурьтай байдаг. Ялангуяа орон нутгийн иргэд өөрсдийнхөө нутаг дэвсгэр дээр байгаа, ялангүй уул уурхай, ашигт малтмалтай холбоотой өгөөжийн үр шимийг хүртэх тэр механизм ажиллах ёстой гэж харж байгаа.

Энэ хуулиар улам хязгаарлагдмал болох гээд байна. Дахиад л төвлөрсөн шинжтэй орж ирж байна. Орон нутгийн удирдлагууд тэнд амьдарч байгаа мянга мянган иргэдийн асуудлыг орон нутгийн талаас нь та нар юу гэж харж хууль тогтоомж дээр тусгаж байгаа вэ? Тэгэхдээ хууль дээр байгаа заалтуудыг харахаар орон нутаг зөвхөн тодорхой чиг үүрэг хэрэгжүүлэхээр маш хязгаарлагдмал байгаад байна л даа.

Тэгэхээр энэ асуудал дээр орон нутагт ямар байр суурьтай байгаа вэ гэсэн ийм гурван асуулт байна.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хууль төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль тогтоомж бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн хууль гэсэн эдгээр хууль тогтоомжууд тогтоомжуудаас бүрдэж байгаа.

Тэгэхээр энэ их онцлог харилцаа. Тэгээд энэ юу вэ гэхээр төр өөрөө хувьцаа эзэмшигч учраас төрийн өмч нийтийн өмч, ард түмний өмч учраас энэ нэг талаасаа нийтийн өмч гэдгээрээ энэ бол захиргааны эрх зүйн ойлголт.

Дээрээс нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж байгаа гэдэг утгаараа мэдээж энэ өөрөө хувийн эрх зүйн асуудал хамт орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энэ хууль батлагдан гарахын ач холбогдол нь юу вэ гэхээр ерөөсөө захиргааны эрх зүй, иргэний эрх зүй хоёрын харилцан хамтын асуудал учраас хамтад нь оруулж ирж байгаа.

Дангаар нь зохицуулаад, эсвэл Компанийн хуульд шууд шингээгээд явах гэхээр нэг талаасаа хувьцаа эзэмшигч нь өөрөө төр байгаад байдаг. Ард түмэн өмчийн эзэн байгаад байдаг.

Тэгэхээр шууд иргэний эрх зүйн ойлголт юм, Компанийн хуулиар зохицуулья гээд явж шууд болохгүй.

Чуулганы завсарлагаанаар бид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай ерөнхий хуулийг өргөн мэдүүлнэ. Нэг ёсондоо өмчийн бүртгэл, өмчийн асуудлыг ерөнхий хуулиар зохицуулах буюу өмчийн харилцааны суурь ерөнхий хуулийг оруулж ирнэ гэж зорьж байгаа.

Мэдээж цаашдаа энэ өмчлөгчийн эрх нь Засгийн газарт, эсвэл төрд байгаа гэдэг утгаараа цаашдынх нь үйл ажиллагаа, компанийн нийтлэг харилцаанд төдийлөн шууд нөлөөлөөд байхгүй. Компанийнхаа хуулийг бариад явна. Компанийнхаа хуулийг. Дан компанийн хуулиар болох боломжгүй байсан.

Тийм учраас бичилтийг ингэж хийсэн. “Бүтээмж” гэдэг агуулга дотор ерөөсөө л нөөцийг хуваарилах ойлголт. Тэгээд “үр ашгийг нэмэгдүүлэх”. Тэр утгаараа бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ил тод байдал, хариуцлага, хараат бус байх, засаглал гээд эдгээр агуулгын өөрчлөлтүүдийг хийснээрээ “бүтээмж нэмэгдэнэ” л гэж зорьж байгаа юм.

Тийм учраас энэ бол хууль бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа.

Тэгээд би түрүүн хэлсэн. Хэрвээ энэ хууль үүргээ биелүүлж дууссан тохиолдолд, үнэхээр зах зээлийг чөлөөлж, төр бүхий л бизнесийн салбарт оролцохоо больсон цагт энэ хууль шаардлагагүй болох өдөр бас нэг өдөр ирж болох байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Гүйцээж хариулья. Н.Учрал сайд.

Н.Учрал: Энэ хуулиар “төрийн өмчит компани”, “орон нутгийн өмчит компани” гэдэг хоёр статус бий болно гэсэн үг.

Орон нутгийн өмчит компанийг нутгийн өөрөө удирдах байгууллага шийдвэрлээд явна. Орон нутгийн өмчит компаниуд дээр мэдээж компанийн үйл ажиллагаа, нийтлэг харилцаан дээр компанийн хуулиа барих хэдий ч энэ төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хуульд заагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн шалгуур, гүйцэтгэх захирлын шалгуур, шаардлага, хараат бус байх зарчим, хяналт-тэнцвэр гээд шаардлагууд давхар баригдана. Энэ шаардлагуудыг нийцүүлнэ.

5 үндсэн чиглэл буюу тэр ямар ямар чиглэлээр орон нутгийн өмчит компани байгуулахыг хуульчилж өгч байгаа. Энэ хүрээндээ л байгуулна гэсэн үг.

Түрүүн Байнгын хороон дээр гишүүдээс жишээ нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн зарим компаниудыг тухайлан авч

үзэх ёстой гэдэг ийм байр суурийг илэрхийлсэн. Их Хурлын ажлын хэсэг дээр үүнийг ярилцаад шийдээд явж болох байх гэж ойлгож байна.

Д.Амарбаясгалан: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн алга. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах энэ хуулийн шинэтгэлийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа.

Сүүлийн 8 жил хоёр парламент дамжиж яригдсан. Одоо яг гурав дахь парламент руугаа дамжиж яригдаж байгаа ийм том шинэчлэл байгаа.

Энэ дангаараа мэдээж яг өргөн баригдсан хэлбэрээрээ цаашдаа энэ гишүүдийн ярьж байгаа саналыг тусгаад боловсронгуй болгоод Их Хурал дээр ажиллах байх. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай цуг ярихгүйгээр энэ дангаараа шинэчлэл болохгүй.

Тэгэхээр өмчийн хуулийг яаралтай Засгийн газар оруулж ирээд Улсын Их Хурал дээр өмчийн хууль, компанийн хуулийг цуг нэг ажлын хэсгийн хүрээнд авч явбал зүгээр байх гэсэн ийм саналтай байгаа.

Ингэхдээ би даруухан биш байж магадгүй. Амбицаа шууд ил хэлж байгаа. Энэ хуулийн шинэчлэлийн ажлын хэсгийг би ахалъя. Их Хурал дээр.

Би Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд байхад 2016 онд анх Засгийн газар дээр энэ хуулийн суурь онолын судалгааг хийх ажлыг эхлүүлж байсан.

Сүүлийн 8 жил Их Хурал дээр өмнөх парламент дээр ажлын хэсгийг нь мөн ахалж ажиллаж байсан. Холбогдох судалгаа юмнуудыг бүгдийг нь хийсэн. Холбогдох хуулийн төслүүдийг хийж байсан. 2 удаагийн сонсгол хийгдэж, энэ төрийн өмчит компаниудад яаж хулгай, авлига хийдэг юм бэ гэдгийг мэдэж, илүү сайн таньж авсан.

Тийм учраас энэ нүх сүвийг яаж бөглөх вэ гэдэг гарц, шийдлийг илүү сайн хийж чадна гэж бодож байна.

Хоёрдугаарт, надад төрийн өмчит компаниуд дээр ямар нэгэн сонирхол байхгүй. Миний ахтай, хамаатан саднаас нэг ч хүн төрийн өмчит компаниудад ажилладаггүй. Мөн энд ямар нэгэн бизнесийн хэлцэл хийж байсан намтар түүх байхгүй бөгөөд сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэдгийгээ хэлж байна.

Тийм учраас энэ реформыг улс төрийн хүрээнд, шийдлийн хүрээнд, онолын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр улс төрийн парламент суудалтай намуудын зөвшилцлийг хангаж, манлайлж ажиллая гэсэн ийм санал бодолтой байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Гишүүд ажлын хэсэгт орж ажиллах санал хүсэлтүүдээ ирүүлэх нь зөв байх.

Яах вэ, гишүүдийн санал ганц Байнгын хорооны хүрээнд биш ер нь нийт Байнгын хороодын хүрээнд энэ асуудал ярих нь зүйтэй байх гэдэг санал гарч байгаа.

Тэгэхээр Их Хурлаас өргөн хүрээний ажлын хэсгийг байгуулаад хэлэлцэх нь зөв байх. Мэдээж энэ чуулганы завсарлагааны цаг хугацааг ашиглая гэсэн зорилготойгоор өнөөдөр намрын чуулганы төгсгөл дээр энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг оруулж ирж хэлэлцүүлж байгаа.

Тэгэхээр үүнийг маргаашдаа багтаад энэ чуулган завсарлах цаг хугацаанаас өмнө ажлын хэсгүүдийг байгуулж ажилд нь оруулах чиглэл дээр анхаарал хандуулах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд гишүүд намын бүлгүүдээр дамжуулж нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүд ч гэсэн өөрсдийн шугамаар санал, хүсэлтээ ирүүлээд энэ төсөл дээр ажиллаж болно гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн. Алга байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн. Алга байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Мэдээж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гэж байна, Компанийн тухай хууль байна, Хэмнэлтийн тухай хууль байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль байна. Саяхан Засгийн газар тогтоол гаргаад төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг яаж үр ашигтай ажиллуулах вэ, бас зохион байгуулалтын өөрчлөлт хийх арга хэмжээнүүдийг авсан байгаа.

Тэгэхээр энэ олон хуулиуд дотор угаасаа байгаа зохицуулалтыг заавал тусад нь гаргаж ирээд, тэгээд түүнийх нь нэр нь ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай ийм агуулгатай. Энэ байгаа хуулиудаа хэрэгжүүлээд ил тод, засаглалыг сайжруулах үүрэг нь Засгийн газарт угаасаа байгаа шүү дээ. Тэгээд тэр дагуу ажлаа хийгээд явж байгаа гэж хараад байгаа юм. Сүүлийн өдрүүдэд их мэдэгдэл яваад байгаа.

Тэгэхээр миний харахын энэ материалтай ч танилцлаа, хуульчидтай ч зөвлөлөө. Давхардсан олон ижил төстэй хуулиуд байх тусмаа хэрэгжилт дээрээ тойрч будилдаг, хоорондоо санаа оноо зөрдөг.

Тэгэхээр ерөөсөө энэ хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн саналтай байна. Тэгээд асуулт давхардсан учраас асуултаа болилоо. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Асуултууд ер нь маш их давхацчихлаа. Тэгээд одоо асуулт алга. Харин үг хэлмээр байна.

Н.Учрал сайдад, бас ажлын хэсэгт хэлье. Энэ хариуцлагын асуудал дээрээ та хэд маань хамгийн сайн анхаараад өгөөрэй.

Нэгэнт төрийн өмчийн компаниудыг татан буулгах ямар нэгэн шийдвэр гарсны дараа өмнө нь яагаад ашигтай биш ашиггүй ажиллуулсан юм. Яагаад тэр алдаа байсаар байтал тэрийг 3 жил нуун дарагдуулсан юм. Тэр удирдлагуудад авах арга хэмжээн дээрээ яг хатуу байж өгөөрэй. Тэгэхгүй бол одоо энэ хууль тогтоомжийг дахиж гаргаж өөрчилж байгаагийн хэрэг ерөөсөө гарахгүй.

Зайлшгүй арга хэмжээ авагдах хүмүүс дээр нь арга хэмжээ авч тэр төрийн өмч өөрөө эзэнтэй гэдгийг нь ойлгуулахгүй бол төр өөрөө өнөөдөр үнэгүйдчихээд байгаа, төр өөрөө өнөөдөр эзэн биегүй болчихоод байгаа учраас төрийн өмчит компанийн захирлуудын гаргаж байгаа алдаанууд энэ дээр байгаа.

Тийм болохоор хариуцлага энэ удаа заавал ингэж, өнгөрсөн тэр алдаатай, ашиггүй ажилласан компаниуд дээр удирдлагуудад нь хариуцлагын арга хэмжээг заавал аваарай, заавал тооцоорой гэдгийг л. Энэ нь дараа дараагийнхаа юманд хэрэгтэй. Нэг хүнээ муу үзэх гээд байгаадаа биш шүү дээ. Энэ чинь ашиггүй ажиллавал ингэж болдог юм гэдэг. Төр өөрөө хатуу шүү. Төр төмөр нүүртэй шүү гэдгийг нь харуулж байхгүй бол болохгүй ийм асуудлууд байгаа шүү.

Ингээд Та нарт амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Бид төр мөн орон нутаг өмчөө яаж удирдах вэ, төрийн болон орон нутгийн өмчит компаниуд цаашдаа ил тод, ашиг сонирхлын зөрчилгүй шийдвэр гаргах чадамжтай байх уу гэдэг асуудлыг зохицуулах асуудлыг улам боловсронгуй болгохоор хуулийн төсөл өргөн бариад хэлэлцэж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр хувийн хэвшил хийх боломжгүй, бас ашиггүй, төрөөс үзүүлэх зайлшгүй шаардлагатай үйлчилгээ буюу нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг байгуулах нь зөв гэдгийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлье.

Асуулт. Орон нутгийн өмчит компани гэж орон нутаг хувьцааг нь эзэмшиж байгаа, эсвэл хяналтын багцыг нь эзэмшиж байгаа хуулийн этгээдийг гэж хуулийн 4.1.2 дээр заасан байна.

Тэгэхээр хяналтын багцыг нь эзэмшиж байгаа компаниуд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага буюу нутгийн өөрөө удирдах ёс иргэдийн Хуралд их нөлөөлөх гээд байдаг л даа. Энэ чиглэлийн тэр зохицуулалтыг яаж хийсэн бэ гэж.

Өөрөөр хэлбэл би хувь хүнийхээ хувьд жижиг Тавантолгойг аягүй дэмждэг байхгүй юу. Орон нутаг болгон нэг ийм жижиг Тавантолгойтой, уул уурхайгаа зөв ашигладаг байгаасай, иргэд нь зөв ашигладаг байгаасай гэж боддог.

Гэхдээ хяналтын багц эзэмшдэг компаниуд нэлээн орон нутгийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад нөлөөлөх гээд байдаг. Энэ асуулт нэг нь.

Хоёр дахь асуулт нь, энэ хуультай хэлэлцэж байгаагүй ч гэсэн яг энэ асуудалтай холбоотой. Бидний 20-иод гишүүн 12 сарын 16-нд Ганцмод-Гашуунсухайтын төмөр замын хил холболттой танилцах гээд явсан юм. Тэгээд тэр үеэр энэ Б.Цэнгэл даргатай холбоотой. Тавантолгой төмөр замын үйл ажиллагаатай танилцсан.

Дараа нь Өвөр Монголын Бугат орж тэр Баушин төмөр замтай танилцсан юм. “Тавантолгой төмөр зам” нийтдээ 267 километр урттай жижигхэн төмөр зам. 883 ажилчин ажиллаж байгаа юм. Тэр ачиж буулгах талбайгаа 300 гаруй тэрбумаар засаж тохижуулсан гэсэн мөртлөө өдөрт 5-хан вагон ачиж байгаа байхгүй юу.

Тэгээд төмөр замын нүүрс тээвэр нь нөгөө машин тээврээсээ үнэтэй болчихсон. Гэтэл хил даваад Өвөр Монголын Баушин төмөр замтай танилцахад 4 мянган километр урт төмөр зам дээр 700 гаруй ажилчинтай, жилийн ачаа эргэлт нь 300 гаруй сая тонн байгаа юм. Манай “Тавантолгой төмөр зам” 2 сая гаруйхан тонн.

Тэгээд ингээд харьцуулаад үзэхээр төрийн өмч, бүтээмж. Адилхан л хоёулаа “төрийн өмчит компани”. Ялгаатай нь Хятад, Монголын л компаниуд байхгүй юу.

Тэгэхээр ер нь цаашдаа “Монголын төмөр зам” чинь 670 гаруй километр л зам юм билээ шүү дээ “Монголын төмөр зам”, “Тавантолгой төмөр зам”-аа нэгтгэх чиглэлээр бодлого явж байгаа юу? Энэ нэг жоохон төмөр зам дээр чинь үндсэндээ 1400, 1500 хүн ажиллаж байна. Бүтээмжийн тухай асуудал ярьж байгаа учраас би нэг асууж байгаа юм. Ер нь төрийн бодлого ямар байгаа юм?

“Монголын төмөр зам” гэхэд нэг ачаа эргэлт нь сая би сайтыг нь үзэж байлаа. 3 сая тонн л юм байна шүү дээ. Энэ хоёрын жилийнх нь ачаа эргэлт нийлээд дөнгөж 5-хан сая тонн. Тэгсэн мөртлөө ийм их олон хүмүүс ажилладаг.

Тэгээд тэр Тавантолгой төмөр замын чинь бараг 50-иас дээш хувь нь Улаанбаатар хотоос очиж ажилласан нэр зүүдэг. Тэгээд ямар ч бүтээмж байхгүй. Иймэрхүү маягаар төрийн өмчит компаниуд яваад байх уу гэдэг асуулт байна. Тэгээд хариултаа авч байгаад тодруулах эсэхээ шийдье.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Орон нутгийн өмчит компанийг аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно гэдэг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль бий.

Тэгэхээр энэ хуулийнхаа хүрээнд төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуульд заасны дагуу нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээ явуулах зорилгоор орон нутгийн өмчит компани байгуулж болно л гэдэг ийм заалтыг оруулж өгсөн.

Зүгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа, уул уурхайн чиглэлээр салбарын үйл ажиллагаа явуулж байгаа нэг хэд хэдэн компани байна л даа.

Тэгэхээр энэ байгууллагуудын статусыг хэрхэн авч үзэх вэ. Дээрээс нь Баялгийн сангийнхаа хуультай хэрхэн нийцүүлэх вэ гэдэг энэ хуулийн хэлэлцүүлгийн нэлээн том сэдэв болох байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ асуудал дээр Их Хурал ажлын хэсгийнхээ хүрээнд ярилцах ёстой. Тэгээд би гишүүний саналыг яг нөхцөл байдлыг ойлгож байна л даа. Үнэхээр нэг тийм алдагдалтай ажиллаад байдаг. Тэгээд яг тухайн салбарын онцлог болоод тэр хувийн хэвшил бусад тухайн адилхан үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн бүтээмжтэй ижил түвшний бүтээмжийг бий болгох боломжтой мөртлөө үргэлж л бүтэц нь томроод байдаг, данхайгаад байдаг, ашиг орлого нь нэмэгддэггүй ийм компаниуд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг нэгтгэх, нийлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлуудыг авч хэрэгжүүлж байгаа юм. Жишээ нь, сая тэр 20 АЗЗА нэгдсэнээр дэвшил гарч байна уу гэвэл гарч байна. 2 төмөр зам нэгтгэх асуудлаар тэр “Монголын төмөр зам”, “Тавантолгой төмөр зам” нэгтгэх асуудлаар одоо яг судалгаанууд хийгдэж байна. Гэхдээ зүгээр нэгтгээд зогсохдоо биш тоогоор хэмжиж сурах хэрэгтэй. Яг бүтээмж хэдэн хувиар нэмэгдсэн юм бэ. Яг орон тоо хэдээр цомхотгогдсон юм бэ гэдэг. Түүнээс биш зүгээр нэг ийм механик засварууд хийгээд ямар нэгэн үр дүнд хүрэхгүй.

Тэгэхээр энэ бодлого явж байгаа. 122 компани Төрийн өмчийн хороон дээр тайлан ирүүлж байгаа болохоос биш энд орон нутгийн өмчит компанийг тооцоогүй. Орон нутгийн өмчит компани сүүлийн байдлаар энэ чинь бараг 400 гарчихсан юм байна. 400 гарчихсан. Тэгээд энэ чинь улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот газрууд чинь нийлэхээрээ 1270 руу хүрчээд байна шүү дээ. Энэ чинь замбараагүй тоо байхгүй юу.

Тэгэхээр үүнийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлэх ёстой. Тэгээд энэ ажлууд хийгдээд явж байгаа. Их Хурал ажлын хэсэг гаргасны дараа Та бүхэнд хэлсэн. Энэ бодлого шийдвэрүүдийг маань илүү хамгаалж, авч гарахын төлөө хичээхгүй бол хувийн төрийн өмчтэй хүмүүс өөрийнхөө асуудлыг яриад янз бүрээр улс төржүүлжүүлэх эрсдэл байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 дугаар микрофон. Болдын Цэнгэл дарга хариулт өгье.

Б.Цэнгэл: Г.Ганбаатар гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Үнэхээр таны хэлж байгаатай санал нэг байгаа. Тэгээд Зам, тээврийн хөгжлийн сайдтай нэг асуудал дээр үндсэндээ шийдлээ гаргачихсан байж байгаа.

“Тавантолгой төмөр зам” компанийг “Монголын төмөр зам” компанитай нийлүүлэх гэж байгаа. Өөрөөр хэлбэл “Тавантолгой төмөр зам”-ыг татан буулгаад “Монголын төмөр зам” компанитай нийлүүлнэ.

Одоо хил холболтын яг үүнийг хийх гэж байгаа компани нь зөвхөн төслийн тусгай зориулалтын ийм жижиг компани болоод, тэр эстакадан гүүрээ хийж дуусаад тэр компани татан буугдах ёстой.

Ер нь Төрөөс төмөр замын талаар баримтлах 2010 онд Их Хурал баталсан бодлогыг хэрэгжилт их олон компани дээр очоод яг үнэндээ компани болгон өөрсдөө тарифаа батлаад, компани болгон тээврээ хийж явна гэдэг ийм буруу жишиг рүү орчихсон байж байгаа.

Тийм учраас төмөр замын компаниуд дээр хийх Засгийн газрын компаниудыг татан буулгах, нэгтгэх энэ хөтөлбөрт төмөр замын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд хуулийг оруулж ирж байгаад агуулгаар нь дэмжиж байгаа. Одоо яригдаад байгаа төрийн өмчийн 122 аж ахуйн нэгж байна. 4.8 их наяд төгрөгийн орлого хийж байна.

Гэхдээ ашиггүй ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүд нь бас байна. Нөгөө талдаа төр бизнес хийх шаардлагагүй. Хийдэг хийдэг юмаа хийгээд явъя гэдэг ийм байдлаар явж байгаа.

Тэгэхээр энэ бодит байдал дээр одоо байгаа эрх зүйн орчин нь өөрөө нөлөөлөхгүй байгаа учраас, одоо байгаа эрх зүйн орчны үр дүн нь өөрсдөө энэ төрийн өмчтэй энэ аж ахуйн нэгжүүд байгаа учраас энэ байдлыг өөрчилье, үүнийг шинэчилье гэж оруулж ирж байгаа зорилгыг нь дэмжиж байгаа.

Тийм ч учраас энэ утгаар нь хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ хуулийн төсөл дотор орж ирсэн гол санаа байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр төр ерөөсөө 5 чиглэлээр үйл ажиллагаа явуулъя. Энэ 5 чиглэлээр нь аж ахуйн нэгжтэй оролцоотой өмч эзэмшдэг, үйл ажиллагаа явуулахад нь тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байя гэсэн энэ санааг нь бас дэмжээд байгаа юм.

Энэ яг энэ хуулийн маань гол амин сүнс болох юм болов уу. Нэг дэх амин сүнс болох юм болов уу гэж харж байна. Гэхдээ бас асуудал байна.

Тэр нь юу вэ гэхээр зөвхөн өнгөрсөн жил гэхэд 150 тэрбум төгрөгийн алдагдалтай 43 компани байсан гэж байгаа. Энэ хуультайгаа зэрэгцүүлээд зарим шаардлагагүй хувийн аж ахуйн нэгжүүд, иргэд маань зүгээр аваад явчих боломжтой, хийгээд явчих боломжтой аж ахуйн нэгжүүдийг хувьчлах бодлогоо боловсруулаад оруулаад ирж болохгүй байсан юм уу гэдэг нэг асуулт байгаа юм. Зэрэгцүүлээд ороод ирж болохгүй байсан юм уу. Нэг мөсөн сайхан ачаанаасаа салаад, нэг мөсөн зохицуулчихсан дээр байсан юм биш үү.

Хэрвээ энэ асуудлыг шийдээд дагуулаад оруулаад ирчихсэн байсан бол энэ хууль бүр хоёр дахь амин сүнс нь болох байлаа гэж харж байгаа юм. Н.Учрал дарга аа.

Гуравдугаарт нь, ер нь аж ахуйн нэгжүүд, ялангуяа төрийн өмчийн оролцоотой төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд дээр улс төрчдийн нөлөө их байдаг, шахаа байдаг, авлига байдаг гэдэг энэ танхимд бүгд л ярьж байна. Бүгдээрээ л ярьж байна. Тийм ээ.

Тийм учраас хараат бус байлгах ёстой, элдэв янзын асуудлаас хол байлгах ёстой гэдэг дээр бүгдээрээ санал нэгдэж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг оруулж ирэхдээ энэ 5 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг, энэ 9 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилохдоо хараат бус гишүүдийг нь олонх байхаар томьёолж болоогүй юм уу.

Хэрэв тэгж чадсан бол энэ аж ахуйн нэгжүүд маань өөрөө бие даасан шийдвэр гаргадаг, биеэ даасан элдэв улс төрийн нөлөөллөөс хол байдаг, энэ

яриад байгаа, бид нарын зориод байгаа энэ зүйл маань биелэх байсан юм биш үү. Гурав дахь амин сүнс нь гэсэн ийм хоёр асуулт байна.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хуулийг дагуулаад хувьчлах, нээлттэй болгох, өөрчлөн зохион байгуулахыг хамтад нь оруулж ирэх нь өөрөө л бас нөгөө өнгөрсөн парламентын гоё лоозон шиг л болно л доо.

Тухайн үед нэг ийм компаниудын жагсаалт баталчихсан юм. Хаанаас ч оруулж ирсэн юм. Тэгээд жагсаалтууд оруулж ирээд Их Хурлаар баталчихсан. Тэгээд яах гэж байгаа юм гэсэн. Нээлттэй болгож байгаа.

Тэгээд нээлттэй болгож байгаа компаниуд дээр нь очсон чинь огт үнэлгээ хийгдээгүй. Аудит ороогүй. Тэр байтугай нөгөө UNDERWRITER авах төлбөр, мөнгө төгрөг ч байхгүй.

Тэгээд одоо яах юм гэсэн чинь харин үнэлгээ хийгдээгүй гээд сууж байгаа юм. Тэгээд яасан. Их Хурлын тогтоол гарчихсан гээд.

Тэгээд бид ер нь асуудалд нэг баримжаагаар ханддаг зантай болчихсон юм билээ. Нэг өглөө сэргэхээр нэг юм сэтгэдэг юм шиг. Тэгээд очихоор хана мөргөчихдөг.

Тэгэхээр тэр OECD-гийн энэ үндсэн зарчим, ерөөсөө бизнесийн салбар өдөр ирэх тусам өөрчлөгдөж байна. Ялангуяа технологи бол бизнесийн орчныг өөрчилж байна. Шинэ төрлийн бизнесүүд нэмэгдэж байна.

Тэгэхээр бизнесийн шинэ орчин өсөн нэмэгдэж байх үед хуулиар тэр бизнесийн салбаруудыг шууд хуульчлах бололцоогүй.

Тийм учраас Засгийн газар байгуулагдлаа. Засгийн газар энэ хуулийн дагуу манай Засгийн газар төрийн өмчит компаниуд дээр ямар бодлого баримтлах юм бэ, аль салбар луу илүү фокуслах юм бэ гэдгээ. Жишээ нь, нийтийн үйлчилгээний зориулалтаар гэвэл сургууль, цэцэрлэг, боловсрол руу анхаарна ч гэдэг юм уу. Ингэж оруулж ирэхдээ давхардуулаад төлбөр. Тэр чинь санхүү, мөнгөний асуудал яригдах учраас энэ энэ компанийг нээлттэй болгоё. Ингэснээрээ хөрөнгө мөнгө төвлөрүүлнэ гэдгээ оруулаад. Тэгээд хувьчлах, өөрчлөх, зохион байгуулах энэ ажлуудаа хамтатгаад оруулж ирж байх нь зохимжтой гэдэг утгаараа хууль батлагдсаны дараа баримтлах үндсэн чиглэлийг нээлттэй болгох, өөрчлөн зохион байгуулах компаниудын хамтдаа оруулж ирнэ. Тэгээд шийдвэрлэе.

Ер нь хуулийн дараа шууд оруулж ирнэ. Ерөөсөө цаг алдахгүй. Та бүхэнд хариуцлагатай хэлэхэд ер нь долоо хоногийн дараа оруулж ирнэ. Яагаад гэхээр

одоо бэлтгэл ажлыг хангаж байгаа. Бэлтгэл. EBRD бол 8 жил хугацаа хийж, төсөл чинь бичигдсэн юм билээ.

Тэгэхээр энэ дээр хангалттай туршлага, мэдээж энэ ажлын хэсэг хуримтлуулж байгаа. Энэ дээрээ бид оруулаад явчихъя гэж хэлмээр байна.

Тэр хараат бус дээр нэг зүйл хэлчихье. Хараат бус дээр бүр ингэсэн юм. Төрийн төлөөлөл чинь 3-аас дээшгүй байхгүй юу. Дээд тал. Босго нь. Хараат бус чинь хамгийн багадаа гуравны нэгээс доошгүй байхгүй юу.

Тэгэхээр 6 байна уу, 7 байна уу. Тэр хараат бус чөлөөтэй тавьсан юм. Төрийг нь ингээд дээд босгыг нь тавьчихсан юм. Гэхдээ нэг онцлог нь юу гэхээр төр ч бай, хараат бус ч бай бүгдийг нь нээлттэй сонгон шалгаруулалтаар оруулна. Төрийг шууд томилохгүй.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Баярлалаа.

Тэгэхээр хууль хэрвээ батлагдаад хүчин төгөлдөр болбол долоо хоногийн дотор Засгийн газар дээр орж ирж байгаа, харьяалагдаж байгаа, мөн орон нутагт харьяалагдаж байгаа ашиггүй ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг тун яаралтай оруулж ирж хувьчлах, нээлттэй болгох ийм бодлого баримтална гэдгээ албан ёсоор хэлж байна. Баярлалаа. Н.Учрал сайдад.

Тодруулах асуудал нь юу вэ гэхээр гуравны нэг нь төрийн албан хаагч байж болно. Гуравны нэг хүртэл хувь нь төрийн албан хаагч байж болно. Үлдсэнийг нь хувьцаа эзэмшигч шийднэ гэхчхэн байгаа учраас би төр хувьцаа эзэмшигч учраас төрийн албан хаагчтайгаа нийлээд хувьцаа эзэмшигч гээд өнөө л байдгаараа нөгөө төр, Засгийн газар, орон нутаг нь олонхоороо явчих юм биш үү гэдэг байдлаар нь хараат бус гишүүдийг олонхыг нь болгооч ээ гэж асуусан юм. Олонх нь болгох боломжтой юу гэж асуусан юм. Энэ дээр та нэг ахиад нэг. Би буруу ойлгочихсон байгаад байна уу? Яагаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд тодруулж хариулъя.

Н.Учрал: Болдог бол одоо хараат бус гишүүд бүр олон баймаар байна. Ер нь бол.

Одоо Их Хурал ажлын хэсгээ байгуулж байгаа учраас ямар ч байсан Засгийн газраас өргөн мэдүүлэхдээ одоо нөгөө төлөөлөн удирдах зөвлөлийн гуравны нэгээс багагүй нь хараат бус байна гээд хамгийн доодхыг нь тавьчихсан юм.

Тэгэхээр энэ нь цаашаа 5 байна уу, 7 байна уу, 9 байна уу, 11 байна уу, тэгээд л Их Хурал шийдэх л ёстой. Тэгэхгүй бол энэ чинь бас их зовлонтой юм

байна шүү дээ. Түрүүн манай зарим гишүүн болохоор төр их олон байх ёстой. Яахаараа хараат бус нь ийм олон байдаг юм бэ гээд бухимдаад байна шүү дээ.

Тэгэхээр орон нутгийн өмчит компани дээр татан буулгах, нэгтгэх тэр ажлуудыг Их Хурал шийдэхгүй шүү дээ. Орон нутгийн өмч бол нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшиндээ шийднэ. Бид бол зөвхөн хуулийн хүрээнд шийднэ. Зүгээр төрийн өмчит компаниудаар баримтлах чиглэлээ оруулж ирээд тэр ажлыг Их Хурал дээрээ зөвхөн төрийн өмчит компанийн түвшинд ярина. Орон нутгийн өмч орон нутагтаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Далай Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Баярлалаа. Тэгээд түрүүн Б.Энхбаяр гишүүн хэлж байсан.

Энэ маш чухал ач холбогдолтой хууль. Энэ хуулиар хэлэлцэгдэх гэж байгаа, шийдэх гэж байгаа асуудал маань өөрөө танил байгаа учраас мөн энэ ажлын хэсэгт ороод Б.Энхбаяр даргатай, Н.Учрал даргатай хамтраад ажиллаад явах боломжтой гэдэг саналаа албан ёсоор хэлчихье.

Д.Амарбаясгалан: Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Төрийн зохицуулах чиг үүрэг болон өмчлөгчийн чиг үүргийг салангид хэрэгжүүлэхээр энэ хуулийн төслийг боловсруулсныг дэмжиж байна.

Тэгэхээр төр бол нэг гараараа эдийн засгийг зохицуулж байгаа мэтээр хувийн хэвшлийн хийх боломжтой зүйлсэд оролцож байгаа нь өнөөдрийн зах зээлийн нийгэмд энэ боломжгүй зүйл гэж би хардаг юм. Тэгээд яг ямар байдлаар төр энэ зохицуулалтыг хийж байгаа вэ гэдгийг энэ хуульд нэлээн сайн тусгаж өгснийг хараад дэмжиж байгаа юм.

Ингээд надад хоёр асуулт байна. Энэ хуулийн төсөлд хувьцаа эзэмшигчдийн зааг ялгааг яг хуульдаа яаж тусгаж өгсөн бэ? Хуулийн төслөөс харахад Засгийн газар бүх энэ төрийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигч мэтээр оруулж ирсэн юм шиг харагдаад байна л даа. Гэтэл төрийн өмчит компанийн охин компани болон хараат бус компаниуд гэсэн ийм ойлголт Компанийн тухай хуульд байдаг.

Тэгэхээр энэ төрийн өмчит компанийн охин бөгөөд хараат компаниудын төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцааны асуудлыг энэ хууль дээр яаж тусгаж өгсөн бэ?

Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” компанийн төрийн эрх мэдэл яг хэн дээр байдаг вэ? Бидний баталсан “Бадрах Энержи” компанийн давуу эрхийн 10 хувийн хувьцаа одоо яг хувьцаа эзэмшигч нь хэн байх вэ гэдэг дээр нэг тайлбар авъя.

Хоёрт нь, төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэж маш олон үйлдвэрийн газрууд байдаг.

Тэгэхээр Улаанбаатар хотын хэмжээнд орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гээд нэлээн олон компаниуд байдаг. Харамсалтай нь жилийн эцсийн тайлангаас харахад ашиггүй ажилладаг.

Тэгэхээр энэ хуульд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэсэн ийм ойлголт байгаа юу? Яагаад ингэж асууж байна гэхээр өнөөдөр Иргэний тухай хуулиар хэрвээ ашгийн байх юм бол компани болон нөхөрлөл хэлбэртэй байна. Ашгийн бус байх юм бол төрийн бус байгууллага болон сан, хоршоо гээд ингээд нарийн заагаад өгчихсөн байдаг. Үйлдвэрийн гэсэн ойлголт, ийм үг хэллэг энэ хууль дээр байдаггүй. Яг шинэчилсэн энэ хууль дээрээ төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэдгийг Та бүхэн ямар хэлбэрээр харж энэ дээр ямар зохицуулалт өгсөн бэ? Энэ хоёр асуулт.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хуулиар түрүүн би хэлсэн. 1270 орчим аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компани, төрийн өмчийн оролцоотой аж ахуй. Энэ чинь одоо бүр уншигдаж дуусахгүй нэг ийм олон статус байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дотор чинь бүр сүүлдээ бүр учраа ч олохоо болилоо шүү дээ. Монгол Улсын Их Сургууль улсын төсөвт үйлдвэрийн газар гэдэг статустай явж байна шүү дээ.

Тэгэхээр бид энэ хуулиар ерөөсөө хоёр л зааглана. Төрийн өмчит компани. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд орон нутгийн өмчит компани.

Төр 34-өөс бага хувьцаа эзэмшихгүй. 34-өөс 100 хүртэлх хувьцааг эзэмшсэнээр төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани гэж үзнэ. Орон нутагт яг адилхан.

Харин тухайн салбарын сайд дээр ч юм уу, төсвөөс санхүүжиж байгаа байгууллага байвал одоогийн тэр улсын төсөвт үйлдвэрийн газар энэ тэр гэсэн статус бол PUBLIC INSTITUTION буюу “нийтийн үйлчилгээний байгууллага” гэдэг статустай болно. Энэ төрийн өмчит компаниас сална гэсэн үг.

Төрийн өмчит компанийн тавигдах шаардлага бол тусдаа. Ашигт ажиллагааг авч үзнэ. Ашигт ажиллагааг зөвхөн мөнгөн дүнгээр хэмжихгүй. Үйл ажиллагааны нийгэмд оруулж байгаа хувь нэмрээр. Ялангуяа үйлчилгээний салбар дээр, тэр хог ч гэдэг юм уу, ус ч гэдэг юм уу. Одоо тэгээд л цэцэрлэг, сургууль. Бусад тэр үйл ажиллагааг явуулж байгаа бол тэндээс ашиг нэхээд байхдаа биш түүнийг өөр хэлбэрээр зохион байгуулна.

Тэгэхээр ер нь энэ хууль гарснаараа “төрийн өмчит компани” ер нь ашигтай ажилладаг нь үлдээд, бусад нь тэр “нийтийн үйлчилгээний байгууллага” гэдэг ийм статустайгаар үйл ажиллагаагаа явуулна гэж ойлгож болно.

Сая ураны хөрөнгө оруулалтын гэрээ батлагдах үе буюу энэ хууль дээр нөгөө 5 үндсэн чиглэлээр компани байгуулна гэсэн шүү дээ. Жишээ нь, олон улсын гэрээгээр байгуулагдаж байгаа Оюу Толгой, эсвэл ураны гэрээ ч гэдэг юм уу. Энэ дээр олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан учраас заавал төрийн өмчийн оролцоог хангуулах хэрэгтэй. Энэ утгаараа тэр 10 хувийн ногдол ашиг хувийг нь эзэмших компани гарын үсэг зурснаараа толгой компани “Эрдэнэс Монгол” байна.

“Эрдэнэс Монгол” компани өөрөө толгой компанийн хувиар байна. Одоо энэ хуулиар Засгийн газар нөгөө хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа. Толгой компаниудын хувьцааг Засгийн газар эзэмшиж байгаа.

Гэхдээ Төрийн өмчийн хороо хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэх үү, эсвэл тухайн салбарын яам хэрэгжүүлэх үү гэдгийг тухайн үедээ Засгийн газар тогтоогоод явна. Жишээ нь, эрчим хүчний салбарын төрийн өмчтэй компаниуд, тэр улсын төсөвт үйлдвэрийн газрууд дээр Эрчим хүчний яам хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэх үү, Төрийн өмчийн хороо хэрэгжүүлэх үү гэдгийг яриад явна. Үүний бэлтгэл ажил хангуулаад “Эрчис Монгол”, “Эрдэнэс Монгол” гэсэн хоёр нэгдэл дээр чиг үүргийн давхардлыг арилгаж байгаа юм. Ингээд шийдвэрлэнэ.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Ялангуяа мега төслүүдээ хөтөлж байгаа энэ цаг үед дэлхийн шилдэг мэргэжилтнүүдийг Монголд урьж байна гэж Ерөнхий сайд хэлсэн байна лээ.

Тэгэхээр энэ төрийн өмчит компаниуд дээр, дээрээс нь нэмээд хувийн хэвшлийн энэ дээр оролцож байгаа гаднын болон Монголын хувийн хэвшлийн компани дээр ирж ажиллах байх. Тэгэхэд төрийн өмчит компаниуд засаглал муутай, захирлууд нь өөрийнхөө хувийн компанид ажиллаж байгаа юм шиг харьцах юм бол гаднаас мундаг залуучууд Монголд ирж ажиллахгүй л дээ.

Тэгээд хэдэн зүйл асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, хэд хэдэн хүмүүс сая төрийн өмчит компанийн хөрөнгө нэмэгдсэн байна. Энэ их буруу юм гэж яриад байх шиг байна. Хэрвээ нийт эдийн засаг томорсон байхад төрийн өмчит компанийн харин хөрөнгө нь нэмэгдээгүй бол тэр муу ажиллуулсан байна гэсэн үг.

Тэгэхээр эдийн засаг томорсон. Тэр дотор “төрийн өмчит компани” ч гэсэн яг ижилхэн хувиар харин томорсон байх юм бол ойлгосон. Харин эдийн засаг нь олигтой томрохгүй байхад “төрийн өмчит компани” нэмэгдээд байвал хувийн хэвшлээс хулгайлаад байна л гэсэн үг. Эдийн засгийнхаа том объёмоосоо.

Дээрээс нь “төрийн өмчит компани” улсын төсвөөс бүр зээл авдаг байсныг 2017 оноос авхуулаад ер нь үүнийг хориглосон юм.

Тэгэхээр энэ хууль дээрээ бараг үүнийг оруулж өгмөөр юм шиг байна лээ. Өөрөөр хэлбэл хавар тийшээ яг ажил эхлэх болохоор улсын төсвөөс хүүгүй зээл авчхаад намар тийшээгээ ашиг олоод буцаагаад төлчхөөд байвал хувийн хэвшил түүнтэй чинь яаж өрсөлдөх вэ.

34 хувиас бага бол төр ерөөсөө оролцоогүй байна гэж байна. Энэ их зовлонтой юм билээ. Н.Учрал сайд аа.

Одоо жишээлбэл “Монгол шуудан” гэдэг компани дээр төрийн өмчийн эзэмшил 34 орчим хувьтай байгаа. 34 хувьтай байгаа. Компани нь өөрөө хувийн хэвшлийнхэн 34 байгаа. Нөгөө компани нь байдаг юм уу, бид 34 хувийг төр өөрөө эзэмшиж байлаа гэхэд бид үлдсэн дээрээ хөрөнгө оруулалт хийе, компаниа улам сайжруулъя гэхээр төр өөрөө мөнгө оруулахгүй бол тэр компани өсөхгүй, хөгжихгүй болчхоод байдаг. Хөрөнгө оруулснаараа манай төрийн өмчийн хувь хэмжээ буурах гээд байдаг.

Тэгэхээр ийм тохиолдолд яах вэ?

Дараагийн асуудал нь. Ямар тохиолдолд “улсын үйлдвэрийн газар”, ямар тохиолдолд “төрийн өмчит компани” байгуулах юм бэ? Тэр нь 8.2-оос 8.4-ийн хооронд “төрийн өмчит компани” байгуулах шалгуур үзүүлэлтүүдийг гаргасан байна.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын 24 улсын төрийн өмчит компанийн эрх зүйн дүн шинжилгээ хийжээ. Түүн дээр энэ 24 улсаас зарим нь улс Улсын Их Хурлаараа оруулж ирж “төрийн өмчит компани” байгуулахыг шийддэг. Зарим нь Засгийн газар нь шийддэг. Зарим нь улсын төсөвт нөлөөтэй юу, эсвэл орон нутгийн төсөвт нөлөөтэй юу, үгүй юу гэдгээс шалтгаалж байж үүнийг нь шийддэг гэсэн ийм юутай байна лээ.

Тэгэхээр яг үүнтэй адилхан бид энэ орон нутгийн өмчит компаниудын асуудлуудыг ер нь яах юм бэ? Би асуух гэсэн юм. Яг төрийн өмчит компаниуд дотор 58 “төрийн өмчит компани” байгаа гэсэн. Тэд нарын охин компаниуд хэд байна вэ? Орон нутгийн өмчит компани хэд байна вэ?

“Орон нутгийн өмчит компани”, “төрийн өмчит компани” охин компаниуд дээр нийлээд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд одоогоор хэд байна вэ?

Нийтдээ 2024 оны байдлаар тэд нарын шагнал урамшуулалд хэдэн төгрөг авсан бэ?

Дараагийнх нь, 14 дүгээр зүйл дээр төрийн болон орон нутгийн өмчит компанид “хөрөнгө олж авах” гэдэг нэг бүлэг байна лээ. “Хөрөнгө олж авах” гэхээр аягүй сонин сонсогдоод байх юм. Хөрөнгө олж авах гэхээр энд тэнд явж байтал хөрөнгө нь байж байгаад олоод авчихсан юм шиг. Хөрөнгийнхөө хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг л үүгээр зохицуулж байна гэж би ойлгосон.

Гэхдээ нөгөө талдаа бид гаднын компанитай нь байдаг юм уу, хувь эзэмшээд хамтарсан компани явж байлаа гэхэд тэдний талд тал нь зарна гэхэд энэ хуулиар чинь худалдаж авах ямар ч боломжгүй тийм хуулийн зохицуулалт байна лээ. Тэгээд энэ болж байгаа юм уу, үгүй юм уу? Та бүхэн минь хараарай.

Хамгийн чухал асуудал төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдах зөвлөлийг томилох, гүйцэтгэх захирал томилох асуудал чинь маш их сулдуу хэвээрээ байгаад байна. Үүн дээр жишээлбэл эрх бүхий албан тушаалтнаас болоод өмнө нь ажиллаж байсан компани нь ашиггүй ажилласан бол дараачийн Удирдах зөвлөлд урихгүй, ажиллуулахгүй гэж байгаа юм. Түүнийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Ер нь одоо ингээд төр ч тэгээд сүүлдээ нээрээ хуушуур хайрч, хүүхдийг нь харахаас бусдыг хийж байна л даа.

Тэгээд ер нь тэгээд “даахгүй нохой булуу хураана” гэдэг шиг юм болоод байгаа юм. Яг үнэндээ.

34-өөс бага хувийг эзэмшээд байх ер нь шаардлага байхгүй ээ. Хоёр арга зам л байгаа. Энэ хуулиараа хэрвээ 34 хувиас бага хувийг төр хэрвээ эзэмшиж байх юм бол жишээ нь нээлттэй компани байвал биржээр нь зарчихна. Зарна.

Тэгэхдээ энэ зарах шийдвэрийг Их Хуралд оруулаад баримтлах чиглэлээрээ чиглэл авна. Зүгээр компани байгаа бол бусад хувьцаа эзэмшигч нартаа мэдээж нэгдүгээрт санал болгоно шүү дээ. Тэгээд бусад хувьцаа эзэмшигч нартаа төр өөрийнхөө эзэмшиж байгаа бага хэмжээний хувьцааг санал болгоно.

Гэхдээ энэ асуудлыг Засгийн газар “төрийн өмчит компани” дээр баримтлах чиглэлтэйгээ хамтатгаад оруулж ирээд Их Хурлаас чиглэл аваад шийдүүлнэ. Үүнийг энэ хууль батлагдсаны дараа баримтлах чиглэл дээр Та бүхэнд танилцуулна гэж бодож байна. Төлөвлөж байна. Төр зайлшгүй хувьцааг эзэмшээд явах компани дээр хувь нийлүүлээд 34 хувиа бариад явахаас өөр арга жишээ нь байдаггүй. Тийм ээ.

Дээрээс нь яах вэ нэгэнт Баялгийн сангийн хууль гарсан. Үүнтэй холбогдуулаад төр эзэмшлийнхээ тэр 34 хувиа юугаар орлуулж, яаж хүртэх вэ гэдгээ Их Хурлаар шийдээгүй байгаа тохиолдолд заавал 34 хувийг нь уул уурхайн салбарт эзэмших л ёстой. Энэ Баялгийн сангийн хуулиараа зохицуулагдаад явна гэж ойлгож болно.

Одоогийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүнээр харьцуулаад үзвэл төрийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд нийлээд л 24.7 хувийг эзэлж байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүний. Үлдсэн 71 хувь дээр хувийн хэвшил байгаа. Ингээд хамгийн сүүлийн статистикийн мэдээллээр сая бол Төрийн өмчийн хороонд тайлан илгээдэг 122. Үүнээс гадна “төрийн өмчит үйлдвэрийн газар”, “төрийн өмчит компани”, тэгээд “орон нутгийн өмчит компани”, “үйлдвэрийн газар” гээд орон нутаг, төрөөр ангилаад үзэхээр Төрийн өмчийн хороон дээр орон нутгийн өмчтэй нийлбэл 513, улсын бүртгэл дээр авагдсан нийт мэдээллээр 1273.

Хамгийн сүүлд **E-Balance** дээр санхүүгийн тайланг энэ 1273-ын 508 хуулийн этгээд л илгээсэн байгаа. Тэгэхээр 50 хувь нь ямар ч идэвхгүй гэсэн үг байхгүй юу. Худлаа нэг ийм тоо байна шүү дээ. Тэгээд төрийн өмчит компанийн тоо нэмэгдчихсэн юм шиг харагдаад байдаг. Тэгээд ямар ч үр ашиггүй ингээд ажиллаад байдаг.

Зүгээр гүйцэтгэх захирал болоод төлөөлөн удирдах зөвлөлийн шалгуур их өндөр болсон. Энэ маш их өндөр болсон. Төлөөлөн удирдах зөвлөл хараат бус, хараат, төрөөс томилогдох хувьцаа эзэмших талаас томилогдох ч бай үүн дээр нээлттэй сонгон шалгаруулалт тавина. Тус шалгууруудыг заавал давахыг шаардаж байгаа.

Дээрээс нь өөрийнхөө төлөвлөгөөг оруулж байж төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулж байна.

Дээрээс нь гүйцэтгэх захирал жил жилээр сунгагдах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Сангийн яаман дээр энэ төрийн өмчит компаниудын зарим аудитуудыг хийгээд, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын газар луу явуулдаг байсан.

Сүүлийн бараг 20 жил ТУЗ-д сууж байгаа хүмүүс байна. Ажилласан компани болгон дампуурсан. Ерөөсөө ашиггүй ажиллаж байсан. Тэр хүний буруугаас болж энэ компани дампуурсан ч гэдэг юм уу, ашиггүй ажилласан гэж нотлоход их хэцүү.

Тэгэхээр яг энэ хуулийн чинь 24.1.5 дээр аливаа хэлбэрээр энэ хүнээс шалтгаалаагүй нь нотлогдсон гээд байгаа байхгүй юу. Гэтэл энэ чинь хамтын шийдвэр байгаад байдаг.

Дээрээс нь нэмээд нийт 9 удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг нь “төрийн захиргааны албан хаагчид байна” гэхээр яах вэ төрийн захиргааны албан хаагчдыг муу гэж байгаа юм биш. Тэгэхдээ ихэнх манай төрийн захиргааны албан хаагчид оюутны ширээнээс шууд төрийн захиргааны ажилд нухлагдаж байсан хүмүүс. Тэд нар хувийн хэвшлийн өдөржин шөнөжин компаниа яаж ашигтай ажиллуулах вэ гэдэг хүмүүстэй яг адилгүй.

Тэгэхээр бид энэ шалгуур үзүүлэлт дээрээ, нэг бодлын би төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хар жагсаалт гаргаас гэж боддог байхгүй юу. Хар жагсаалт гаргаасай. Та зөндөө олон ТУЗ-д суусан. Таны ажилласан компани.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлага хууль дээр тусгагдаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд ч гэсэн гэрээ сунгаад л явна. Одоо тийм юм байдаггүй байхгүй юу. Тэгээд л ойлгомжгүй. Юу хийж байгаа нь ч ойлгомжгүй. Ингээд байгаад байна шүү дээ.

Тэгэхдээ төлөөлөн удирдах зөвлөлийг цөөлж болдгийг “Эрдэнэс Монгол” дээр 269-өөс 66 руу буулгахад харуулсан шиг “Эрчис Монгол” дээр буюу уул уурхайн бус нэгдэл дээр бид төлөөлөн удирдах зөвлөлийг маш цомхон болгох бололцоо байгаа.

Тэгэхдээ төлөөлөн удирдах зөвлөл байх ёстой. Бид үүнийг зөв ойлгох ёстой. Төлөөлөн удирдах зөвлөл байж хараат бус үйл ажиллагаа, төлөөлөн удирдах зөвлөл байж төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд 2 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой 3 дотоод аудит ажиллаад, хөндлөнгийн аудит хийдэг.

Энэ яг компанийн засаглал гэдэг зүйлийг барихгүй бол. Төлөөлөн удирдах зөвлөл заавал байх ёстой. Төлөөлөн удирдах зөвлөл тэгэхдээ хараат бус байх ёстой гэдэг ийм л зарчмыг илүү барьж байгаа.

Тэгээд ер нь яг таны хэлдэг үнэн. Захирлууд ч гэсэн замаа алдсан шүү дээ. Юу билээ. Байшин баривал инженер гэдэг шиг нөгөө бүх л юмыг хийдэг ийм супер захирлууд хүртэл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя. Сүүлийн хүн асуулт асууж байгаа. Гишүүд танхим цуглая. Санал хураалт явагдана.

Б.Батбаатар: Энэ төрийн өмчит компаниуд орон нутгийн өмчит, төрийн өмчит гээд ингээд ялгаад компаниуд байлгаад байдаг.

Энэ компаниудаа ер нь цөөлөөд хувьчлахыг нь хувьчлаад, зарахыг нь зарах хэрэгтэй шүү дээ. Нээлттэй компаниуд болгох хэрэгтэй шүү дээ. Хувьцаат компаниуд болоод хөрөнгийн биржээр шударга арилжаагаар үнэ ханш нь тогтоод.

Тэгэхгүй ингээд энэ төрийн өмчит компаниуд ашиггүй ажиллаж байна гээд байх юм. Ашигтайг нь авч үлдэнэ. Ашиггүйг нь татан буулгана гэж яриад байгаа юм.

Яг үнэндээ ашиггүй ажиллаж байгаа компаниуд чинь бизнес эрхэлж байгаа Монголын иргэдийнхээ тэр зах зээл дээр ашиг олж амьдрах, амьдрал ахуйгаа сайжруулах, эргэн тойрноо сайжруулах, нэмээд хэлбэл улс орноо хөгжүүлэх тэр замыг нь хааж байгаа шүү дээ.

Ер нь Засгийн газар ашгийн төлөө иргэдтэйгээ өрсөлддөг байж болох юм уу? Энэ суурь концепцоо яаж харах юм? Иргэдтэйгээ ашгаар өрсөлддөг, ашгийн ашиг олох гэж Засгийн газар, төр нь өрсөлддөг ийм байхаар чинь иргэд маань нэг бол төрийн албан хаагч, нэг төрийн өмчит компанид ажилд орё л гэдэг юм ярьж байгаа шүү дээ.

Дээрээс нь, одоо хаа байсан Америкт хүртэл монголчууд хөрөнгө оруулалт хийгээд л компаниуд байгуулаад гарч эхэлж байна. Европ руу, Америк руу, бусад тив рүү.

Монголд бизнес хийх сонирхол алга байна шүү дээ. 42 их наядын мөнгөний нийлүүлэлттэй. Түүний 35 их наяд нь төрөөс хамаарч байна шүү дээ. Үлдсэн 7 их наяд нь тэгээд Монголбанкны үнэт цаас, Засгийн газрын бонд эд нар луу ороод.

Тэгэхээр эрх мэдэлтнийг дагасан ийм эдийн засгийн орчинтой болгоход наад төрийн өмчит компаниуд олноор байгаа чинь буруу. Иргэдтэйгээ ашгийн төлөө өрсөлддөг Засгийн газар байж болохгүй ээ. Ашигтайг нь ч гэсэн хувьчлах хэрэгтэй. Нээлттэй, шударгаар.

Их Хурлын гишүүд зарим нь хардаж асуугаад байна. Төрийн өмчийг хувьчлах гээд. Төрийн өмч гэдэг чинь ард түмний л өмч шүү дээ. Энэ ард түмэн өөрсдөө өмчтэй, бизнестэй ашиг олдог байх нь энэ улс оронд л хэрэгтэй шүү дээ. Нэг ийм байдал үүсээд байгаа юм.

Дээрээс нь тархины гоожилт гээд улс орны хамгийн шилдэг сайн хүмүүс гадаад руу гараад байна гэж ярьдаг. Үүнээс гадна өнөөдөр Монгол ажиллах хүчний хомсдолтой болчихсон. Гадаадад 300 мянга орчим монголчууд ажиллаж,

амьдарч байна гээд байдаг. Дахиад виз нь гарахад явахад бэлэн дахиад тэр хэмжээний хүмүүс байж байна шүү дээ.

Дөнгөж саяхан нэг хуулийн төсөл өргөн бариад л байсан. Ажиллах хүчнийг чөлөөтэй, нээлттэй оруулъя гэдэг баахан хэл ам татлаад л. Яагаад тийм болж байгаа юм. Төр энд ашгийн төлөө бизнес хийгээд төрийн эрх мэдэлд очсон улс төрийн нам төрийн өмчийг хувийн өмч мэт ашиглаад байгаа учраас монголчууд Монголдоо бизнес хийж амьдарч чадахгүй болоод гадагшаагаа яваад байгаа. Монголоосоо гарч гадаадад амьдаръя гэж байна.

Улс орны хүн ам зүйн бодлого талаасаа ч харсан өнөөдөр Монголд байгаа гадагшаа гарчихсан идэр насны залуучуудаас гадна Монголд үлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа, насны харьцаа, баялаг бүтээгч нь хэд байгаа юм. Баялгаас хувь өртөг чинь хэд байгаа юм.

Ийм олон сул талууд байсаар байхад төрийн өмчийг бэхжүүлэх тухай яриад байх юм. Төрийн өмчтэй болох тухай яриад байх юм. Энэ төрийн өмчийн олон компаниудаа хэзээ үгүй болгох юм. Ашгаа иргэд нь авч байг л дээ. Төр татвараа л авна биз.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Б.Батбаатар дарга би яг энэ төрийн өмчийн олон компаниудыг цэгцэлье, нэгтгэе, нийлүүлэе, нээлттэй болгоё, хувийн оролцоог хангуулъя, зарим чиг үүргийг аутсорсингоор хувийн хэвшилд өгье гэдэг зорилгоор л энэ хуулийг оруулж ирээд яриад байгаа юм.

Тийм учраас түрүүн Ерөнхий сайд танилцуулга дээрээ хэлсэн. Төрийн өмчийн хороонд тайлангаа ирүүлж байгаа 122 компанийг хууль батлагдсанаар баримтлах чиглэлтэйгээ хамт бид охин компанитай нийлүүлээд 70 болгоно. 56 толгой компанийг үлдээнэ.

Уул уурхайн бус компанийн “Эрчис Монгол” нэгдэл дээр дотор нь 4-хөн салбарт хуваана.

Ингээд 34-өөс бага хувь хэрвээ төр эзэмшиж байвал бүгдийг нь эхний байдлаар нээлттэй компани биржээр арилжаална, 34-өөс бага хувийг төр эзэмшиж байвал нөгөө хувьцаа эзэмшигчид нь шууд санал болгож худалдах бодлого чиглэлийг Их Хуралд танилцуулж, чиглэл авснаар энэ ажлуудыг Засгийн газар хийнэ гэж байгаа юм. Энэ хийгдэх ажил.

Тэгэхээр төр энэ бизнесийн олон салбаруудад хошуу нэмэрлэдгээ одоо больё. Тэгэхгүй бол алдагдалтай ажилласан ч авч байгаа цалин адилхан хувийн төрийн өмчит компаниудтай болчихлоо. Наад төрийн өмчит компанийн зарим захирлууд чинь компаниа ашигтай ажиллуулъя биш, өөрийг нь жоохон

шүүмжлэхээр аавдаа ховлож байгаа хүүхэд шиг хэн нэгэнд очиж ховлоод тэр хүн нь утас цохих юм. Энэ үнэхээр зовлон.

Тэгэхээр үүнийгээ шийдэж авъя гэдэг зорилгоор энэ хууль орж ирж байгаа юм.

Дээрээс нь бид төр цаашдаа энэ 5 чиглэлээс өөр салбарт ямар ч “төрийн өмчит компани” байгуулах боломжгүй болно.

Орон нутгийн түвшинд нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт, нөгөө эмнэлэг, сургуулийн л түвшинд. Үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт зайлшгүй үйл ажиллагаа тохиолдолд төр оролцоно.

Энэ юу юм бэ гэхээр жишээ нь экспортын 80, 90 хувийг бүрдүүлж байгаа нүүрс, Эрдэнэс Тавантолгой ч гэдэг юм уу, Эрдэнэт үйлдвэр ч гэдэг юм уу, МИАТ ч гэдэг юм уу. Мэдээлэл холбооны сүлжээ. Нөгөө үндсэн сүлжээгээ хариуцаж байгаа компани ч гэдэг юм уу. Тийм ээ. “Улаанбаатар төмөр зам” ч гэдэг юм уу.

Дөрөвт, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нөгөө батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих.

Нөгөө батлан хамгаалах, цэргийн оёдлын үйлдвэр, нууц үйлдвэр. Жишээ нь, гадаад улстай янз бүрийн үйлдвэр хамтарч байгуулах гэрээ хэлцэл хийгдсэн бол.

Тавд, хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу буюу Оюу Толгойн гэрээ шиг хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан бол. Саяын “Бадрах Энержи”-гийн гэрээ батлагдсан бол төр оролцоно.

Бусад тохиолдолд төр ямар ч компани байгуулахыг хуулиар хориглоно. Ингээд бусад тохиолдолд хэрвээ дэргэдээ И-Монгол академи шиг нэг ийм аппликэйшн гаргаад ингээд төрийн үйлчилгээ үзүүлэх гэж байвал энэ компани биш. Ашиг олох зорилгогүй. Зарим чиг үүргээ хувийн хэвшлээр хийлгэ. Хариуцах ажлаа өөрсдөө хий. Төсвөөс цалингаа тэр 10, 20 хувь нь авч болно. Түүнээс компани биш.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлэг, бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлэхээр байгаа. Дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлнэ.

Нэг гишүүний нэр ирсэн байна. Чинбаатарын Анар индэр дээрээс үг хэлнэ. 1 дүгээр индэр дээр очъё.

Ч.Анар: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би Улсын Их Хурлын гишүүн болоод удаагүй байна. Монгол Улсын Хууль, эрх зүйн орчин бүрэлдэн тогтоод шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш 30 жил өнгөрч байна.

Гэхдээ одоо энэ “төрийн өмчит компани”, “төрийн өмчит улсын үйлдвэрийн газар”. Энэ хамгийн том завхрал болсон суурь асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Н.Учрал сайд оруулж ирж байгаад нь маш их талархалтай хандаж байна.

Гэхдээ энэ одоо орж ирж байгаа хуулийн үзэл баримтлал зарчмын хувьд үндсэн суурь асуудлыг ерөөсөө шийдэхээр хууль биш байна.

Улс юу хийх ёстой юм, төр юу хийх ёстой юм, юу хийх ёсгүй юм, төрийн өмчит компани, төрийн өмчит улсын үйлдвэрээ ч тоолж чадахгүй хэмжээндээ очтолоо завхрал үүсчихсэн.

1995 онд баталсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд шилжилтийн хуулийн зохицуулалттай. Хэзээ дуусах нь тодорхойгүй. Дуусгах сонирхол үе үеийн Засгийн газарт нь байдаггүй.

Тэгэхээр анх удаа энэ Засгийн газар үүнийг хөндөж орж ирж байгааг нь би дэмжиж байна.

Гэхдээ энэ хуулийг сууриар нь, бүр цаашаагаа Өмчийн тухай хууль, цаашлаад бүр олон улсын жишигт Үндсэн хууль дээрээ хүртэл төр ямар үйлчилгээг хийх ёстой, хийх ёсгүйг нь ангилж оруулж ирдэг.

Одоо бол энэ төрийн өмчит компаниудын засаглал, төрийн өмчит хувьцаат компани, төрийн өмчит улсын үйлдвэр, аж ахуйн тооцоо, улсын төсөв бүгдээрээ хуулийн зохицуулалтгүй цоорхойгоор явж ирсэн. Үе үеийн улс төрчдийн, үе үеийн Засгийн газрынхны ашиг сонирхлыг шингээж, байр суурийг нь хадгалдаг улс төрийн үйл ажиллагааны том субъект болчихсон байна.

Тэгэхээр энэ хуулийг Н.Учрал сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хуулийг оруулж ирж байгаа ажлын хэсэгт миний санал болгох нь энэ хуулиа сууриар нь нухацтайгаар авч хэлэлцэж оруулж ирэх хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол бид нар өнөөдөр “бүтээмжийг дээшлүүлнэ”, “засаглалыг сайжруулна” гээд суурь асуудлаа шийдэхгүй дахиад нэг ийм үргэлжилсэн, энэ

асуудлыг хөндсөн нэртэй хууль л болж өнгөрөх гэж байна гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Тэгэхээр Их Хурлын гишүүд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, магадгүй Засгийн газар нь Их Хуралтайгаа хамтраад энэ суурь асуудлыг нэлээн нухацтайгаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Ирц санал хураалт явуулахад хангалттай гэж үзэж байна. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61 гишүүн буюу 62.9 хувиар санал дэмжигдлээ.

Сангийн сайд Болдын Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жадамбаагийн Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл, Доржзовдын Энхтуяа нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна.

2.Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

60.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

58.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

64.9 хувиар дэмжигдлээ.

5. Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар дэмжигдлээ.

6. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

67.0 хувиар санал дэмжигдлээ.

7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар санал дэмжигдлээ.

8. Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар санал дэмжигдлээ.

9. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар санал дэмжигдлээ.

10. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.0 хувиар санал дэмжигдлээ.

11. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.1 хувиар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.0 хувиар санал дэмжигдлээ.

13.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.0 хувиар санал дэмжигдлээ.

14.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.0 хувиар санал дэмжигдлээ.

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

66.0 хувиар санал дэмжигдлээ.

16.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.0 хувиар санал дэмжигдлээ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааа. Санал хураалт. /алх цохив/

68.0 хувиар санал дэмжигдлээ.

18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.1 хувиар санал дэмжигдлээ.

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.1 хувиар санал дэмжигдлээ.

20.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

71.1 хувиар санал дэмжигдлээ.

21.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.1 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөж байна.

Маргааш өглөө 10.00 цагт чуулганы хуралдаан эхэлнэ. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 56 минут үргэлжилж, 17 цаг 11 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД